



ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ
2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИК АГЫН ТӨВ

ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, СУУРЬШИЛ



1
БОЛОВСРОЛ,
БИЧИГ ҮСГИЙН
МЭДЛЭГ



3
ӨНДЭР
НАСТАН



4
ӨРХ-ГЭР
БҮЛИЙН БАЙДАЛ,
ГЭРЛЭЛТ



5
Хөгжлийн
бэрхшээлтэй
иргэд



6
ЖЕНДЕРИЙН
ТЭГШ БАЙДАЛ



7
ОРОН СУУЦНЫ
АХУЙН НӨХЦӨЛ




8
ИНТЕРНЕТ,
ГАР УТАСНЫ
ХЭРЭГЛЭЭ



9
ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУД



10
ЭДИЙН ЗАСЛИЙН
ИДЭВХ



11 ХҮН АМЫН ТОО
ХҮН АМЫН
ХЭТИЙН ТООЦОО
2010-2040



12
МЯНГАНЫ
ХӨГЖЛИЙН
ЗӨРИЛГҮЙН
ЗӨРИЛГҮЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО

ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, СУУРЬШИЛ

Улаанбаатар хот
2011 он


DDC
307.2'021'517
Ш-634

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр
<http://www.nso.mn>
И-мэйл: nso@magicnet.mn

Сэдэвчилсэн судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж
боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

Энэхүү судалгаа нь англи хэл дээр хэвлэгдэж, хэрэглэгчдийн хүртээл болно.

 **BCI** "BCI" Хэвлэлийн компани
Утас: 319032

ISBN 978-99929-64-70-7

АГУУЛГА

Судалгаа бичихэд оролцогчид.....	iv
Хүснэгтийн жагсаалт.....	v
Зургийн жагсаалт.....	viii
Хавсралт хүснэгтийн жагсаалт.....	ix
Товчилсон үгийн тайлбар	x
Өмнөх үг.....	1
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.	
Шилжих хөдөлгөөн: судалгааны зорилго, ойлголт, тодорхойлолт, хууль эрх зүйн үндэс, товч түүх	3
ХОЁРДУГААР БҮЛЭГ.	
Шилжих хөдөлгөөний урсгал, дүр зураг	11
ГУРАВДУГААР БҮЛЭГ.	
Хотжилт	27
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.	
Нэг жилд шилжин ирэгчдийн нас, хүйс, боловсрол, гэр бүлийн байдал	33
ТАВДУГААР БҮЛЭГ.	
Нэг жилд шилжин ирэгчдийн эдийн засгийн идэвх, ажилгүйдэл, ажил эрхлээгүй шалтгаан	51
ЗУРГААДУГААР БҮЛЭГ.	
Нэг жилд шилжин ирэгчдийн ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хөдөлмөр эрхлэлтийн байдал.....	59
ДОЛООДУГААР БҮЛЭГ.	
Нэг жилд шилжин ирсэн өрхийн сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр, цахилгаан, халаалт, усан хангамж	79
Дүгнэлт, зөвлөмж.....	99
Ном зүй	106
Хавсралт	107



СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД

НЭГ. СУДАЛГААГ БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН

Дашцэрэнгийн Ариунаа

Эдийн засагч-Статистикч-Хүн ам зүйч

Судлаач

ХОЁР. ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН

Цэнджавын Бадрах

Эдийн засагч

ҮСХ-ны MNG4P103 төслийн зөвлөх

Жигжидсүрэнгийн Ядамсүрэн

Санхүү-Эдийн засагч

Эдийн засгийн ухааны доктор, профессор

ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

Бямбацогтын Уранбилэг

Эдийн засагч-Хүн ам зүйч

ҮСХ-ны Хүн ам, орон сууцны тооллогын товчооны шинжээч

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1	Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо, төрсөн газар болон тоолох үед байнга оршин сууж байсан бүс нутгаар, 2010 он... 13
Хүснэгт 2.2	Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнд оролцогчид, төрсөн болон тоолох үед байнга оршин сууж байсан бүс нутаг, хувиар, 2010 он .. 14
Хүснэгт 2.3	Төрснөөс хойших шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэл, хүйс, хувиар, 2010 он 16
Хүснэгт 2.4	Тав, түүнээс дээш настай хүн амын тоо, 2005 оны 1 дүгээр сар болон тоолох үед байнга сууж байсан бүс нутгаар, 2010 он..... 18
Хүснэгт 2.5	Тав, түүнээс дээш настай хүн амын тоо, 2005 оны 1 дүгээр сар болон тоолох үед байнга сууж байсан бүс нутаг, хувиар, 2010 он 19
Хүснэгт 2.6	Тав, түүнээс дээш насны хүн амын сүүлчийн таван жилийн шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэл, хүйс, хувиар, 2010 он.....20
Хүснэгт 2.7	Хүн амын тоо, жилийн өмнө болон тоолох үед байнга оршин сууж байсан бүс нутгаар, 2010 он22
Хүснэгт 2.8	Хүн амын тоо жилийн өмнө болон тоолох үед байнга сууж байсан бүс нутаг, хувиар, 2010 он22
Хүснэгт 2.9	Нэг жилийн шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэл, хүйс, хувиар, 2010 он24
Хүснэгт 3.1	Монгол Улсын хотын хүн ам, бүс нутаг, аймаг, нийслэлээр 2000, 2010 оны тооллогоор.....29
Хүснэгт 4.1	Суурин хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2010 он.....34
Хүснэгт 4.2	Улаанбаатар хотын суурин хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2010 он.....35
Хүснэгт 4.3	Өмнөговь аймгийн суурин хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2010 он.....36
Хүснэгт 4.4	Дорноговь аймгийн суурин хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2010 он.....37
Хүснэгт 4.5	Арван тав, түүнээс дээш насны боловсролгүй хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, бичиг үсгийн мэдлэг, хүйсээр, 2010 он38
Хүснэгт 4.6	Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны боловсролгүй хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, бичиг үсгийн мэдлэг, хүйсээр, 2010 он38
Хүснэгт 4.7	Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны боловсролгүй хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, бичиг үсгийн мэдлэг, хүйсээр, 2010 он39
Хүснэгт 4.8	Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны боловсролгүй хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, бичиг үсгийн мэдлэг, хүйсээр, 2010 он39
Хүснэгт 4.9	Арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр, 2010 он41
Хүснэгт 4.10	Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр, 2010 он.....42
Хүснэгт 4.11	Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр, 2010 он.....44
Хүснэгт 4.12	Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр, 2010 он.....45



Хүснэгт 4.13	Арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, гэр бүлийн байдал, хүйсээр, 2010 он	46
Хүснэгт 4.14	Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, гэр бүлийн байдал, хүйсээр, 2010 он	47
Хүснэгт 4.15	Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, гэр бүлийн байдал, хүйсээр, 2010 он	48
Хүснэгт 4.16	Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, гэр бүлийн байдал, хүйсээр, 2010 он	49
Хүснэгт 5.1	Арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн идэвх, хүйсээр, 2010 он	52
Хүснэгт 5.2	Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн идэвх, хүйсээр, 2010 он.....	53
Хүснэгт 5.3	Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн идэвх, хүйсээр, 2010 он.....	53
Хүснэгт 5.4	Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн идэвх, хүйсээр, 2010 он.....	54
Хүснэгт 5.5	Арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил эрхлээгүй шалтгаан, хүйсээр, 2010 он	55
Хүснэгт 5.6	Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил эрхлээгүй шалтгаан, хүйсээр, 2010 он	56
Хүснэгт 5.7	Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил эрхлээгүй шалтгаан, хүйсээр, 2010 он	57
Хүснэгт 5.8	Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил эрхлээгүй шалтгаан, хүйсээр, 2010 он	58
Хүснэгт 6.1	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил мэргэжил, хүйсээр, 2010 он	60
Хүснэгт 6.2	Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил мэргэжил, хүйсээр, 2010 он	61
Хүснэгт 6.3	Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил мэргэжил, хүйсээр, 2010 он	62
Хүснэгт 6.4	Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил мэргэжил, хүйсээр, 2010 он	63
Хүснэгт 6.5	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, 2010 он ...	65
Хүснэгт 6.6	Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, 2010 он	68
Хүснэгт 6.7	Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, 2010 он	70
Хүснэгт 6.8	Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, 2010 он	72

Хүснэгт 6.9	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, 2010 он	74
Хүснэгт 6.10	Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, 2010 он	75
Хүснэгт 6.11	Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, 2010 он	76
Хүснэгт 6.12	Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, 2010 он	77
Хүснэгт 7.1	Нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, сууцны төрөл, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	80
Хүснэгт 7.2	Улаанбаатар хотод нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, сууцны төрөл, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	81
Хүснэгт 7.3	Өмнөговь аймагт нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, сууцны төрөл, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	82
Хүснэгт 7.4	Дорноговь аймагт нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, сууцны төрөл, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	83
Хүснэгт 7.5	Нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	84
Хүснэгт 7.6	Улаанбаатар хотод нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он.....	85
Хүснэгт 7.7	Өмнөговь аймагт нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он.....	85
Хүснэгт 7.8	Дорноговь аймагт нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он.....	86
Хүснэгт 7.9	Нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	87
Хүснэгт 7.10	Улаанбаатар хотод нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	88
Хүснэгт 7.11	Өмнөговь аймагт нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	89
Хүснэгт 7.12	Дорноговь аймагт нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	90
Хүснэгт 7.13	Нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, халаалтын эх үүсвэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	91
Хүснэгт 7.14	Улаанбаатар хотод нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, халаалтын эх үүсвэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	92
Хүснэгт 7.15	Өмнөговь аймагт нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, халаалтын эх үүсвэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	92
Хүснэгт 7.16	Дорноговь аймагт нэг жилд шилжин ирсэн өрхийн тоо, халаалтын эх үүсвэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он	93
Хүснэгт 7.17	Нэг жилд шилжин ирсэн байшинд амьдардаг өрхийн тоо, усан хангамж, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он.....	94



Хүснэгт 7.18	Улаанбаатар хотод нэг жилд шилжин ирсэн байшинд амьдардаг өрхийн тоо, усан хангамж, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он.....	95
Хүснэгт 7.19	Өмнөговь аймагт нэг жилд шилжин ирсэн байшинд амьдардаг өрхийн тоо, усан хангамж, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он.....	96
Хүснэгт 7.20	Дорноговь аймагт нэг жилд шилжин ирсэн байшинд амьдардаг өрхийн тоо, усан хангамж, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он.....	97

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.2	Сүүлчийн таван жилийн дотоод шилжих хөдөлгөөн, 2010 он	5
Зураг 1.1	Төрснөөс хойших дотоод шилжих хөдөлгөөн, 2010 он.....	5
Зураг 1.3.	Сүүлчийн нэг жилийн дотоод шилжих хөдөлгөөн, 2010 он	6
Зураг 2.1	Түлхэх болон татах хүчин зүйлс.....	8
Зураг 2.1	Шилжигчдийн тоо, хугацаа, нутаг дэвсгэрээр, 2010 он.....	12
Зураг 2.2	Тав, түүнээс дээш насны хүн амаас Улаанбаатар хотод сүүлийн 5 жилд шилжин ирэгчид, бүс нутгаар, 2010 он (шилжин ирсэн болон явсан хүний зөрүүгээр, мян.хүн).....	17
Зураг 3.1	Нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувь, тооллого явагдсан онуудаар	28
Зураг 3.2	Монгол Улсын нийт хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувь, тооллого явагдсан онуудаар.....	30
Зураг 4.1	Арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр, 2010 он	40
Зураг 4.2	Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр, 2010 он.....	42
Зураг 4.3	Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр, 2010 он.....	43
Зураг 4.4	Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр, 2010 он.....	45

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1	Суурин хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2010 он.....	108
Хүснэгт 1.2	Улаанбаатар хотын суурин хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2010 он.....	108
Хүснэгт 1.3	Өмнөговь аймгийн суурин хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр, 2010 он.....	109
Хүснэгт 2.1	Арван тав, түүнээс дээш насны боловсролгүй хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, бичиг үсгийн мэдлэг, хүйсээр, 2010 он.....	109
Хүснэгт 2.1	Арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, боловсролын төвшин, хүйсээр, 2010 он.....	110
Хүснэгт 3.	Арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, гэр бүлийн байдал, хүйсээр.....	111
Хүснэгт 4.1	Арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн идэвх, хүйсээр, 2010 он.....	112
Хүснэгт 4.2	Арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил эрхлээгүй шалтгаан, хүйсээр, 2010 он.....	113
Хүснэгт 4.3	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил мэргэжил, хүйсээр, 2010 он.....	114
Хүснэгт 4.4.1	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, 2010 он.....	115
Хүснэгт 4.4.2	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, 2010 он.....	116
Хүснэгт 4.4.3	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, 2010 он.....	117
Хүснэгт 5	Арван тав, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амд сүүлчийн 5 жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, 2010 он.....	118
Хүснэгт 6.1	Сүүлчийн 5 жилд шилжин ирсэн өрх, сууцны төрөл, нөхцөл, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он.....	119
Хүснэгт 6.2	Сүүлчийн 5 жилд шилжин ирсэн өрх, сууцны төрөл, нөхцөл, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он.....	120
Хүснэгт 6.3	Сүүлчийн 5 жилд шилжин ирсэн өрх, сууцны төрөл, нөхцөл, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, 2010 он.....	121

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБ-ын ХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан
ҮСХ	Үндэсний статитикийн хороо
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ЭСЯ	Элчин сайдын яам
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
БНКаЗУ	Бүгд Найрамдах Казакстан Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ГИХАЭГ	Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар
МҮОНТ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
МУИС	Монгол Улсын Их Сургууль
УБИС	Улсын багшийн их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан техникийн их сургууль
ЭМШУИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
ХААИС	Хөдөө аж ахуй их сургууль
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
ХАОСТТ	Хүн ам, орон сууцны тооллогын товчоо
ГМС	Газарзүй мэдээллийн систем
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

ӨМНӨХ ҮГ



Монгол Улс хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг 2010 онд амжилттай зохион байгуулсан. Энэхүү тооллогын үр дүнд үндэслэн нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн олон үзүүлэлтийг улс, аймаг, нийслэл, бүс нутгаар тодорхойлсон. Тооллогын үр дүнг үндэслэн сэдэвчилсэн судалгаануудыг хийж олон нийтийн хүртээл болгож, байгаагийн нэг нь “Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөн, суурьшил” юм.

Энэхүү сэдэвчилсэн 2 дахь удаагийн судалгаа нь сүүлчийн 10 гаруй жилийн хугацаанд шилжих хөдөлгөөний хандлага, чиглэл ямар байгааг харуулав. Өмнөх тооллогын үр дүн ялангуяа, 1989 оны тооллогын үр дүнгээс гарсан боломжит бүх мэдээллийг ашиглан эмхтгэл хийж байсан бол 2000 оны тооллогын дүнд үндэслэн “Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт” гэсэн сэдэвчилсэн судалгаа хийсэн байдаг.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиснээс хойш буюу 1990 оноос хойш шилжих хөдөлгөөн улам бүр нэмэгдэж байна. Шилжих хөдөлгөөнийг судлах нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох ялагуяа, хүн амын байршил, суурьшил, шилжих хөдөлгөөний талаар баримтлах бодлого, хөтөлбөр боловсруулахад чухал ач холбогдолтой суурь мэдээлэл болох юм.

Хүн амын дотоод шилжих хөдөлгөөнийг тодорхой цаг, хугацаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үздэг бөгөөд энэ удаагийн сэдэвчилсэн судалгаанд сүүлчийн нэг жилийн хүн амын шилжих хөдөлгөөнийг илүү түлхүү харуулсан болно.


Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнд үндэслэн Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөний өнөөгийн байдлыг тодорхойлсон энэхүү сэдэвчилсэн судалгаа нь тооллогын үр дүнг хэрэглэгчдэд үнэтэй мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ ТООЛЛОГЫН
УЛСЫН КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА

 С.МЭНДСАЙХАН

НЭГЛҮГЭЭР БҮЛЭГ

**ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН: СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ОЙЛГОЛТ,
ТОДОРХОЙЛОЛТ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭС, ТОВЧ ТҮҮХ**



1.1 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Шилжих хөдөлгөөн нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүн амын тоо, бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтөд голлон нөлөөлдөг хүчин зүйл юм. Сүүлийн 20 гаруй жилд хүн амын дотоод, гадаад шилжих хөдөлгөөн эрчимжиж, аймаг, нийслэл, бүс нутгийн хүн амын тоо, бүтцэд ихээхэн өөрчлөлт гарсан төдийгүй нийгэм, эдийн засгийн хөгжилд хүчтэй нөлөөлж байгааг улс, аймаг, нийслэл, бүс нутгийн хэмжээнд нарийвчлан судлахад судалгааны гол зорилго оршино. Ингэхдээ шилжих хөдөлгөөнийг үе шатуудаар нарийвчлан судалж, хүн амын суурьшлын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар төр, засгийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх бодлогын зөвлөмж, саналыг тусгахыг зорилоо.

1.2 ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Шилжих хөдөлгөөнийг тодорхой цаг хугацаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үздэг. Байнга оршин сууж байсан газраасаа (буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс (аймаг, нийслэл) өөр газар руу шилжсэн, шилжиж ирсэн газартаа б, түүнээс дээш сарын хугацаагаар суурьшин амьдарч байгаа хүн амыг шилжих хөдөлгөөнд оролцсон гэж үзнэ. Шилжих хөдөлгөөний урсгал, шилжин суурьшсан хугацааг тооллогын товын үед байнга оршин сууж байсан газраасаа шилжиж ирсэн хүн бүрээс оршин суугаа хугацаа, өмнө нь байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг асууж гаргасан.

2010 оны тооллогоор шилжих хөдөлгөөн буюу шилжигчдийг тодорхойлохдоо тооллогын товын үед:

- төрсөн нутгаасаа өөр газар амьдарч байгаа;
- таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газраасаа өөр газарт шилжиж ирсэн (Үүнд 5 жил 11 сарын хөдөлгөөнийг хамруулав.);
- нэг жилийн өмнө байнга оршин сууж байсан газраасаа өөр газарт шилжиж ирсэн (Энд 11 сарын хөдөлгөөнийг хамруулав.) гэсэн гурван үндсэн хугацаагаар авсан.

Шилжих хөдөлгөөнийг тухайн хүн дээрх хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан хамгийн сүүлд шилжсэн нутаг дэвсгэрийн байдлаар, нутаг дэвсгэрийг байнга оршин сууж байсан аймгаас нийслэлд эсвэл өөр аймагт, нийслэлээс аймагт шилжсэн байдлаар тодорхойлов. Шилжигчдийг тодорхойлох эхний арга нь төрсөн газрын асуулт дээр үндэслэсэн байв (Зураг 1.1).

Төрсөн аймаг, нийслэлдээ тооллогын товын үед байнга оршин сууж байсан хүн амыг “Төрснөөсөө хойш сууж байгаа” буюу амьдралынхаа туршид оршин суугаа газраа өөрчлөөгүй гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, амьдралынхаа аль нэг хугацаанд өөр хэдэн газар амьдарч байсныг үл харгалзан төрсөн газраа тооллогын товын үед байнга оршин сууж байсан гэсэн шалгуурыг гол болгож үзсэн. Харин тооллогын товын үед төрсөн аймаг, нийслэлээсээ өөр газар байнга оршин сууж байгаа хүмүүсийг “Төрснөөсөө хойш шилжигчид” гэж үзэв. Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийг хугацаа үл харгалзан тухайн хүний төрсөн болон тоолох үед байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийг үндэслэв. Тиймээс тоолох үед тухайн нутаг дэвсгэрээс өөр газар төрсөн бүх хүнийг шилжин ирээд байнга амьдарч байгаа хугацааг үл харгалзан шилжин ирэгчид гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, тухайн хүн төрснөөсөө хойш 2010 оны 11 дүгээр сар буюу тоолох үе хүртэлх хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан зөвхөн сүүлчийнхийг хамруулж байгаа болно. Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний үндсэн агуулга нь аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа хүн амын хэдэн хувь нь уугуул нутагтаа амьдарч байгааг илэрхийлэхэд оршино. Энэхүү мэдээллийг ашиглахад дутагдалтай тал нь шилжих хөдөлгөөнд оролцсон хугацаа тодорхой бус байдаг явдал юм.

ЗУРАГ 1.1 ТӨРСНӨӨС ХОЙШИХ ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2010 ОН



Шилжих хөдөлгөөнийг судлах хоёр дахь арга нь тогтсон цаг хугацааг хэрэглэж, өөрөөр хэлбэл, яг таван жилийн өмнө байнга оршин сууж байсан газрыг асуусан. Сүүлчийн таван жилийн шилжих хөдөлгөөнийг тоолуулагч 2005 оноос өмнө болон хойших хугацаанд хэдэн удаа шилжсэнийг үл харгалзан, товын үед болон товоос таван жилийн өмнө байнга сууж байсан газраар тооцоолсон болно. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор 5 жилийн шилжих хөдөлгөөнийг 2005 оны 1 дүгээр сард байнга сууж байсан аймаг, нийслэлээр авсан. Анхаарах асуудал нь 2000 оны тооллогын тов 1 дүгээр сарын 4-өөс 5-нд шилжих шөнө байсан бол 2010 оных 11 дүгээр сарын 10-аас 11-нд шилжих шөнө байсан гэдгийг судлаачид харгалзаж үзэх нь зүйтэй. Тав хүртэлх насны хүүхэд тооллого явуулахаас таван жилийн өмнө төрөөгүй байсан тул зөвхөн тав, түүнээс дээш насны хүнээс асуусан.

ЗУРАГ 1.2 СҮҮЛЧИЙН ТАВАН ЖИЛИЙН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2010 ОН



Шилжих хөдөлгөөнийг хэмжих гурав дахь арга нь байнга оршин сууж байгаа хугацааг үндэслэсэн байв. Тооллогын үед байнга оршин сууж байсан аймаг, нийслэлд шилжиж ирсэн хүн нэг бүрээс байнга оршин сууж байгаа хугацаа, урьд нь байнга оршин сууж байсан аймаг, нийслэлийн нэрийг асуусан. Сүүлчийн нэг жилд (буюу 2009 онд) нийтдээ 114 022 хүн шилжих хөдөлгөөнд орсон байна (Зураг 1.3). Гэхдээ шилжих хөдөлгөөнийг өөр өөр цаг хугацаа, оноор нарийвчлан судлах боломж тооллогын баримтад байгааг тэмдэглэе.

ЗУРАГ 1.3. СҮҮЛЧИЙН НЭГ ЖИЛИЙН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, 2010 ОН



Дээрх аргууд дээр үндэслэн нийт хүн амыг шилжих хөдөлгөөнд оролцсон байдлаар дараах бүлэгт хувааж болно. Үүнд:

- Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнд ороогүй, орсон
- Сүүлчийн таван жилд шилжих хөдөлгөөнд ороогүй, орсон
- Сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд ороогүй, орсон

Энэ судалгаанд шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийг, ороогүй хүмүүстэй харьцуулж судална.

Шилжигчдийг судлахдаа сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийг дараах шалтгаанаар сонгосон. Үүнд:

- Богино хугацааг сонгосноор шилжих хөдөлгөөний ихэнх нь давхардахгүйгээр судалгаанд хамрагдаж, олон удаагийн шилжих хөдөлгөөний нөлөөг багасгана.
- Шилжин ирсэн хүн тухайн нутагтаа удаан амьдрах тутам тэдний орон сууц, боловсрол, ажил эрхлэлт зэрэгт анх ирсэн үеийнхтэй харьцуулахад өөрчлөгддөг нөлөөллийг багасгах
- Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний үр дүнг 2000 оныхтой харьцуулах боломжтой.

Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөнийг улсын хэмжээнд тооцож судлахын зэрэгцээ Улаанбаатар хот, Өмнөговь, Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийг онцгойлон үзэв. Улсын хэмжээний шилжих хөдөлгөөн Улаанбаатар хот руу чиглэсэн байна. 2010 онд Өмнөговь аймаг шилжин ирэгчдийн эзлэх хувь Улаанбаатар хотоос илүү байна. 2010 онд Дорноговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөн бусад аймгаас өндөр биш байгаа ч гэсэн тэнд бий болох бүтээн байгуулалттай холбоотойгоор шилжих хөдөлгөөн өрнөх магадлалтай тул уг аймгийг энэ судалгаанд сонгов. Харин зах зээлд шилжснээс хойш

шилжин ирэгчид ихтэй байгаа Төв, Хангайн бүсийн аймгийн шилжих хөдөлгөөнийг аймгийн төвшний судалгаагаар нарийвчлан гаргах нь зүйтэй гэж үзэв.

1.3 МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

Монгол Улсад хүн амын дотоод шилжих хөдөлгөөний асуудлыг дараах хууль тогтоомжоор зохицуулдаг¹. Үүнд:

1. Монгол Улсын хууль
 - Монгол Улсын Үндсэн хууль. 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр;
 - Иргэний бүртгэлийн тухай хууль. 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр;
 - Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр;
 - Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль. 1994 оны 7 дугаар сарын 5-ны өдөр;
 - Иргэний хууль хууль. 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр;
 - Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль. 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр;
2. Монгол Улсын Засгийн Газрын тогтоол:
 - Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам. 2002 оны 214 дүгээр тогтоол;
3. Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол:
 - Нийслэл хотод шилжин суурьших, түр оршин суух, нийслэлээс шилжин явах түр журам. 1995 оны 69 дүгээр тогтоолоор баталсан, 2000 оны 46 дугаар, 2001 оны 8 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.

1.4 МОНГОЛ УЛСЫН ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮҮХЭЭС ТОВЧ

Монгол Улсын ард иргэд 1921 оны хувьсгалаас өмнө малаа дагаж, хаваржих, зусах, намаржих, өвөлжих газраа сэлгэн нүүдэллэж ирсэн. Энэ нь орчин цагийн шилжих хөдөлгөөн биш юм. Аймаг, хошуу дамжин нүүх нүүдэл харьцангуй бага, уламжлалт мал аж ахуйгаа эрхлэн уугуул нутагтаа амьдардаг байжээ.

1990 оноос өмнөх 70 жилд хөнгөн аж үйлдвэр, газар тариалангийн салбарыг шинээр үүсгэн хөгжүүлж эхэлснээр түүнийг дагасан шилжих хөдөлгөөн, жишээлбэл, “илгээлтийн эзэн” уриан хүрээнд өрнөж байсан. Бүх нийтэд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг үнэгүй хангах зорилгоор эмч, багш нарыг олноор бэлтгэн, улс орны өнцөг булан бүрт тухайлвал, говийн бүсэд нэмэгдэл цалинтай илгээж, хөдөлмөрлөх хүчийг төлөвлөж, төрийн зохицуулалттай шилжих хөдөлгөөн хийж байсан. Түүнчлэн, нэгдэлжих хөдөлгөөн, төмөр замын бүтээн байгуулалт, Эрдэнэт, Дархан хотын бүтээн байгуулалттай холбоотой шилжих хөдөлгөөн явагдсан².

1990 оноос хойш хүн амын шилжих хөдөлгөөн чөлөөтэй болсон. Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт иргэд “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэсэн заалт нь шилжих хөдөлгөөнд сайн дураараа чөлөөтэй оролцох эрх зүйн боломжийг бүрдүүлсэн.

¹ <http://www.legalinfo.mn/pages/1/page1.php.infor> веб хуудас

² Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн талаарх баримтыг Төмөрийн Намжимийн 2000 онд бичсэн “Монгол улсын эдийн засаг: гурван үед” гэсэн номноос харна уу.

2000 оны тооллогоос үзэхэд шилжих хөдөлгөөний үндсэн хоёр урсгал үүссэн:

1. Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал;
2. Төвийн бүс рүү чиглэсэн урсгал;

Энэ хоёр урсгалаар Монгол Улсын хүн ам төвийн бүсдээ бөөгнөрч, зах хязгаар нутаг эзгүйрэх хандлага гарч ирсэн. Цаашид шилжих хөдөлгөөн багасахгүй, харин ч нэмэгдэх хандлагатай байна.


1.5 ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ОНОЛООС

Шилжих хөдөлгөөнийг судалдаг эдийн засгийн хөгжлийн загвар, шилжих хөдөлгөөний хүчин зүйлс, “хэмжээлшгүй том хот”-ын онол зэрэг хэд хэдэн онолын урсгал байдаг.

Луис (Lewis)- ийн онол нь 1954 онд анх гарсан бөгөөд эдийн засгийн хоёр салбартай хөгжлийн онол гэж алдаршсан байдаг. Энэ онолоор хөгжиж буй улс орныг уламжлалт хөдөө аж ахуй, орчин үеийн аж үйлдвэр гэсэн үндсэн хоёр салбартай гэж үздэг. Уламжлалт хөдөө аж ахуйн салбарыг бүтээмж муутай, орлого багатай, санхүүгийн хуримтлал үүсгэх боломж муу, бүрэн бус ажил эрхлэлттэй гэж төсөөлдөг. Харин аж үйлдвэрийн салбарыг технологийн хувьд харьцангуй дэвшилттэй, хөрөнгө оруулах боломж өндөр, хот суурин газрын салбар гэж төсөөлдөг. Хот суурин газраа төрийн эсвэл хувийн өмчийн ялгаагүй аж үйлдвэр эрхэлдэг аж ахуйн газар нь уламжлалт хөдөө аж ахуйн салбараас илүү өндөр бөгөөд баталгаатай цалин өгнө. Эдийн засгийн систем нь ийм хоёр салбартай байхад хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн явагдана гэж Луис үзсэн. Луисийн (Lewis 1954) загвараар бол шилжих хөдөлгөөний урсгал нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой юм. Хөгжиж байгаа улс орны шилжих хөдөлгөөнийг тайлбарладаг эдийн засгийн өөр нэг загвар бол Харрис болон Тодарогийн (Harris and Todaro 1970) загвар юм. Харрис, Тодаро хөгжиж буй улс оронд ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлтийн төвшин өндөр байдаг тул хөдөөгөөс хот руу шилжихэд шууд ажил олох магадлал өндөр биш байдаг гэж үздэг.

Шилжих хөдөлгөөний онолын бас нэг урсгал нь шилжих хөдөлгөөний хүчин зүйлс юм. Ихэнх тохиолдолд “гэрэлтэй хот”, “өндөр цалин, орлого” зэрэг хүчин зүйлд татагдан хүмүүс шилжих хөдөлгөөнд ордог гэж үзэж байсан. Гэтэл Ли (Lee 1956) анх удаа татах хүчээс гадна түлхэх хүч байдаг гэж үзсэн. Түүнээс хойш түлхэх, татах хүчин зүйлсийн онол гарсан байдаг (Зураг 2.1).

ЗУРАГ 2.1 ТҮЛХЭХ БОЛОН ТАТАХ ХҮЧИН ЗҮЙЛС



Хүн ам, орон сууцны тооллогоор шилжихэд нөлөөлөх хүчин зүйлсийг асуух боломжгүй ч гэсэн шилжих хөдөлгөөнд оролцсон хүмүүсийн заримд үндэслэн таамаглал дэвшүүлж болно.

Ихэнх улс оронд хүмүүс тодорхой хүчин зүйлсийн нөлөөллөөр шилжих хөдөлгөөнд ордог. Жишээлбэл, Энэтхэгт залуу эрэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх гэж харин Филиппин улсын залуу эмэгтэйчүүд гадаадад гэрийн үйлчлэгчээр ажиллахаар шилжих хөдөлгөөнд орох нь бусад улс орныхоос илүү байдаг. Өөрөөр хэлбэл ямар бүлгийн хүмүүс илүү шилжих хөдөлгөөнд орж байгааг судалснаар ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг таамаглаж болно. Монгол Улсын хувьд хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнд малчид зонхилж байвал үүнийг мал аж ахуйн салбарт ган зуд зэрэг байгалийн гамшгаас болж хүндрэлтэй байдал үүссэнтэй холбоотой гэж таамаглаж болно. Ийм нөхцөлд мал аж ахуйн салбарын хөгжилд анхаарах, бэлчээрийн асуудлыг зөв зохистой шийдвэрлэх зэрэг арга хэмжээг төр засгаас авбал шилжих хөдөлгөөнийг багасгахад тодорхой нөлөө үзүүлнэ.

Шилжих хөдөлгөөний онолын өөр нэг урсгал бол “хэмжээлшгүй том хот”-ын онол юм. Газар зүйч Мак Жефферсон (Jefferson 1939) анх удаа хэмжээлшгүй том хотын онолыг бий болгосон. Аливаа хот бусад хотоос харьцангуй том болбол цаашид “хэмжээлшгүй том хот” болж хөгждөг. “Хэмжээлшгүй том хот” гэдэг нь бусдаасаа хүн амын тооны хувьд ядаж хоёр дахин том байдаг. “Хэмжээлшгүй том хот” нь ихэнхи тохиолдолд аливаа улсын нийслэл байдаг. Жишээлбэл, Парис 9.6 сая хүн амтай байхад түүний дараагийн хот Марселлис 1.3 сая хүн амтай, Лондон 7 сая хүн амтай байхад хоёр дахь хот болох Бирмингем нэг сая хүн амтай, Банконг 7.5 сая хүн амтай байхад хоёр дахь хот нь 481 мянган хүн амтай байна. Гэтэл хүн ам олонтой зарим улс оронд “хэмжээлшгүй том хот” байдаггүй. Энэтхэгт хамгийн том хот Мумбай (Бомбэй) 16 сая хүн амтай байхад хоёр дахь том хот Калькута 13 сая хүн амтай, гурав дахь нь 13 сая орчим хүн амтай байдаг. Хятад, Канад, Австрали, Бразил зэрэг улс оронд “хэмжээлшгүй том хот” байдаггүй. Хөгжиж буй улс орны хувьд “хэмжээлшгүй том хот” нь үйлдвэржсэн хот биш ч гэсэн хүн амын тоо, дотоод зах зээл, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг үзүүлэлтээрээ хүмүүсийг татдаг.

1.6 ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ СУДЛАХЫН АЧ ХОЛБОГДОЛ

Монгол Улсад 1990-2000 оны үеийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан төрөлт, гэрлэлт буурч байсан бол сүүлчийн үед төрөлт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Хүн ам зүйн үзэгдэл дотроос шилжих хөдөлгөөнийг дээр дурьдсанаар эдийн засгийн загвараар тайлбарладаг тул эдийн засгийн хөгжилтэй шууд холбоотой байдаг. Эдийн засгийн шинэ салбар бий болоход ажилгүйчүүдээс гадна ажил хийж байгаа хүмүүс шинэ салбар руу орох урсгал бий болно. Монгол Улсад Оюу толгой, Таван толгойн төслөөс шалтгаалан уул уурхайн салбар руу чиглэсэн урсгал бий болж байна. Үүнийг 2010 оны тооллогоос судлах боломжтой.

Шилжих хөдөлгөөний урсгал нь тухайн орны эдийн засгийн хөгжлийн төвшин, эдийн засгийн бүтцээс шалтгаалан байнга өөрчлөгдөж байдаг. Гэхдээ шилжих хөдөлгөөн их байна гэдэг нь улс орон хөгжиж байна гэсэн үг биш юм. Хэрэв тодорхой салбар шинээр бий болж, тэнд хүмүүс шилжин очиж баталгаатай ажлын байраар хангагдаж байвал эдийн засгийн хөгжлөөс шалтгаалан хүн ард шилжин суурьшиж байна гэж ойлгож болно. Харин эрхэлсэн ажилгүй, олсон орлогогүй хүмүүс тогтвортой амьдрах газраа олж ядан хэсүүчлэн явж байвал энэ нь эдийн засгийн хөгжилтэй холбоотой шилжих хөдөлгөөн гэж ойлгож болохгүй. Шилжигчдийн шинж төрхийг судалснаар тухайн хүн эдийн засгийн хөгжлийн үр шимийг хүртэж чадсан уу эсвэл үгүй юу гэдгийг таамаглаж болно.

Товч дүгнэхэд шилжих хөдөлгөөн нь эдийн засгийн хөгжил, ядуурал, амьжиргаанаас үүдэлтэй тул шилжих хөдөлгөөнийг бууруулах арга хэмжээ нь өөрөө эдийн засгийн хөгжлийн арга хэмжээ байдаг. Тиймээс шилжих хөдөлгөөнийг судлах нь эдийн засгийн өсөлтийг хангахтай дүйцэхүйц чухал асуудал юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ


ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛ, ДҮР ЗУРАГ



2.1 ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР

Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөн сүүлчийн 10 жилд улам бүр эрчимжсэн байна. Сүүлчийн нэг жилд бүс нутаг хооронд нийтдээ 101.2 мянган хүн шилжих хөдөлгөөнд орсон нь 2000 оныхоос 1.6 дахин нэмэгдсэн байна (Зураг 3.1). Төрснөөс хойш аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч 1097.6 мянган хүн байгаа нь суурин хүн амын 41.5 хувь болж, 2000 оныхоос 2 дахин (2000 онд 20.7 хувь) өсчээ. Төрснөөс хойш аймаг, нийслэл хооронд шилжигчдийн 28.9 хувь 2005 оноос хойш, 10.4 хувь сүүлчийн нэг жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд оролцжээ.

ЗУРАГ 2.1 ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2010 ОН



Бүс нутаг хоорондын шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнөөс 10.3 хувиар бага байгаа нь олон хүн шилжин ирж, суурьших болсон Улаанбаатар хот дангаараа нэг бүсийг төлөөлж, нөгөө талаар бүс нутаг доторх ялангуяа, төвийн бүсийн аймаг хоорондын шилжих хөдөлгөөн харьцангуй их байгаатай холбоотой.

2.2 ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, БҮС НУТАГ, АЙМГААР

2.2.1 УЛААНБААТАР ХОТ РУУ ЧИГЛЭСЭН УРСГАЛ

2010 оны хүн амын тооллогын дүнгээр төрснөөс хойших шилжих хөдөлгөөний урсгалыг бүс нутгаар³ судлахад шилжих хөдөлгөөний урсгалын ерөнхий дүр төрх 2000 оны тооллогын дүнтэй төстэй байна. Хамгийн том урсгал нь баруун бүс нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн бөгөөд энэ урсгалд нийтдээ 176 734 хүн орсон байна (Хүснэгт 3.1). Хамгийн бага урсгал нь зүүн бүс нутгаас баруун бүс нутаг руу явсан бөгөөд энэ урсгалд 376 хүн орсон байна.

³ Улсын Их хурлаас баталсан “Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” 2003 он.

Бүсүүдэд хамаарах аймаг, нийслэлийн нэр:

- Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг;
- Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймаг;
- Төвийн бүсэд: Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймаг;
- Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг;
- Улаанбаатарын бүсэд: Нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотуудыг хамруулдаг.

ХҮСНЭГТ 2.1 ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ТОО,
ТӨРСӨН ГАЗАР БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН
БҮС НУТГААР, 2010 ОН

Төрсөн газар	Хүн амын тоо	Тоолох үед байнга оршин сууж байсан газар					Шилжин явсан
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
БҮГД	2 647 545	352 537	514 726	440 693	185 299	1 154 290	-
Баруун	595 596	344 993	24 889	48 194	2 472	175 048	250 603
Хангай	680 933	1 951	464 447	35 728	2 073	176 734	216 486
Төв	481 974	1 402	10 181	315 203	3 350	151 838	166 771
Зүүн	256 881	376	2 069	9 308	172 001	73 127	84 880
Улаанбаатар	610 646	3 287	12 002	26 958	4 508	563 891	46 755
Гадаад ¹	21 515	528	1 138	5 302	895	13 652	21 515
Шилжин ирсэн	-	7 544	50 279	125 490	13 298	590 399	787 010

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Хэдүйгээр шилжих хөдөлгөөний урсгал чиг хэвээр хадгалагдаж байгаа боловч үүний дотор Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал улам бүр нэмэгдэж, эрчимжсэн байна. Төрсөн нутагтаа 2010 оны тооллогын үед байнга оршин суугаа хүний эзлэх хувь Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 92.3 хувь төрснөөс хойш амьдарч байна (Хүснэгт 3.2). Үүнийг 2000 оны тооллогын үр дүнтэй⁴ харьцуулахад ойролцоо байна. Улаанбаатар хотод төрсөн хүмүүс Төвийн (4.4%) болон Хангайн (2.0%) бүс рүү шилжиж суурьших нь Баруун (0.5%) болон Зүүн (0.7%) бүс рүү шилжихээс илүү байна. Энэ нь 2000 оны тооллоготой төстэй байна.

Улаанбаатар хотоос бусад бүс нутгийн хувьд төрснөөсөө хойш уугуул нутагтаа амьдарч байгаа хүн амын эзлэх хувь 2000 оны тооллоготой харьцуулахад огцом буюу 13-16 пунктээр буурч, бүс нутгаас гадагшаа урссан төрснөөс хойших шилжих хөдөлгөөний урсгал ийм хэмжээгээр нэмэгдсэн байна. Бүс нутгийн төрснөөс хойших шилжих хөдөлгөөн Зүүн бүсийн хувьд хамгийн их нэмэгдсэн байна. 2000 оны тооллогоор Зүүн бүс нутагт төрсөн хүний 83.2 хувь төрснөөсөө хойш амьдарч байсан бол 2010 онд 67.0 хувь болж 16.2 пунктээр буурчээ. Зүүн бүсийн дараа Баруун (15.8%) болон Төвийн (15.8%) бүс орж, харин Хангайн (13.4%) бүсийн төрснөөс хойших шилжих хөдөлгөөн бусдаас бага нэмэгдсэн байна. Эдгээрээс үзэхэд төрсөн нутгаас гадагшаа шилжих хөдөлгөөн Зүүн бүс нутагт хамгийн өндөр нь байна.

⁴ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 15, Хүснэгт 2.4

ХҮСНЭГТ 2.2 ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧИД, ТӨРСӨН БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН БҮС НУТАГ, ХУВИАР, 2010 ОН

Төрсөн газар	Бүгд	Тоолох үед байнга оршин сууж байсан газар				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
БҮГД	100.0	13.3	19.4	16.6	7.0	43.6
Баруун	100.0	57.9	4.2	8.1	0.4	29.4
Хангай	100.0	0.3	68.2	5.2	0.3	26.0
Төв	100.0	0.3	2.1	65.4	0.7	31.5
Зүүн	100.0	0.1	0.8	3.6	67.0	28.5
Улаанбаатар	100.0	0.5	2.0	4.4	0.7	92.3
Гадаад ¹	100.0	2.5	5.3	24.6	4.2	63.5
ДҮН	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	22.5	97.9	4.8	10.9	1.3	15.2
Хангай	25.7	0.6	90.2	8.1	1.1	15.3
Төв	18.2	0.4	2.0	71.5	1.8	13.2
Зүүн	9.7	0.1	0.4	2.1	92.8	6.3
Улаанбаатар	23.1	0.9	2.3	6.1	2.4	48.9
Гадаад ¹	0.8	0.1	0.2	1.2	0.5	1.2

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Улаанбаатар хотын дараа төрснөөс хойших шилжих хөдөлгөөн хамгийн бага газар нь 2000 оны тооллогын үр дүнгээр Зүүн бүс байсан бол 2010 оны энэ тооллогоор Хангайн бүс (68.2%) болсон байна.

Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн 2000-2010 оны хооронд хэвээр хадгалагдаж, Баруун (29.4%) болон Төвийн (31.5%) бүс нутгаас ирэх урсгал хамгийн их байгаа ч бүх бүс нутгаас ирэх урсгалын хэмжээ ойролцоогоор хоёр дахин нэмэгдсэн байна.

Төвийн бүсэд шилжин ирэгчид Баруун бүсээс (8.1%) хамгийн их, харин Хангай (5.2%) болон Зүүн (3.6%) бүсээс харьцангуй бага шилжиж ирсэн байна. Мөн Хангайн бүсэд шилжин ирэгчид Баруун бүсээс (4.2%) хамгийн их ирсэн байна. Төв болон Хангайн бүс нутгаас хүмүүс ихэвчлэн Улаанбаатар хот руу шилжихээс гадна, эдгээр бүс нутагт Баруун болон Зүүн бүс нутгаас хүмүүс ирж суурьшиж байна. Төв болон Хангайн бүс нутаг нь Баруун болон Зүүн бүс нутгаас шилжигчдийн хувьд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалын “дамжих цэг” болж байна.

Хүснэгт 3.2-ийн хоёр дахь хэсэгт 2010 оны тооллогод хамрагдсан хүн амын төрсөн газрыг тоолох үед байнга оршин суугаа газрын эзлэх хувиар харуулав. Улаанбаатар хотод тоологдсон нийт хүн амын талаас илүү нь (51.1%) Улаанбаатар хотод төрөөгүй, харин Монгол улсын бусад өнцөг буланд төрсөн байна. Улаанбаатар хотод төрөөд, тэндээ амьдарч байгаа хүний эзлэх хувь 2000 онд 64.6 хувь байсан бол 2010 онд 48.9 хувь болж буурсан байна. Өөрөөр хэлбэл, 2000 онд Улаанбаатар хотод амьдарч байгаа гурван хүний нэг нь шилжин ирэгч байсан бол 2010 онд хоёр хүний нэг нь шилжин ирэгч болжээ.

2000 онд Монгол улсын нийт хүн амын 22.2 хувь Улаанбаатар хотод төрж, харин 32.0 хувь нь тоолох үед Улаанбаатар хотод амьдарч байсан бол 2010 онд нийт хүн амын 23.1 хувь Улаанбаатар хотод төрж, 43.6 хувь тоолох үед амьдарч байна. Энэ нь Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал оршин суугчдад яаж нөлөөлснийг харуулж байна.

Улаанбаатар хот руу чиглэсэн урсгалаас гадна Монгол улсад шилжих хөдөлгөөн улс орон даяар 2010 онд 2000 онтой харьцуулахад ерөнхийдөө нэмэгдсэн байна. Бусад бүх бүс

нутгийн хувьд төрсөн газартаа төрснөөс хойш амьдарч байгаа хүний эзлэх хувь 2010 онд 2000 онтой харьцуулахад буурсан байна. Баруун бүс нутагт төрөөд тэндээ амьдарч байгаа хүний эзлэх хувь 2000 онд 99.1 хувь байсан бол 2010 онд 97.9 хувь болж 1.2 пунктээр буурчээ. Энэ үзүүлэлт Хангайн бүс нутагт 2.6 пунктээр, Төвийн бүс нутагт 5.7 пунктээр, Зүүн бүс нутагт 1.7 пунктээр буурчээ.

Улаанбаатар хот руу Монгол улсын өнцөг булан бүрээс чиглэсэн урсгал нь 2000-2010 оны тооллогын хооронд хэвээр үлдсэн хэдүй ч урсгалын хэмжээ бараг хоёр дахин нэмэгдсэн байна. Төв болон Хангайн бүс нутаг Улаанбаатар руу чиглэсэн шилжих хөдөлгөөнд оролцохоос гадна Баруун болон Зүүн бүс нутгаас хүмүүс ирж байгаа тул зөвхөн “илгээх” биш харин “хүлээж авах” газар болж, Улаанбаатар хот руу чиглэсэн “дамжих цэг” болж байна. 2000 оны тооллогоор төрснөөс хойших гадагшаа шилжих хөдөлгөөн хамгийн бага бүс нутаг нь Зүүн бүс байсан бол 2010 онд Хангайн бүс болж өөрчлөгдсөн байна. 2000-2010 оны хооронд Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөнөөс гадна Монгол улсад шилжих хөдөлгөөн ерөнхийдөө нэмэгдсэн байна.

2.2.2 ӨМНӨГОВЬ АЙМАГ РУУ ЧИГЛЭСЭН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ШИНЭ УРСГАЛ ГАРСАН НЬ

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөний байдлыг аймгаар авч үзэхэд шинэ чиглэл, урсгал гарсан нь харагдаж байна. Хүснэгт 3.3-т төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийг аймаг, нийслэл, хүйс, хувиар харуулав.

Монгол Улсад нийт хүн амын гуравны нэг нь төрсөн газраасаа өөр газарт амьдарч байна. Улаанбаатар хотод байнга оршин суудаг хүн амын тал нь (51.1%) өөр аймагт төрж, Улаанбаатар хот руу шилжиж ирсэн байна. Гэхдээ төрснөөс хойш шилжин ирэгчдийн эзлэх хувь Орхон аймгийн хувьд (68.4%) хамгийн өндөр байна. Үүний дараа Говь-Сүмбэр (59.6%), Дархан-Уул (58.4%), Сэлэнгэ (41.2%), Төв (32.8%) аймаг орж, улсын дунджаас дээгүүр байна. Эдгээр аймаг руу шилжигчдийг хүйсээр ангилан үзэхэд эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс илүү давамгайлж байна.

2010 оны төрснөөс хойш шилжин ирэгчдийн эзлэх хувийг 2000 оныхтой⁵ харьцуулахад Улаанбаатар хот (15.7 пункт), Дархан-Уул (5.6 пункт), Сэлэнгэ (6.1 пункт), Төв (5.4 пункт) аймагт өөр газар төрсөн хүмүүс шилжиж ирэх нь улам бүр нэмэгдэж, шилжигчдийг хамгийн их татаж байна. Харин Орхон (-1.5) Говьсүмбэр (-3.9) аймагт шилжин ирэгчид буурсан байна.

⁵ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 17, Хүснэгт 2.5

ХҮСНЭГТ 2.3 ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Суурин хүн ам			Үүнээс:								
				Төрснөөс хойш сууж байгаа хүн ам			Шилжин ирсэн хүн ам			Шилжин явсан хүн ам		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	2 647 545	1 313 968	1 333 577	1 549 952	749 246	800 706	877 562	422 076	455 486	877 562	422 076	455 486
Архангай	84 078	41 943	42 135	66 145	30 594	35 551	5 633	2 236	3 397	62 745	29 412	33 333
Баян-Өлгий	85 232	42 655	42 577	71 693	34 406	37 287	1 782	806	976	14 400	6 801	7 599
Баянхонгор	75 690	38 023	37 667	57 058	25 153	31 905	2 452	1 176	1 276	44 128	21 149	22 979
Булган	53 065	27 325	25 740	33 386	16 071	17 315	10 928	5 408	5 520	35 716	16 547	19 169
Говь-Алтай	53 223	26 602	26 621	38 630	17 520	21 110	3 401	1 590	1 811	51 622	24 707	26 915
Дорноговь	57 930	29 230	28 700	34 491	16 130	18 361	15 594	8 022	7 572	20 017	9 315	10 702
Дорнод	68 873	34 796	34 077	57 346	28 573	28 773	9 142	4 563	4 579	31 617	14 709	16 908
Дундговь	38 543	19 578	18 965	28 833	12 927	15 906	2 198	1 163	1 035	32 853	15 863	16 990
Завхан	64 924	32 544	32 380	50 759	23 273	27 486	2 868	1 267	1 601	76 683	36 972	39 711
Өвөрхангай	100 444	50 333	50 111	78 409	36 517	41 892	5 821	2 741	3 080	53 337	25 272	28 065
Өмнөговь	60 855	34 884	25 971	36 209	17 372	18 837	14 512	11 430	3 082	15 264	7 185	8 079
Сүхбаатар	51 091	26 059	25 032	36 131	16 844	19 287	2 928	1 506	1 422	30 208	14 045	16 163
Сэлэнгэ	95 804	48 756	47 048	49 326	25 873	23 453	39 461	19 618	19 843	40 710	19 040	21 670
Төв	83 838	43 751	40 087	47 468	24 266	23 202	27 532	14 146	13 386	63 624	29 649	33 975
Увс	72 906	36 829	36 077	53 783	24 182	29 601	1 800	862	938	66 597	32 201	34 396
Ховд	76 252	38 006	38 246	60 750	28 797	31 953	4 773	2 015	2 758	48 381	23 043	25 338
Хөвсгөл	114 331	56 899	57 432	95 965	45 999	49 966	4 622	2 216	2 406	46 217	21 491	24 726
Хэнтий	65 335	33 399	31 936	41 851	19 419	22 432	11 430	5 816	5 614	33 257	15 402	17 855
Дархан-Уул	90 642	44 556	46 086	35 990	18 569	17 421	52 943	25 017	27 926	25 863	12 529	13 334
Улаанбаатар	1 154 290	558 247	596 043	544 813	270 768	274 045	590 399	277 924	312 475	46 755	24 215	22 540
Орхон	87 118	42 813	44 305	26 090	13 509	12 581	59 549	28 535	31 014	13 069	6 252	6 817
Говьсүмбэр	13 081	6 740	6 341	4 826	2 484	2 342	7 794	4 019	3 775	2 984	1 458	1 526
Гадаадад	-	-	-	-	-	-	-	-	-	21 515	14 819	6 696

Мөн төрснөөс хойших шилжих хөдөлгөөн харьцангуй өндөр аймагт Булган (20.6%), Өмнөговь (23.8%), Дорноговь (26.9%) аймгууд орж байна. Улмаар 2000 онтой харьцуулахад Булган (6.5 пункт), Дорноговь (6.9 пункт) аймагт шилжих хөдөлгөөн харьцангуй бага нэмэгдсэн байхад Өмнөговь аймагт (18.8 пунктээр) их нэмэгдсэн байна. Булган, Дорноговь аймаг урд өмнө шилжигчдийг татдаг газар байсан бол Өмнөговь аймаг шинээр гарч ирсэн байна. Энэ нь уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотой юм.

Зүүн бүсийн Хэнтий (17.5%), Дорнод (13.3%) аймагт төрснөөс хойших шилжих хөдөлгөөн Төвийн бүсийн аймагтай харьцуулахад бага байгаа ч Баруун бүсийн аймагтай харьцуулахад өндөр байна. Түүнчлэн 2000 онтой харьцуулахад Хэнтий (4.3 пункт), Дорнод (3.5 пункт) аймагт төрснөөс хойших шилжих хөдөлгөөн бага ч гэсэн нэмэгдсэн нь эдгээр аймаг шилжигчдийг бага ч гэсэн татдаг хэвээрээ байгаа нь харагдаж байна.

Хөвсгөл, Завхан, Дундговь, Сүхбаатар, Өвөрхангай, Ховд, Говь-Алтай аймагт төрснөөс хойш шилжин ирэгчдийн эзлэх хувь 4.0-6.7 хооронд хэлбэлзэж байна. Эдгээр аймаг дотроос Архангай, Говь-Алтай аймгийн төрснөөс хойших шилжих хөдөлгөөн 2000 онтой харьцуулахад илүү өссөн байна.

Баян-Өлгий (2.1%), Баянхонгор (3.2%), Увс (2.5%) аймагт төрснөөс хойших шилжих хөдөлгөөн хамгийн бага байна.

Төрснөөс хойших шилжих хөдөлгөөнийг 2000 оныхтой харьцуулахад Орхон, Говь-Сүмбэрээс бусад бүх аймаг, нийслэлд өсчээ. Улаанбаатар хот шилжигчдийг хамгийн их татдаг газар хэвээрээ байна. Түүнчлэн Орхон, Дархан-Уул, Говь-Сүмбэр, Сэлэнгэ, Төв аймаг руу шилжигчид нэмэгдсээр байна. Эдгээр аймгаас гадна 2010 онд Дорноговь, Өмнөговь

аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал шинээр нэмэгджээ. Ялангуяа, Өмнөговь руу чиглэсэн урсгал нь сүүлчийн 10 жилд гарсан шинэ урсгал байна. Үүнээс гадна Дорноговь, Өмнөговь руу чиглэсэн урсгалд эрэгтэйчүүд давамгайлж байхад бусад аймаг, нийслэл рүү чиглэсэн урсгалд эмэгтэйчүүд давамгайлж байна.

2.3 ТАВАН ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, БҮС НУТАГ, АЙМГААР

2.3.1 ХАНГАЙН БҮС НУТГААС - УЛААНБААТАР ХОТ РУУ ЧИГЛЭСЭН УРСГАЛ ХОЁР ДАХИН НЭМЭГДСЭН НЬ

Таван жилийн шилжих хөдөлгөөн төрснөөс хойших шилжих хөдөлгөөнтэй харьцуулахад харьцангуй сүүлчийн үеийн дүр зургийг харуулдаг. 2010 оны тооллогоор гарсан 2005-2010 оны шилжих хөдөлгөөний урсгалыг 2000 оны тооллогоор гарсан 1995-2000 оныхтой харьцуулахад адилхан үндсэн гурван чиглэлтэй байна (Хүснэгт 3.4). Үүнд:

1. Улаанбаатар хот
2. Төвийн бүс нутаг
3. Хангайн бүс нутаг

Гэхдээ Улаанбаатар хот руу чиглэсэн хамгийн том урсгал өмнө нь Баруун бүс нутгаас байсан бол сүүлчийн 5 жилд Хангайн бүс нутгаас байна. Улаанбаатар хот руу Хангайн бүс нутгаас 2005-2010 оны хооронд 55 864 хүн шилжиж иржээ. Үүнийг 2000 оны тооллогоор гарсан 1995-2000 оны шилжих хөдөлгөөний Хангайн бүс нутгаас – Улаанбаатар хот руу чиглэсэн урсгалтай (24 437 хүн)⁶ харьцуулахад хоёр дахин нэмэгдсэн байна. Хангайн бүс нутгаас – Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал илүү байгааг Зураг 3.1-ээс харж болно. Хамгийн бага урсгал нь Зүүн бүс нутгаас баруун бүс нутаг руу 120 хүн орсон байна.

ЗУРАГ 2.2 ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМААС УЛААНБААТАР ХОТОД СҮҮЛИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧИД, БҮС НУТГААР*, 2010 ОН (ШИЛЖИН ИРСЭН БОЛОН ЯВСАН ХҮНИЙ ЗӨРҮҮГЭЭР, МЯН.ХҮН)



⁶ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: Улаанбаатар хот, 2002 он, хуудас 25.

ХҮСНЭГТ 2.4 ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ТОО, 2005 ОНЫ 1 ДҮГЭЭР САР БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА СУУЖ БАЙСАН БҮС НУТГААР, 2010 ОН

2005 оны 1 дүгээр сард байнга амьдарч байсан газар	5, түүнээс дээш насны хүн ам	Тоолох үед байнга оршин сууж байсан газар					Шилжин явсан
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
БҮГД	2 321 148	303 132	449 421	386 720	161 727	1 020 148	-
Баруун	348 358	292 011	5 355	11 204	379	39 409	56 347
Хангай	493 075	1 430	425 698	9 642	441	55 864	67 377
Төв	391 445	1 117	4 382	332 898	1 439	51 609	58 547
Зүүн	182 152	120	431	3 409	153 452	24 740	28 700
Улаанбаатар	884 407	7 721	12 572	24 038	5 385	834 691	49 716
Гадаад ¹	21 711	733	983	5 529	631	13 835	21 711
Шилжин ирсэн	-	11 121	23 723	53 822	8 275	185 457	282 398

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал улам бүр нэмэгдэж эрчимжсэн байна. 1995-2000 онд 95 435 хүн Улаанбаатар хотод шилжин ирж байсан бол 2005-2010 онд нийтдээ 185 457 хүн шилжин ирж, таван жилийн шилжих хөдөлгөөн 1.9 дахин нэмэгджээ.

Хүснэгт 3.5-ын эхний хэсэгт тоолох үед байнга оршин суугаа тав, түүнээс дээш насны хүн амыг 2005 оны 1 дүгээр сард байнга амьдарч байсан бүс нутаг, эзлэх хувиар харуулав. 2005 оны 1 дүгээр сард байнга оршин сууж байсан бүс нутагтаа 2010 оны тооллогын үед байнга оршин суугаа хүний эзлэх хувь Улаанбаатар хотод хамгийн өндөр (94.4%) байгаа нь өмнөх тооллогынхоос 0.4 пунктээр буурсан байна. Таван жилийн шилжих хөдөлгөөний дүр төрхөөс харахад Улаанбаатар хотоос Төвийн (2.7%) болон Хангайн (1.4%) бүс рүү шилжих нь Баруун (0.9%) болон Зүүн (0.3%) бүс рүү шилжихээс илүү байна. Энэ дүр төрх нь 2000 оныхтой төстэй боловч Хангайн болон Төвийн бүс рүү шилжих хөдөлгөөн арай илүү нэмэгдсэн байна.

Улаанбаатар хотын дараа таван жилд шилжих хөдөлгөөнд ороогүй хүний эзлэх хувь хамгийн өндөр Хангайн бүсэд (86.3%) байна. Харин хамгийн бага нь Баруун бүсэд хамгийн бага (83.8%) байна. Энэ нь Баруун бүс нутгаас гадагшаа шилжих хөдөлгөөн өмнөх 5 жилд хамгийн өндөр байгааг харуулж байна. Гэхдээ Баруун бүс нутгаас гарсан шилжих хөдөлгөөний урсгал Улаанбаатар хотоос гадна Хангайн болон Төвийн гэсэн хоёр бүс нутаг руу чиглэж байгаа учир Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал Хангайн бүсийнхтэй харьцуулахад харьцангуй бага байна.

Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн 2000-2010 оны хооронд хэвээр хадгалагдаж байгаа ч бүх бүс нутгаас ирэх урсгал ойролцоогоор хоёр дахин өссөн байна. Улаанбаатар руу Зүүн (13.6%) болон Төвийн (13.2%) бүс нутгаас ирэх урсгал Баруун (11.3%) болон Хангайн (11.3%) бүс нутгаас ирэх урсгалаас ялимгүй их байна.

Сүүлчийн таван жилд Төвийн бүсэд Баруун бүс нутгаас (3.2%) хамгийн олон хүмүүс шилжиж ирсэн байна. Үүний дараа нь Улаанбаатар хот (2.7%), Хангай (2.0%) болон Зүүн (1.9%) бүс нутаг орж байна. Энэ нь 2000 оны тооллогынхтой яг адилхан байна. Хангайн бүсэд Баруун бүс нутгаас (1.5%) хамгийн олон хүн шилжиж ирсэн байна. Үүний дараа Улаанбаатар хот орж байна. Өөрөөр хэлбэл, Төв болон Хангайн бүс нутгаас хүмүүс шилжиж, ихэвчлэн Улаанбаатар хот руу явахаас гадна эдгээр бүс нутагт Баруун болон Зүүн бүс нутгаас хүмүүс ирж суурьшиж байна. Тиймээс Төв болон Хангайн бүс нутаг нь Баруун болон Зүүн бүс нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний “дамжих цэг” болж байна.

ХҮСНЭГТ 2.5 ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ТОО, 2005 ОНЫ 1 ДҮГЭЭР САР
БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА СУУЖ БАЙСАН БҮС НУТАГ, ХУВИАР, 2010 ОН

2005 оны 1 дүгээр сард байнга амьдарч байсан газар	Бүгд	Тоолох үед байнга оршин сууж байсан газар				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
БҮГД	100.0	13.1	19.4	16.7	7.0	44.0
Баруун	100.0	83.8	1.5	3.2	0.1	11.3
Хангай	100.0	0.3	86.3	2.0	0.1	11.3
Төв	100.0	0.3	1.1	85.0	0.4	13.2
Зүүн	100.0	0.1	0.2	1.9	84.2	13.6
Улаанбаатар	100.0	0.9	1.4	2.7	0.6	94.4
Гадаад ¹	100.0	3.4	4.5	25.5	2.9	63.7
ДҮН	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	15.0	96.3	1.2	2.9	0.2	3.9
Хангай	21.2	0.5	94.7	2.5	0.3	5.5
Төв	16.9	0.4	1.0	86.1	0.9	5.1
Зүүн	7.8	0.0	0.1	0.9	94.9	2.4
Улаанбаатар	38.1	2.5	2.8	6.2	3.3	81.8
Гадаад ¹	0.9	0.2	0.2	1.4	0.4	1.4

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

2010 онд Улаанбаатар хотод байнга оршин суудаг нийт хүн амын тавны дөрөв нь (81.8%) Улаанбаатар хотод таван жилийн өмнө байнга оршин сууж байсан бол үлдсэн хэсэг нь бусад аймгаас сүүлчийн таван жилд шилжин ирсэн байна (Хүснэгт 3.5, хоёр дахь хэсэг). Улаанбаатар хотод сүүлчийн таван жилд шилжих хөдөлгөөнд ороогүй хүний эзлэх хувь 2000 онд 96.8 хувь байсан бол 2010 онд 94.4 хувь болж буурсан байна. Түүнчлэн 1995 онд Монгол улсын тав түүнээс дээш насны хүн амын 29.3 хувь Улаанбаатар хотод амьдарч байсан бол 2000 онд 32.9 хувь, 2005 онд 38.1 хувь, 2010 онд 44.0 хувь болж, нийтдээ 10 жилийн дотор 14.7 пунктээр өссөн байна.

Монгол улсад шилжих хөдөлгөөн улс орон даяар 2010 онд 2000 онтой харьцуулахад ерөнхийдөө нэмэгдсэнийг өмнө нь тэмдэглэсэн. Улаанбаатар хотоос бусад бүх бүс нутгийн хувьд сүүлчийн таван жилд тухайн бүс нутагтаа байнга оршин сууж буй хүний эзлэх хувь 2010 онд 2000 онтой харьцуулахад буурсан байна. Төвийн бүс нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал хамгийн их байгаагаас харахад “Бусад бүс нутаг – Төвийн бүс нутаг – Улаанбаатар хот” гэсэн үе шаттай урсгал явагдаж байна.

Сүүлийн таван жилийн шилжих хөдөлгөөн 2005-2010 онд 1995-2000 оныхоос улам бүр нэмэгдсэн байна. Баруун бүсээс гадагшаа шилжих урсгал өндөр хэвээрээ байна. Гэхдээ Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний хувьд Хангайн бүс нутаг, Баруун бүс нутгийн оронд түрж орж ирсэн байна. Учир нь Хангайн бүс нутгаас гарсан урсгалын хувьд Төвийн бүс, Улаанбаатар хот гэсэн хоёр гол хүлээж авах бүс нутаг байхад Баруун бүс нутгаас гарсан урсгалын хувьд Хангай, Төв, Улаанбаатар хот гэсэн гурван хүлээж авах бүс нутаг байна.

Түүнээс гадна сүүлчийн таван жилийн шилжих хөдөлгөөний хувьд Улаанбаатар хот руу Монгол улсын өнцөг булан бүрээс чиглэсэн урсгал 2000-2010 онд өмнөх 10 жилийнхтэй төстэй хэвээр үлдсэн хэдүй ч хэмжээ бараг хоёр дахин нэмэгдсэн байна. Төв болон Хангайн бүс нутаг Улаанбаатар руу чиглэсэн шилжих хөдөлгөөнд оролцохоос гадна Баруун болон Зүүн бүсээс хүмүүс ирж байгаа тул зөвхөн “илгээх” биш харин “хүлээж авах” газар болж, Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний “дамжих цэг” болж Улаанбаатар хот

“эцсийн цэг” болж байна. Тиймээс Улаанбаатар хотод амьдарч байгаа тав түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь сүүлчийн 10 жилд 14.7 пунктээр өссөн байна. 2005-2010 онд гадагшаа шилжих хөдөлгөөний хувьд хамгийн бага бүс нутаг нь Хангайн бүс нутаг хэвээрээ байна.

2.3.2 ТАВАН ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭ

Оюу толгой, Таван толгой гэсэн дэлхийн хэмжээний уул уурхайн ашиглалт явагдаж байгаатай холбоотойгоор үүссэн Өмнөговь аймаг руу чиглэсэн цоо шинэ урсгал сүүлчийн 5 жилд улам эрчимжсэн байна.

Монгол Улсад тав, түүнээс дээш насны хүн амын 13.7 хувь нь сүүлчийн таван жилд шилжих хөдөлгөөнд орсон байна (Хүснэгт 3.6). Улаанбаатар хотод байнга оршин суудаг тав, түүнээс дээш насны хүн амын бараг тавны нэг нь (18.2%) сүүлчийн таван жилд шилжин ирэгчид байна. Харин сүүлчийн таван жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь Өмнөговь аймгийн хувьд хамгийн өндөр 26.0 хувь байна. Үүний дараа Говь-Сүмбэр (25.0%), Дархан-Уул (19.9%), Орхон (19.0%), Төв (17.6%), Дорноговь (15.9%), Сэлэнгэ (15.9%) аймаг орж улсын дунджаас дээгүүр байна. Эдгээрийн дараа сүүлчийн таван жилийн шилжих хөдөлгөөн харьцангуй өндөр аймагт Булган (11.2%), Хэнтий (10.4%) аймаг орж байна. Таван жилийн шилжих хөдөлгөөн улсын дунджаас дээгүүр байгаа аймагт шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд давамгайлж байна. Жишээлбэл, Өмнөговь аймагт 2010 онд байнга оршин сууж байгаа тав, түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн гуравны нэг нь сүүлчийн таван жилд шилжин ирэгчид байна.

ХҮСНЭГТ 2.6 ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН СҮҮЛЧИЙН ТАВАН ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Суурин хүн ам			Сүүлийн 5 жилд шилжих хөдөлгөөнд ороогүй			Шилжин ирэгчид		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	2 321 148	1 148 040	1 173 108	86.3	86.0	86.6	13.7	14.0	13.4
Архангай	73 537	36 674	36 863	94.6	95.7	93.5	5.4	4.3	6.5
Баян-Өлгий	72 501	36 241	36 260	97.0	97.2	96.9	3.0	2.8	3.1
Баянхонгор	65 889	32 978	32 911	95.1	95.0	95.3	4.9	5.0	4.7
Булган	46 489	23 990	22 499	88.8	88.7	89.0	11.2	11.3	11.0
Говь-Алтай	46 412	23 142	23 270	91.0	91.3	90.7	9.0	8.7	9.3
Дорноговь	50 332	25 387	24 945	84.1	83.3	84.8	15.9	16.7	15.2
Дорнод	59 915	30 239	29 676	95.1	94.5	95.7	4.9	5.5	4.3
Дундговь	33 610	17 031	16 579	94.7	94.5	94.9	5.3	5.5	5.1
Завхан	56 199	28 175	28 024	94.3	94.5	94.2	5.7	5.5	5.8
Өвөрхангай	87 354	43 636	43 718	95.5	95.4	95.5	4.5	4.6	4.5
Өмнөговь	54 383	31 598	22 785	74.0	64.9	86.7	26.0	35.1	13.3
Сүхбаатар	44 956	22 947	22 009	93.7	93.4	94.0	6.3	6.6	6.0
Сэлэнгэ	83 809	42 639	41 170	84.1	83.7	84.5	15.9	16.3	15.5
Төв	73 227	38 260	34 967	82.4	81.8	83.0	17.6	18.2	17.0
Увс	62 375	31 488	30 887	94.9	94.7	95.0	5.1	5.3	5.0
Ховд	65 645	32 568	33 077	94.1	94.4	93.7	5.9	5.6	6.3
Хөвсгөл	99 215	49 282	49 933	96.2	96.4	96.1	3.8	3.6	3.9
Хэнтий	56 856	29 035	27 821	89.6	89.2	90.0	10.4	10.8	10.0
Дархан-Уул	80 051	39 156	40 895	80.1	80.4	79.9	19.9	19.6	20.1
Улаанбаатар	1 020 148	490 169	529 979	81.8	81.7	81.9	18.2	18.3	18.1
Орхон	76 937	37 567	39 370	81.0	81.1	80.9	19.0	18.9	19.1
Говьсүмбэр	11 308	5 838	5 470	75.0	73.6	76.4	25.0	26.4	23.6

Увс, Дундговь, Архангай, Завхан, Ховд, Сүхбаатар, Говь-Алтай аймагт сүүлчийн таван жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 5.1%-9.0% хооронд хэлбэлзэж байна. Эдгээр аймгаас Увс, Дундговь, Сүхбаатар аймагт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү шилжиж ирсэн, харин үлдсэн аймгуудад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү шилжиж ирсэн байна. Дээрхээс Говь-Алтай (9.0%) аймагт сүүлчийн таван жилд шилжин ирэгчид хамгийн өндөр байгаа нь тэнд хүмүүсийг татах хүч бага ч гэсэн байгааг харуулж байна.

Баян-Өлгий, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Дорнод аймагт сүүлчийн таван жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн бага байна. Эдгээр аймгаас Баянхонгор, Дорнод аймагт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү шилжиж ирсэн харин бусдад нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү шилжиж ирсэн байна.

Сүүлчийн таван жилд Улаанбаатар хот руу чиглэсэн нүсэр нүүдэл үргэлжилсэн хэвээр байгаа ч сүүлчийн таван жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь Өмнөговь, Говьсүмбэр аймгийн хувьд хамгийн өндөр байна. Өмнөговь аймаг руу чиглэсэн урсгал 2010 оны тооллогоор гарсан цоо шинэ урсгал бөгөөд сүүлчийн таван жилд бүр их нэмэгдсэн нь харагдаж байна. Өмнөговь, Говьсүмбэр аймагт сүүлчийн таван жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү давамгайлж байгаа нь уул уурхайн салбартай холбоотой.

2.4 НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, БҮС НУТАГ, АЙМГААР

2.4.1 УЛААНБААТАР ХОТ РУУ ЧИГЛЭСЭН НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

2010 оны хүн амын тооллогоор гарсан сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний урсгалыг бүс нутгаар харахад шилжих хөдөлгөөний урсгал 2000 оны тооллогын үр дүнтэй адилхан үндсэн хоёр чиглэлтэй байна (Хүснэгт 3.7). Үүнд:

- 1) Улаанбаатар хот
- 2) Төвийн бүс нутаг

Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал хэвээр хадгалагдсан байна. 2000 оны тооллогоор Улаанбаатар хот руу чиглэсэн хамгийн том урсгал Баруун бүс нутгаас байсан бол 2010 оны тооллогоор Хангайн бүс нутаг болж өөрчлөгдсөн байна. Улаанбаатар хот руу Хангайн бүс нутгаас сүүлчийн нэг жилд нийтдээ 19 125 хүн шилжиж ирсэн байна. Хамгийн бага урсгал нь Зүүн бүс нутгаас Баруун бүс нутаг руу 61 хүн орсон байна.

Сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн тоог харахад Улаанбаатар хотод жилд 61 мянган хүн, Төвийн бүс нутагт 23 мянган хүн шилжин ирдэг гэж тоймлон хэлж болохоор байна. Мөн Баруун бүс нутгаас жилд дундажаар 18 мянган хүн, Хангайн бүс нутгаас 24 мянган хүн, Төвийн бүс нутгаас 18 мянган хүн, Улаанбаатар хотоос 20 мянган хүн шилжин явсан байна.

Улаанбаатар хотын хүн амын 98.1 хувь сүүлчийн нэг жилд өөр газар руу шилжээгүй байна (Хүснэгт 3.8). Өөрөөр хэлбэл, 2010 оны тооллогын үед Улаанбаатар хотод байнга оршин сууж байгаа хүн амын 1.9 хувь сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид байна. Сүүлчийн 1 жилд Улаанбаатар хотоос Төвийн бүс нутаг (1.0%) руу шилжсэн шилжих хөдөлгөөн бусад бүс нутаг руу шилжсэн хөдөлгөөнөөс их байна. Улаанбаатар хотын дараа сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд ороогүй хүний эзлэх хувь хамгийн өндөртэй газар бол Төвийн бүс нутаг (95.8%) байна. Энэ нь сүүлчийн 5 жилийн шилжих хөдөлгөөний дүнгээс арай өөр байна. Сүүлчийн 5 жилийн шилжих хөдөлгөөний дүнгээс Хангайн бүс нутаг (86.3%) Улаанбаатар хотын дараа орж байсан. Харин сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд ороогүй хүний эзлэх хувь Баруун бүс нутагт хамгийн бага (95.1%) байна. Энэ нь сүүлчийн нэг жилд Баруун бүс нутгаас гадагшаа шилжих хөдөлгөөн өндөр байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 2.7 ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ӨМНӨ БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН БҮС НУТГААР, 2010 ОН

Жилийн өмнө байнга амьдарч байсан газар	Хүн амын тоо	Тоолох үед байнга оршин сууж байсан газар					Шилжин явсан
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	
БҮГД	2 647 545	352 537	514 726	440 693	185 299	1 154 290	-
Баруун	365 998	347 989	1 632	3 083	130	13 164	18 009
Хангай	530 152	570	506 142	4 137	178	19 125	24 010
Төв	435 318	409	1 551	417 104	488	15 766	18 214
Зүүн	191 418	61	158	1 227	182 146	7 826	9 272
Улаанбаатар	1 113 649	3 077	4 838	10 746	1 991	1 092 997	20 652
Гадаад ¹	11 010	431	405	4 396	366	5 412	11 010
Шилжин ирсэн	-	4 548	8 584	23 589	3 153	61 293	101 167

¹ Гадаадын харьяат иргэд, Монгол Улсын харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Сүүлчийн нэг жилд Улаанбаатар хот руу Зүүн бүс нутгаас (4.1%) ирэх урсгал Төвийн, Баруун болон Хангайн (3.6%) бүс нутгийнхаас ялимгүй их байна.

ХҮСНЭГТ 2.8 ХҮН АМЫН ТОО ЖИЛИЙН ӨМНӨ БОЛОН ТООЛОХ ҮЕД БАЙНГА СУУЖ БАЙСАН БҮС НУТАГ, ХУВИАР, 2010 ОН

Жилийн өмнө байнга амьдарч байсан газар	Бүгд	Тоолох үед байнга оршин сууж байсан газар				
		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
БҮГД	100.0	13.3	19.4	16.6	7.0	43.6
Баруун	100.0	95.1	0.4	0.8	0.0	3.6
Хангай	100.0	0.1	95.5	0.8	0.0	3.6
Төв	100.0	0.1	0.4	95.8	0.1	3.6
Зүүн	100.0	0.0	0.1	0.6	95.2	4.1
Улаанбаатар	100.0	0.3	0.4	1.0	0.2	98.1
Гадаад ¹	100.0	3.9	3.7	39.9	3.3	49.2
ДҮН	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	13.8	98.7	0.3	0.7	0.1	1.1
Хангай	20.0	0.2	98.3	0.9	0.1	1.7
Төв	16.4	0.1	0.3	94.6	0.3	1.4
Зүүн	7.2	0.0	0.0	0.3	98.3	0.7
Улаанбаатар	42.1	0.9	0.9	2.4	1.1	94.7
Гадаад ¹	0.4	0.1	0.1	1.0	0.2	0.5

¹ Гадаадын харьяат иргэд, МУ-н харьяат иргэдээс гадаадад төрсөн хүмүүс

Сүүлчийн нэг жилд Төвийн бүсэд шилжиж ирэгчдийн урсгалаас харахад Улаанбаатар хотоос (1.0%) хамгийн их, дараа нь Баруун (0.8%), Хангай (0.8) болон Зүүн (0.6%) бүс нутгаас ирсэн байна. Энэ нь сүүлчийн таван жилийн шилжих хөдөлгөөний дүр төрхөөс ялгаатай байна. Сүүлчийн таван жилд Баруун бүс нутгаас - Төвийн бүс нутаг руу чиглэсэн урсгал хамгийн их байсан бол сүүлчийн нэг жилд Улаанбаатар хотоос – Төвийн бүс нутаг руу чиглэсэн урсгал хамгийн их байна. Энэ нь хөдөө мал аж ахуй эрхэлж байсан хүмүүс малгүй болсны дараа Улаанбаатар хотод ирж амьжиргаа залгуулахад хүндрэл үүсч буцаж хөдөө аж

ахуйн салбар руу шилжсэн, ингэхдээ өөрсдийн бүс нутаг руу буцахгүй харин Улаанбаатар хотод ойрхон хөдөө нутаг руу явсан байж болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл, “Баруун бүс нутаг - Улаанбаатар – Төвийн бүс нутаг” гэсэн урсгал байна. Шилжигчдийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарыг 7 дугаар бүлэг авч үзнэ.

Хангайн бүсэд шилжин ирсэн урсгал Баруун болон Төвийн бүс нутаг Улаанбаатар хотоос адилхан 0.4 хувь байна. Өөрөөр хэлбэл, Хангайн бүс нутаг Төвийн бүс нутагтай адилхан шилжигчдийг татаж байна.

2010 онд Улаанбаатар хотод байнга оршин суугаа хүн амын 94.7 хувь Улаанбаатар хотод нэг жилийн өмнө байнга оршин сууж байсан бол үлдсэн 5.3 хувь нь аймгуудаас сүүлчийн нэг жилд шилжиж ирсэн байна. Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөнөөс харахад Улаанбаатар хотын хүн ам жилд дунджаар **61.3 мянган хүнээр** нэмэгдэж байна. Түүнчлэн, нэг жилийн өмнө Монгол улсын хүн амын 42.1 хувь Улаанбаатар хотод амьдарч байсан бол 2010 онд 43.6 хувь болж нэг жилийн дотор Улаанбаатар хотын нийт хүн амд эзлэх хувь 1.5 пунктээр өсч, Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн жил ирэх тутам улам бүр эрчимжиж байгааг давхар харуулж байна.

Нэг жилийн өмнө Монгол улсын нийт хүн амын 13.8 хувь Баруун бүсэд амьдарч байсан бол 2010 онд 13.3 хувь болж нэг жилийн дотор 0.5 пунктээр буурчээ. Энэ үзүүлэлт Хангайн бүсэд 0.2 пунктээр, Зүүн бүсэд 0.2 пунктээр буурчээ (Хүснэгт 3.8).

Харин Төвийн бүс нутагт нэг жилийн өмнө 16.4 хувь амьдарч байсан бол 2010 онд 16.6 хувь болж 0.2 пунктээр өсчээ. Эдгээрээс Төвийн бүс нутаг шилжигчдийг “хүлээж авдаг бүс нутаг” хэвээрээ байгаа нь тод харагдаж байна. Түүнээс гадна “Бусад бүс нутаг – Төвийн бүс нутаг – Улаанбаатар хот” гэсэн үе шаттай урсгал байна.

Сүүлчийн нэг жилд 101 мянган хүн шилжих хөдөлгөөнд орсноос 60 хувь Улаанбаатар хот, 25 хувь Төвийн бүс нутагт ирж суурьшсан байна. Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөн сүүлчийн таван жилийнхтэй төстэй байна. Баруун бүс нутгаас гадагшаа шилжих урсгал өндөр хэвээрээ байгаа ч Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний хувьд Хангайн бүс, Баруун бүсийн оронд түрж орсон байна. Учир нь Хангайн бүс нутгаас гарсан шилжих хөдөлгөөний урсгалын хувьд Төвийн бүс, Улаанбаатар хот гэсэн хоёр гол хүлээж авах бүс нутаг байхад Баруун бүс нутгаас гадагшаа шилжих урсгалын хувьд Хангай, Төв, Улаанбаатар хот гэсэн гурван хүлээж авах бүс нутаг байна. Түүнээс гадна сүүлчийн нэг жилийн хувьд “Баруун бүс нутаг - Улаанбаатар – Төвийн бүс нутаг” гэсэн урсгал тод харагдаж байна. Энэ нь зарим шилжигчид ялангуяа, хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын хувьд Улаанбаатар хот нь “дамжих цэг” болж байгааг харуулж байна.

Түүнчлэн, Төв болон Хангайн бүсээс Улаанбаатар хотод хүмүүс шилжин ирэхээс гадна Баруун болон Зүүн бүс нутгаас Төв болон Хангайн бүсэд хүмүүс ирж байгаа тул Төв болон Хангайн бүс нь зөвхөн “илгээх” биш харин “хүлээж авах” газар болж, Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний “дамжих цэг” болж, харин Улаанбаатар хот “эцсийн цэг” болж байна. Өөрөөр хэлбэл, Төвийн бүс нутаг, Улаанбаатар хот улс орны өнцөг булан бүрээс ирсэн дийлэнх хүмүүсийн хувьд хүлээж авах “эцсийн цэг” нь болсон хэвээр байна.

2.4.2 ӨМНӨГОВЬ АЙМАГ РУУ ЧИГЛЭСЭН НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний дүр төрх сүүлчийн таван жилийнхтэй төстэй байна. Гэхдээ Өмнөговь аймаг руу чиглэсэн шинэ урсгал нь сүүлчийн нэг жилд улам эрчимжсэн нь харагдаж байна (Хүснэгт 3.9).

ХҮСНЭГТ 2.9 НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010 ОН

Аймаг, нийслэл	Суурин хүн ам			Сүүлийн 1 жилд шилжих хөдөлгөөнд ороогүй			Сүүлийн 1 жилд шилжин ирэгчид		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	2 647 545	1 313 968	1 333 577	95.7	95.4	96.0	4.3	4.6	4.0
Архангай	84 078	41 943	42 135	98.4	98.7	98.2	1.6	1.3	1.8
Баян-Өлгий	85 232	42 655	42 577	98.9	99.0	98.8	1.1	1.0	1.2
Баянхонгор	75 690	38 023	37 667	98.1	97.9	98.2	1.9	2.1	1.8
Булган	53 065	27 325	25 740	95.9	95.8	96.1	4.1	4.2	3.9
Говь-Алтай	53 223	26 602	26 621	97.0	96.7	97.3	3.0	3.3	2.7
Дорноговь	57 930	29 230	28 700	95.1	94.5	95.7	4.9	5.5	4.3
Дорнод	68 873	34 796	34 077	98.1	97.8	98.4	1.9	2.2	1.6
Дундговь	38 543	19 578	18 965	98.1	97.9	98.4	1.9	2.1	1.6
Завхан	64 924	32 544	32 380	98.3	98.2	98.3	1.7	1.8	1.7
Өвөрхангай	100 444	50 333	50 111	98.5	98.5	98.5	1.5	1.5	1.5
Өмнөговь	60 855	34 884	25 971	82.8	75.0	93.3	17.2	25.0	6.7
Сүхбаатар	51 091	26 059	25 032	97.8	97.6	97.9	2.2	2.4	2.1
Сэлэнгэ	95 804	48 756	47 048	95.8	95.6	96.0	4.2	4.4	4.0
Төв	83 838	43 751	40 087	94.6	94.4	94.8	5.4	5.6	5.2
Увс	72 906	36 829	36 077	98.2	98.1	98.4	1.8	1.9	1.6
Ховд	76 252	38 006	38 246	97.9	97.8	98.0	2.1	2.2	2.0
Хөвсгөл	114 331	56 899	57 432	98.7	98.7	98.8	1.3	1.3	1.2
Хэнтий	65 335	33 399	31 936	97.2	96.9	97.4	2.8	3.1	2.6
Дархан-Уул	90 642	44 556	46 086	93.6	93.9	93.3	6.4	6.1	6.7
Улаанбаатар	1 154 290	558 247	596 043	94.7	94.6	94.8	5.3	5.4	5.2
Орхон	87 118	42 813	44 305	94.7	94.8	94.7	5.3	5.2	5.3
Говьсүмбэр	13 081	6 740	6 341	92.4	91.5	93.3	7.6	8.5	6.7

Монгол Улсын нийт хүн амын 4.3 хувь сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орсон байна. Энэ нь 2000 оны тооллогын дүнтэй ойролцоо бөгөөд 2000 оноос хойш жилд дунджаар шилжин ирж байгаа хүний тоо буураагүй улам нэмэгдсэн гэсэн үг юм. Улаанбаатар хотод байнга оршин суудаг хүн амын 5.3 хувь нь сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид байна. Гэхдээ сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөн хамгийн өндөр нь Өмнөговь аймаг (17.2%) байна. Үүний дараа Говь-Сүмбэр (7.6%), Дархан-Уул (6.4%), Төв (5.4%), Орхон (5.3%), Дорноговь (4.9%) аймаг орж улсын дунджаас дээгүүр байна. Эдгээрийн дараа сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид ихтэй аймагт Сэлэнгэ (4.2%), Булган (4.1%), Говь-Алтай (3.0%), Хэнтий (2.8%) орж байна. Төвийн болон Хангайн бүсийн аймгууд шилжин ирэгчдийг урд өмнө татдаг байсан бол Өмнөговь, Говьсүмбэр аймаг нэмэгдсэн. Ингэхдээ улсын дунджаас дээгүүр гарч ирсэн нь онцгой анхаарал татаж байна. Өмнөговь аймагт амьдарч байгаа бараг таван хүний нэг нь сүүлчийн нэг жилд шилжиж ирсэн байна. Түүнээс гадна шилжин ирэгчдийн эзлэх хувь нь улсын дунджаас өндөр байгаа эдгээр аймагт (Дархан-Уул, Орхон

аймгаас бусад) эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс шилжин ирэх нь илүү байна. Жишээлбэл, Өмнөговь аймагт 2010 онд байнга оршин сууж байгаа эрэгтэйчүүдийн дөрөвний нэг нь сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид байна. Энэ нь Өмнөговь аймагт өрнөж байгаа уул уурхайн салбартай холбоотой бүтээн байгуулалтад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү оролцож байна.

Ховд, Сүхбаатар, Хэнтий, Говь-Алтай, Булган, Сэлэнгэ аймгийн хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 2.1-4.2-ын хооронд хэлбэлзэж байна. Эдгээр аймагт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү шилжиж ирсэн байна. Түүнчлэн, уламжлалт гадагшаа шилжих хөдөлгөөн өндөр байдаг Баруун бүсийн Ховд, Говь-Алтай аймгийн хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь тийм бага биш байгаа нь эдгээр аймагт хүмүүсийг татах зарим үйл ажиллагаа, тухайлвал, хөгжлийн асуудлыг орон нутгийн онцлогтой, зохистойгоор шийдсэнтэй холбоотой байж болох юм.

Харин Баян-Өлгий, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Завхан, Увс, Дундговь, Дорнод, Баянхонгор аймгийн хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 1.1-1.9 -ын хооронд хэлбэлзэж байна. Эдгээр аймаг дотроос Баян-Өлгий, Өвөрхангайгаас бусад аймагт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү шилжин ирсэн байна.

Эцэст нь дүгнэхэд сүүлчийн нэг жилд Улаанбаатар хот руу чиглэсэн нүүдэл үргэлжилсэн хэвээр байгаа ч сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь Өмнөговь аймгийн хувьд онцгой өндөр байна. Өмнөговь руу чиглэсэн урсгал 2010 оны тооллогоор гарсан шинэ урсгал бөгөөд сүүлчийн нэг жилд бүр их нэмэгдсэн нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хот шилжигчдийг хамгийн их татдаг газар хэвээрээ байгаа ч Өмнөговь, Говьсүмбэр аймаг ялангуяа, эрэгтэйчүүдийг түүнээс илүү татаж байна. Энэ нь нь уул уурхайн салбартай холбоотой бүтээн байгуулалттай холбоотой юм.

2010 оны тооллогын дүнгээрх шилжих хөдөлгөөний урсгал нь 2000 оныхтой адилхан хэвээр боловч ерөнхийдөө эрчим нь нэмэгдсэн байна. Монгол улсын хүн ам Төвийн болон Хангайн бүс нутаг, Улаанбаатар хотод, өөрөөр хэлбэл, газар нутгийнхаа төвд төвлөрч зах хязгаар нь улам бүр хоосорч байгааг 2010 оны тооллогын дүн дахин баталлаа. Баруун бүс нутгаас Хангай, Төвийн бүс Улаанбаатар хот, улмаар Хангай, Төвийн бүсээс Улаанбаатар хот руу нүүх “шаталсан нүүдэл” улам бүр нэмэгдсэн байна.

Үүнээс гадна Өмнөговь аймаг руу чиглэсэн урсгал шинээр гарч ирсэн бөгөөд энэ нь сүүлчийн жилд тухайлвал, сүүлчийн 1.5 жилд илүү их нэмэгдсэн нь тод харагдаж байна. Ялангуяа, Өмнөговь аймаг руу чиглэсэн урсгал нь хүйсийн хувьд эрэгтэйчүүд байгаа нь анхаарал татаж байна. Энэ урсгалыг уул уурхайн салбарын хөгжилтэй холбоотой гэж үзэж болох бөгөөд үүнийг 7 дугаар бүлэгт судалж харуулна. Эдгээр шилжих хөдөлгөөн, шинэ урсгал нь суурьшилт, хотжилт бий болгож байгаа эсэхийг дараагийн бүлэгт судлахыг зорив.


ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХОТЖИЛТ



Өндөр хөгжилтэй улс оронд үйлдвэржих үйл явцтай холбогдон хот суурин газарт үйлдвэрийн газар бий болж түүнийг дагасан шилжих хөдөлгөөн өрнөдөг. Харин хөгжиж байгаа улс оронд үйлдвэржих явц тэгтлээ өрнөөгүй тохиолдолд шилжих хөдөлгөөний өрнөл ч хот, суурин газрыг чиглэж, шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлдэг. Үүнтэй адил Монгол Улсын хувьд шилжих хөдөлгөөн жилээс жилд эрчимжиж байгаа ч үнэхээр үйлдвэржилтээс үүдэлтэй хотжилтыг бий болгож байна уу гэвэл арай тийм биш юм. Өөрөөр хэлбэл, хотын хүн ам өснө гэдэг хөгжил сайжирч байна гэсэн үг биш юм. Монгол улсын хотын хүн ам 1969 оноос хойш байнга өссөн бөгөөд буцаж буураагүй байна (Зураг 4.1). 2000-2010 оны хооронд хотын хүн амын эзлэх хувь 11.3 пунктээр өссөн нь 1969-2000 оны хоорондох өсөлттэй бараг ойролцоо байна. Сүүлчийн 10 жилд Монгол улсын хотын хүн амын өсөлт түүний өмнөх 30 жилийн өсөлттэй ойролцоо болж байна. 2010 оны байдлаар Монгол Улсын гурван хүний хоёр нь хот, суурин газар амьдарч байна.

ЗУРАГ 3.1 НИЙТ ХҮН АМД ХОТЫН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Улаанбаатар хотыг оруулахгүйгээр тооцвол Төвийн бүс нутаг хотжилтын төвшингээр хамгийн өндөр (48.0%) байна (Хүснэгт 4.1). 2010 онд Төвийн бүс нутгийн хотжилтын төвшин 2000 онтой харьцуулахад 2.6 пунктээр өсчээ. Хотжилтын төвшингээр Төвийн бүс нутгийн дараа Зүүн, Хангайн бүс нутаг орж, харин Баруун бүс нутаг хамгийн доогуур (34.7%) байна.

2010 онд 2000 онтой харьцуулахад хотжилтын төвшин Хангайн бүс нутагт 11.6 пунктээр өссөн нь хамгийн өндөр байна. Үүний дараа Баруун бүс нутагт хотжилтын төвшин 5.6 пункт, Зүүн бүс нутагт 4.0 пункт, Төвийн бүс нутагт 2.6 пунктээр өссөн байна. Хотжилтын төвшин гадагшаа шилжих хөдөлгөөн өндөр Баруун, Зүүн бүс нутагт шилжин ирэгчдийг хамгийн их хүлээж авдаг Төвийн бүс нутгаас илүү өссөн нь анхаарал татаж байна. Энэ нь нэг талдаа Төвийн бүс нутагт шилжиж ирсэн хүмүүс хөдөө аж ахуйн салбарт ажиллаж, өөрөөр хэлбэл, “Бусад бүс нутгийн хөдөөгөөс - Төвийн бүсийн хөдөө рүү” шилжиж байгаа харуулж байна. Нөгөө талдаа Баруун, Хангайн, Зүүн бүс нутагт гадагшаа шилжих хөдөлгөөнөөс гадна бүс нутаг, аймаг дотроо “хөдөөнөөс – хот руу” шилжих хөдөлгөөн байгааг харуулж байна. Энэ шилжих хөдөлгөөнийг аймгийн төвшинд хийх судалгаагаар илүү тодорхойлж гаргаж болох юм.

ХҮСНЭГТ 3.1 МОНГОЛ УЛСЫН ХОТЫН ХҮН АМ, БҮС НУТАГ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР 2000⁷, 2010 ОНЫ ТООЛЛОГООР

Бүс нутаг, аймаг	Суурин хүн ам		Хотын хүн ам		Хотын хүн амын эзлэх хувь		Нийт хүн амд эзлэх хувь		Хотын хүн амд эзлэх хувь	
	2000 он	2010 он	2000 он	2010 он	2000 он	2010 он	2000 он	2010 он	2000 он	2010 он
БҮГД	2 373 493	2 647 545	1 344 516	1 798 147	56.6	67.9	100.0	100.0	100.0	100.0
БАРУУН	421 608	352 537	122 701	122 334	29.1	34.7	17.8	13.3	9.1	6.8
Баян-Өлгий	91 068	85 232	28 060	30 663	30.8	36.0	3.8	3.2	2.1	1.7
Говь-Алтай	63 673	53 223	18 023	17 962	28.3	33.7	2.7	2.0	1.3	1.0
Завхан	89 999	64 924	24 276	17 485	27.0	26.9	3.8	2.5	1.8	1.0
Увс	90 037	72 906	26 319	27 178	29.2	37.3	3.8	2.8	2.0	1.5
Ховд	86 831	76 252	26 023	29 046	30.0	38.1	3.7	2.9	1.9	1.6
ХАНГАЙН	545 654	514 726	175 681	225 221	32.2	43.8	23.0	19.4	13.1	12.5
Архангай	97 091	84 078	18 519	20 619	19.1	24.5	4.1	3.2	1.4	1.1
Баянхонгор	84 779	75 690	22 066	29 829	26.0	39.4	3.6	2.9	1.6	1.7
Булган	61 776	53 065	16 239	14 116	26.3	26.6	2.6	2.0	1.2	0.8
Өвөрхангай	111 420	100 444	19 058	38 027	17.1	37.9	4.7	3.8	1.4	2.1
Хөвсгөл	119 063	114 331	31 489	38 443	26.4	33.6	5.0	4.3	2.3	2.1
Орхон	71 525	87 118	68 310	84 187	95.5	96.6	3.0	3.3	5.1	4.7
ТӨВИЙН	443 669	440 693	201 357	211 451	45.4	48.0	18.7	16.6	15.0	11.8
Дорноговь	50 575	57 930	25 210	33 932	49.8	58.6	2.1	2.2	1.9	1.9
Дундговь	51 517	38 543	14 517	13 664	28.2	35.5	2.2	1.5	1.1	0.8
Өмнөговь	46 858	60 855	14 183	18 781	30.3	30.9	2.0	2.3	1.1	1.0
Сэлэнгэ	99 950	95 804	56 446	47 008	56.5	49.1	4.2	3.6	4.2	2.6
Төв	99 268	83 838	16 227	13 339	16.3	15.9	4.2	3.2	1.2	0.7
Дархан-Уул	83 271	90 642	65 791	74 985	79.0	82.7	3.5	3.4	4.9	4.2
Говьсүмбэр	12 230	13 081	8 983	9 742	73.5	74.5	0.5	0.5	0.7	0.5
ЗҮҮН	202 485	185 299	84 700	84 851	41.8	45.8	8.5	7.0	6.3	4.7
Дорнод	75 373	68 873	41 714	38 615	55.3	56.1	3.2	2.6	3.1	2.1
Сүхбаатар	56 166	51 091	15 133	16 150	26.9	31.6	2.4	1.9	1.1	0.9
Хэнтий	70 946	65 335	27 853	30 086	39.3	46.0	3.0	2.5	2.1	1.7
УЛААНБААТАР	760 077	1 154 290	760 077	1 154 290	100.0	100.0	32.0	43.6	56.5	64.2

Хотжилтын төвшинг аймаг, нийслэлээр үзэхэд Улаанбаатар хотын дараа Орхон аймаг (96.6%) орж байна. Орхон аймгийн хүн амын 0.4 хувь хөдөөд амьдарч байна. Эндээс Орхон аймгийг бүхэлд нь хот гэж үзэх боломжтой мэт харагдаж байна. Орхон аймгийн дараа Дархан-Уул (82.7%), Говь-Сүмбэр (74.5%) аймаг орж байна. Дархан-Уул аймгийн хүн амын тавны нэг, Говь-сүмбэр аймгийн хүн амын дөрөвний нэг хөдөөд амьдарч байгаа нь хотжилт өндөртэй гэхээсээ илүү засаг захиргааны хуваарьтай холбоотой юм.

Харин бусад аймгийн дотроос Хэнтий (46.0%), Сэлэнгэ (49.1%), Дорнод (56.1%), Дорноговь (58.6%) аймагт хотжилтын төвшин өндөр, хүн амын бараг тал хувь нь хотод амьдардаг байна. Эдгээрийн дараа 30-39 хувийн хотжилтой аймагт Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Говь-Алтай, Дундговь, Баян-Өлгий, Увс, Өвөрхангай, Ховд, Баянхонгор орж байна.

Архангай, Булган, Завхан аймагт хотжилтын төвшин харьцангуй бага 24.5-26.9 хувийн хооронд хэлбэлзэж байна. Харин шилжин ирэгчид хамгийн их Төв аймагт хотжилтын төвшин хамгийн бага нийт хүн амын дийлэнх буюу 84.1 хувь хөдөөд амьдарч байна. Энэ нь зах зээлд ойртсон малчдын нүүдэл, мал аж ахуйн салбар Төвийн бүсэд бөөгнөрч байгаатай


⁷ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: Улаанбаатар хот, 2002 он.

холбоотой. Түүнээс гадна Төвийн бүс “Баруун бүсээс – Улаанбаатар хот руу” чиглэсэн нүүдлийн “дамжих цэг” болж буйтай ч холбоотой юм.

Аймгуудын 2010 оны хотжилтын төвшинг 2000 оныхтой харьцуулахад шилжин ирэгчид хамгийн ихтэй Төв (0.4 пункт), Сэлэнгэ (7.4 пункт) хоёр аймагт хотжилтын төвшин буурсан байна. Төв аймгийн иргэд аймгийн төв рүүгээ шилжихийг гол болгохгүй нийслэлд шууд шилжиж байгаа онцлог ч бас бий юм. Сэлэнгэ аймгийн хотжилтын төвшин буурсан нь Атарын III аяны хүрээнд хүмүүс газар тариалан эрхлэх болсонтой холбоотой байж болох юм.

Сэлэнгэ, Төв аймгаас бусад бүх аймагт хотжилтын төвшин өссөн нь уламжлалт мал аж ахуй эрсдэлтэй аймаг дотроо “хөдөөнөөс аймгийн төв рүү” малгүй болсон малчид шилжин суурьшиж байгаатай холбоотой юм. Хотжилтын төвшин 2000-2010 онд Баянхонгор (13.4 пункт), Өвөрхангай (20.8 пункт) аймагт, бусад аймагтай харьцуулахад онцгой өссөн байна. Өвөрхангай аймгийн хотжилтын төвшин өссөн нь Хар хорин тосгон, аялал жуулчлалын салбарын хөгжилтэй холбоотой байж болох юм.

ЗУРАГ 3.2 МОНГОЛ УЛСЫН НИЙТ ХҮН АМД УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Хотжилтын төвшингээс гадна хүн амын суурьшил төвлөрөлийг харуулах өөр үзүүлэлт бол Монгол Улсын нийт хүн амд тухайн аймаг, нийслэлийн хүн амын эзлэх хувь юм. Шилжих хөдөлгөөний үр дүнд Монгол Улсын нийт хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувь 2010 онд 2000 онтой харьцуулахад хамгийн ихээр өссөн байна. 2010 онд Монгол Улсын нийт хүн амын 43.6 хувь Улаанбаатар хотод амьдарч байна (Зураг 4.2). Энэ нь 2000 оныхтой харьцуулахад 11.6 пунктээр нэмэгдсэн байна.

Улаанбаатар хотоос гадна Дорноговь (0.1 пункт), Орхон (0.3 пункт), Өмнөговь (0.1 пункт) аймгийн хүн амын нийт хүн амд эзлэх хувь өссөн байна. Харин үлдсэн бүх аймгийн хүн амын нийт хүн амд эзлэх хувь буурсан байна. Завхан аймгийн хүн амын нийт хүн амд эзлэх хувь хамгийн ихээр буюу 1.3 пунктээр буурсан байна.


Монгол Улсын хотын хүн амын дийлэнх буюу 64.2 хувь зөвхөн Улаанбаатар хотод амьдарч байна. Үүний дараа Эрдэнэт, Дархан хот орж байна. Эдгээр нь хотын хүн амын 10 хувийг эзэлж байна. Улаанбаатар хот тус улсын хамгийн том хот хэвээр байна. Өвөрхангай, Хөвсгөл, Дорнод, Сэлэнгэ аймаг бусад аймгийг бодвол хотын хүн амд эзлэх хувиараа бусдаас арай өндөр 2.1-2.6 хувь байна. Үлдсэн бүх аймагт хотын хүн амд эзлэх хувь маш бага, 0.5-1.9 хувийн хооронд хэлбэлзэж байна.

Товч дүгнэхэд аймгаасаа гадагшаа шилжин явагчид ихтэй газар хотжилт нэмэгдэж, харин шилжин ирэгчид ихтэй аймагт хотжилт буурсан нь эдийн засгийн өсөлттэй холбоотой гэхээсээ илүү мал аж ахуйн салбарт тохиолдсон ган, зуд зэрэг хүндрэлээс шалтгаалан малгүй болсон малчид ажил эрхлэх, худалдаа, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд ойртох гэж төв суурин газар руу шилжиж байгаатай холбоотой. 1990-ээд оноос өмнөх шилжих хөдөлгөөн нь тодорхой чиглэл зорилготой шилжиж байсан бол 90-ээд оноос хойш энэ байдал эрс өөрчлөгдөж шилжих хөдөлгөөн урсгалаараа явагдаж байгааг харуулж байна.

Монгол Улсын нийт хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувь улам бүр өсч байна.

ДӨРӨВЛҮГЭЭР БҮЛЭГ

НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН НАС, ХҮЙС,
БОЛОВСРОЛ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ



4.1 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН НАС, ХҮЙС

Монгол Улсын нийт хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 4.3 байгаагийн дотор эрэгтэйчүүд (4.6 хувь) эмэгтэйчүүдээс (4.0 хувь) ялимгүй илүү байна (Хүснэгт 5.1). Нас, хүйсээр ангилан үзэхэд хамгийн их шилжих хөдөлгөөнд орж байгаа бүлэг бол 15-19 насны охид (9.6 хувь) байна. Энэ нь сургуульд дэвшин суралцахтай холбоотой байж болох юм. Үүний дараа 20-24 насны эрэгтэйчүүд (9.0 хувь) орж байна. Ерөнхийдөө шилжин ирэгчдийн эзлэх хувь 15-19 (8.9 хувь) болон 20-24 (8.8 хувь) насны залуучуудын хувьд хамгийн өндөр байна. Эдгээрийн дараа 25-29 насны эрэгтэйчүүд (5.6 хувь) орж байна. Мөн 30-39 насны эрэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд орох нь улсын дунджаас дээгүүр байна.

Харин 35-аас дээш насны эмэгтэйчүүд, 40-өөс дээш насны эрэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд орох нь багасч улсын дунджаас доогуур байна. Хүүхэд, настай хүмүүсийн дунд шилжих хөдөлгөөн харьцангуй бага байна.

ХҮСНЭГТ 4.1 СУУРИН ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	2 647 545	1 313 968	1 333 577	114 022	60 953	53 069	4.3	4.6	4.0
0-4	288 497	146 516	141 981	9 389	4 776	4 613	3.3	3.3	3.2
5-9	216 214	110 117	106 097	4 738	2 384	2 354	2.2	2.2	2.2
10-14	236 865	120 064	116 801	4 606	2 370	2 236	1.9	2.0	1.9
15-19	257 645	130 560	127 085	22 898	10 645	12 253	8.9	8.2	9.6
20-24	292 183	147 472	144 711	25 722	13 239	12 483	8.8	9.0	8.6
25-29	247 983	124 490	123 493	12 250	6 988	5 262	4.9	5.6	4.3
30-34	222 522	111 976	110 546	8 682	5 307	3 375	3.9	4.7	3.1
35-39	202 383	100 819	101 564	7 009	4 441	2 568	3.5	4.4	2.5
40-44	179 267	88 273	90 994	5 855	3 841	2 014	3.3	4.4	2.2
45-49	158 756	77 475	81 281	4 504	2 829	1 675	2.8	3.7	2.1
50-54	122 082	58 009	64 073	2 978	1 705	1 273	2.4	2.9	2.0
55-59	71 989	33 384	38 605	1 890	967	923	2.6	2.9	2.4
60-64	49 453	22 106	27 347	1 171	581	590	2.4	2.6	2.2
65-69	38 232	17 262	20 970	836	350	486	2.2	2.0	2.3
70-74	29 332	13 081	16 251	702	266	436	2.4	2.0	2.7
75-79	18 617	7 252	11 365	418	135	283	2.2	1.9	2.5
80-84	9 166	3 258	5 908	217	73	144	2.4	2.2	2.4
85 +	6 359	1 854	4 505	157	56	101	2.5	3.0	2.2

Улаанбаатар хотын суурин хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 5.3 байна (Хүснэгт 5.2). Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын нийт хүн амын 5.3 хувь сүүлчийн нэг жилд байнга амьдарч байсан газраасаа Улаанбаатар хотод байнга амьдрахаар шилжин иржээ. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд эрэгтэйчүүд (5.4%) эмэгтэйчүүдээс (5.2%) ялимгүй илүү шилжин ирсэн байна. Нас, хүйсний бүлгээр авч үзэхэд Улаанбаатар хот руу хамгийн их шилжиж ирсэн бүлэг бол 15-19 насны охид байна. Улаанбаатар хотод амьдарч байгаа 15-19 насны охидын 14.5 хувь нь сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байна. Энэ нь Улаанбаатар хотод их, дээд болон мэргэжлийн сургуульд суралцахтай холбоотой байж болно. Үүний дараа 20-24 насны эрэгтэйчүүд (8.1%) орж байна. Энэ нь Улаанбаатар хотод

суралцахаас гадна, хөдөлмөр эрхлэх боломж илүү байдагтай холбоотой байж болно. Ерөнхийдөө 15-19 (13.6%) болон 20-24 (7.9%) залуучууд Улаанбаатар хот руу хамгийн их шилжин ирж байна. Эдгээрийн дараа 25-29 насны эрэгтэйчүүд (5.5%) орж байна.

Харин Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн 30-аас дээш настай эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алины хувьд багасч улсын дунджаас доогуур байна. Гэхдээ 30-аас дээш насныхны хувьд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг бодвол шилжин ирэх нь илүү байна. Өөрөөр хэлбэл, 15-19 наснаас дээш Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давамгайлж байна.

ХҮСНЭГТ 4.2 УЛААНБААТАР ХОТЫН СУУРИН ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд		2010 онд шилжин ирэгчид						
			тоо			хувь			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 154 290	558 247	596 043	61 293	30 233	31 060	5.3	5.4	5.2
0-4	119 637	60 587	59 050	4 787	2 409	2 378	4.0	4.0	4.0
5-9	80 040	40 885	39 155	2 376	1 208	1 168	3.0	3.0	3.0
10-14	82 753	41 840	40 913	2 473	1 253	1 220	3.0	3.0	3.0
15-19	121 019	58 632	62 387	16 483	7 407	9 076	13.6	12.6	14.5
20-24	159 643	77 209	82 434	12 658	6 236	6 422	7.9	8.1	7.8
25-29	116 322	56 452	59 870	5 899	3 103	2 796	5.1	5.5	4.7
30-34	97 609	47 714	49 895	3 908	2 155	1 753	4.0	4.5	3.5
35-39	86 563	42 319	44 244	3 019	1 707	1 312	3.5	4.0	3.0
40-44	74 127	35 413	38 714	2 583	1 447	1 136	3.5	4.1	2.9
45-49	67 613	31 885	35 728	2 169	1 162	1 007	3.2	3.6	2.8
50-54	52 379	23 907	28 472	1 566	756	810	3.0	3.2	2.8
55-59	31 323	13 927	17 396	1 130	499	631	3.6	3.6	3.6
60-64	22 676	9 829	12 847	723	326	397	3.2	3.3	3.1
65-69	16 605	7 292	9 313	567	227	340	3.4	3.1	3.7
70-74	12 043	5 289	6 754	443	169	274	3.7	3.2	4.1
75-79	7 462	2 829	4 633	262	79	183	3.5	2.8	3.9
80-84	3 855	1 392	2 463	140	47	93	3.6	3.4	3.8
85 +	2 621	846	1 775	107	43	64	4.1	5.1	3.6

Өмнөговь аймгийн суурин хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 17.2 байгаа нь аймгийн нийт хүн амын бараг тавны нэг нь болж байна (Хүснэгт 5.3). Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд эрэгтэйчүүд (25.0%) эмэгтэйчүүдээс (6.7%) бараг дөрөв дахин илүү шилжин ирсэн байна. Нас, хүйсээр ангилан үзэхэд Өмнөговь аймаг руу хамгийн их шилжин ирсэн бүлэг бол 40-44 насны эрэгтэйчүүд (39.2%) байна. Энэ нь шилжих хөдөлгөөний бүх урсгалаас хамгийн өндөр нь юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улс дахь шилжих хөдөлгөөний хамгийн өндөр төвшинтэй урсгал нь Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирсэн 40-44 насны эрэгтэйчүүд байна. Энэ нь уул уурхайн салбарын хөгжилтэй шууд холбоотой юм. Үүний дараа 20-24 насны эрэгтэйчүүд (37.3%) орж байна. Ерөнхийдөө 20-49 насны эрэгтэйчүүд Өмнөговь аймаг руу сүүлчийн нэг жилд эмэгтэйчүүдээс илүү шилжиж очсон байна. Эрэгтэйчүүдийн Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөн 30-аас дээш насанд буурахгүй жигд өндөр байна.

Гэхдээ эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ялгаа 20-29 насанд бага байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл, 20-29 насны эмэгтэйчүүд Өмнөговь аймаг руу, бусад насны

эмэгтэйчүүдээс, илүү олноороо шилжин очиж байна. Ялангуяа, 20-24 насны эмэгтэйчүүдийн бараг тавны нэг нь сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид байна. Эмэгтэйчүүдийн Өмнөговь руу чиглэсэн шилжих хөдөлгөөн 30-аас дээш насанд огцом буурч байна. Уул уурхайн салбар, түүнтэй холбоотой бүтээн байгуулалтад эрчүүд олноороо оролцох гэж Өмнөговь аймагт очихын зэрэгцээ, залуу эмэгтэйчүүд очиж байгаа дүр төрх сонирхол татаж байна.

ХҮСНЭГТ 4.3 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУУРИН ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	60 855	34 884	25 971	10 462	8 709	1 753	17.2	25.0	6.7
0-4	5 726	2 895	2 831	300	152	148	5.2	5.3	5.2
5-9	4 671	2 390	2 281	151	72	79	3.2	3.0	3.5
10-14	5 236	2 668	2 568	100	56	44	1.9	2.1	1.7
15-19	4 387	2 456	1 931	402	296	106	9.2	12.1	5.5
20-24	6 610	4 146	2 464	2 031	1 546	485	30.7	37.3	19.7
25-29	6 988	4 218	2 770	1 779	1 475	304	25.5	35.0	11.0
30-34	5 931	3 722	2 209	1 464	1 293	171	24.7	34.7	7.7
35-39	5 412	3 415	1 997	1 435	1 272	163	26.5	37.2	8.2
40-44	4 853	3 044	1 809	1 295	1 193	102	26.7	39.2	5.6
45-49	3 982	2 400	1 582	890	808	82	22.4	33.7	5.2
50-54	2 501	1 446	1 055	395	363	32	15.8	25.1	3.0
55-59	1 331	674	657	133	114	19	10.0	16.9	2.9
60-64	856	442	414	55	51	4	6.4	11.5	1.0
65-69	709	329	380	15	12	3	2.1	3.6	0.8
70-74	715	290	425	11	4	7	1.5	1.4	1.6
75-79	511	214	297	4	1	3	0.8	0.5	1.0
80-84	244	87	157	1	1	0	0.4	1.1	0.0
85 +	192	48	144	1	0	1	0.5	0.0	0.7

Дорноговь аймгийн суурин хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 4.9 байна (Хүснэгт 5.4). Энэ нь улсын төвшинтэй (4.3%) бараг адилхан байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд эрэгтэйчүүд (5.5%) эмэгтэйчүүдээс (4.3%) 1.2 пунктээр илүү шилжин ирсэн байна. Нас, хүйсээр ангилан үзэхэд 20-24 насны эрэгтэйчүүд (14.4%) Дорноговь аймаг руу хамгийн их шилжин ирсэн байна. Энэ нь Дорноговь аймагт аж үйлдвэрийн цогцолбор байгуулах гэж байгаатай холбоотой байж болно. Үүний дараа 20-24 насны эмэгтэйчүүд (11.6%) орж байна. Ерөнхийдөө Дорноговь аймаг руу шилжих хөдөлгөөн зөвхөн 15-29 насны залуучуудын хувьд өндөр байна.

ХҮСНЭГТ 4.4 ДОРНОГОВЬ АЙМГИЙН СУУРИН ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН
ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	57 930	29 230	28 700	2 847	1 619	1 228	4.9	5.5	4.3
0-4	6 688	3 386	3 302	255	138	117	3.8	4.1	3.5
5-9	5 116	2 530	2 586	127	59	68	2.5	2.3	2.6
10-14	5 315	2 611	2 704	112	65	47	2.1	2.5	1.7
15-19	4 698	2 349	2 349	339	144	195	7.2	6.1	8.3
20-24	5 780	2 991	2 789	755	432	323	13.1	14.4	11.6
25-29	5 974	3 244	2 730	382	217	165	6.4	6.7	6.0
30-34	5 343	2 768	2 575	239	162	77	4.5	5.9	3.0
35-39	4 563	2 346	2 217	199	127	72	4.4	5.4	3.2
40-44	3 969	2 010	1 959	175	116	59	4.4	5.8	3.0
45-49	3 513	1 770	1 743	132	80	52	3.8	4.5	3.0
50-54	2 644	1 318	1 326	63	44	19	2.4	3.3	1.4
55-59	1 527	760	767	29	19	10	1.9	2.5	1.3
60-64	893	430	463	20	11	9	2.2	2.6	1.9
65-69	640	286	354	5	1	4	0.8	0.3	1.1
70-74	603	241	362	9	3	6	1.5	1.2	1.7
75-79	381	120	261	2	-	2	0.5	-	0.8
80-84	161	47	114	3	1	2	1.9	2.1	1.8
85 +	122	23	99	1	-	1	0.8	-	1.0

Товч дүгнэхэд сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөнийг нас хүйсээр үзэхэд 2000 оныхтой төстэй Улаанбаатар хот руу чиглэсэн урсгалд 15-19 эмэгтэйчүүд давамгайлж, бусад насанд эрэгтэйчүүд давамгайлж байна. Харин шинээр бий болсон Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалд 40-44 насны эрэгтэйчүүд (39.2%) хамгийн их оролцож байгаа нь улсын хэмжээнд хамгийн өндөр байна. Ерөнхийдөө Өмнөговь аймаг руу чиглэсэн урсгалд бүх насны эрчүүд давамгайлж байна. Харин нөгөө талд нь 20-29 насны эмэгтэйчүүд бусад насны эмэгтэйчүүдийг бодоход Өмнөговь аймагт очиж амьдрах нь илүү байгаа нь сонирхол татаж байна. Дорноговь аймгийн хувьд том бүтээн байгуулалт дөнгөж эхлэлийн төдий байгаа нь тодорхой байна. Нас, хүйсээр ангилан үзэхэд зөвхөн 20-24 насны эрэгтэйчүүд Дорноговь аймаг руу шилжин ирэх нь хамгийн их байна.

4.2 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Боловсрол сайтай, цаашид үргэлжлүүлэн ахиулах сонирхолтой хүмүүс шилжих хөдөлгөөнд орох нь илүү байдаг. Монгол Улсын хувьд мал дээр гарсан, боловсрол эзэмшээгүй малчид, малгүй болохоороо шилжих хөдөлгөөнд орж байгаа дүр төрх 2000 оны тооллогын үр дүнгээс харагдаж байсан. Харин 2010 оны тооллогоор сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 4.3 байхад боловсролгүй хүнийх 2.4 хувь байгаа нь боловсролгүй хүмүүс, боловсролтой хүмүүстэй харьцуулахад шилжих хөдөлгөөнд орох нь бага байгааг харуулж байна (Хүснэгт 5.5). Боловсролгүй хүн дотор бичиг үсгийн мэдлэггүй хүн бичиг үсгийн мэдлэгтэй хүнийг бодвол шилжих хөдөлгөөнд орох нь илүү бага байна. Бичиг үсгийн мэдлэгтэй эрэгтэйчүүд (2.9%) эмэгтэйчүүдийг (2.1%) бодвол сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орох нь илүү байна. Энэ дүр төрх нь 2000 оныхтой төстэй байна⁸.

ХҮСНЭГТ 4.5 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Бичиг үсэг тайлагдалт	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	81 672	43 919	37 753	1 947	1 161	786	2.4	2.6	2.1
Бичиг үсэг мэддэг	48 451	26 811	21 640	1 241	777	464	2.6	2.9	2.1
Бичиг үсэг мэддэггүй	33 221	17 108	16 113	706	384	322	2.1	2.2	2.0

Арван тав, түүнээс дээш насны боловсролгүй хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь улсын төвшинд 2.4 байхад Улаанбаатар хотынх 7.2 хувь байгаа нь Улаанбаатар хотод боловсролгүй хүмүүс шилжин ирэх нь илүү байгааг харуулж байна (Хүснэгт 5.6). Улаанбаатар хотод бичиг үсгийн мэдлэгтэй хүмүүс шилжин ирэх нь бичиг үсгийн мэдлэггүй хүмүүсийг бодвол илүү байна. Бичиг үсгийн мэдлэгтэй эрэгтэйчүүд (8.4%) эмэгтэйчүүдийг (8.0%) бодвол сүүлчийн нэг жилд Улаанбаатар хотод ихээр шилжин ирсэн байна. Энэ нь 2000 онд бичиг үсгийн мэдлэгтэй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орох нь адилхан⁹ байснаас ялимгүй өөр байна.

ХҮСНЭГТ 4.6 УЛААНБААТАР ХОТЫН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Бичиг үсэг тайлагдалт	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	10 392	5 255	5 137	744	373	371	7.2	7.1	7.2
Бичиг үсэг мэддэг	5 495	2 762	2 733	451	232	219	8.2	8.4	8.0
Бичиг үсэг мэддэггүй	4 897	2 493	2 404	293	141	152	6.0	5.7	6.3

⁷ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 38

⁸ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 56

Арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчидийн эзлэх хувь улсын төвшинд 2.4 хувь байхад Өмнөговь аймагт ялимгүй өндөр 3.6 хувь байна (Хүснэгт 5.7). Боловсролгүй хүн дотор бичиг үсгийн мэдлэгтэй хүмүүс, бичиг үсгийн мэдлэггүй хүмүүсийг бодвол Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэх нь илүү байна. Бичиг үсгийн мэдлэгтэй эрэгтэйчүүд (5.5%) эмэгтэйчүүдийг (1.2%) бодвол сүүлчийн нэг жилд Өмнөговь аймагт шилжин ирэх нь илүү байна. Энэ нь “мал аж ахуйн салбараас уул уурхайн салбар руу” чиглэсэн урсгал бий болсныг харуулж байна.

**ХҮСНЭГТ 4.7 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ
БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ,
БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН**

Бичиг үсэг тайлагдалт	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	2 297	1 306	991	83	68	15	3.6	5.2	1.5
Бичиг үсэг мэддэг	1 553	897	656	57	49	8	3.7	5.5	1.2
Бичиг үсэг мэддэггүй	744	409	335	26	19	7	3.5	4.6	2.1

Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны боловсролгүй хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчидийн эзлэх хувь улсын төвшинийхөөс (2.4%) ялимгүй өндөр, 3.1 хувь байна (Хүснэгт 5.8). Боловсролгүй хүн дотроо бичиг үсгийн мэдлэгтэй хүмүүс, бичиг үсгийн мэдлэггүй хүмүүсийг бодвол шилжих хөдөлгөөнд орох нь илүү их байна. Бичиг үсгийн мэдлэгтэй эрэгтэйчүүд (5.5%) эмэгтэйчүүдийг (1.8%) бодвол сүүлчийн нэг жилд Дорноговь аймагт шилжин ирэх нь илүү байна. Энэ нь “мал аж ахуйн салбараас шинэ бүтээн байгуулалт руу” чиглэсэн урсгал бага ч гэсэн бий болсныг харуулж байна.

**ХҮСНЭГТ 4.8 ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ
БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ,
БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН**

Бичиг үсэг тайлагдалт	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	1 965	1 151	814	61	47	14	3.1	4.1	1.7
Бичиг үсэг мэддэг	1 141	693	448	46	38	8	4.0	5.5	1.8
Бичиг үсэг мэддэггүй	824	458	366	15	9	6	1.8	2.0	1.6


Товч дүгнэхэд боловсролгүй хүмүүсийн сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөнөөс малгүй болсон малчид хэд хэдэн чиглэлд амьжиргаагаа шинээр хайж байгаа дүр төрх харагдаж байна. 2000 оны тооллогоор малгүй болсон малчид Улаанбаатар хот руу чиглэсэн урсгалд голчлон орж байсан бол 2010 оны тооллогын дүнгээр үүнээс гадна “мал аж ахуйн салбараас уул уурхайн салбар руу” чиглэсэн урсгалд орж байна. Шинэ бүтээн байгуулалт бий болж байгаа Дорноговь аймаг руу боловсролгүй хүмүүс шилжин суурьших нь улсын төвшнөөс арай өндөр байна.

4.3 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВШИН

Ерөнхий боловсролын сургууль төгссөн залуучууд ялангуяа, эмэгтэйчүүд Улаанбаатар хотод сургуульд үргэлжлүүлэн сурахаар илүү их ирдэг дүр төрх 2000 оны тооллогын үр дүнгээр харагдаж байсан. Цаашид суралцах нь Монгол улсын хувьд шилжих хөдөлгөөнд оролцох нэг чухал шалтгаан болдог дүр төрх 2010 оны тооллогоор мөн ажиглагдаж байна.

Арван тав, түүнээс дээш насны суурин хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 5.1 байна (Зураг 5.1, Хүснэгт 5.9). 2000 оны тооллогын үр дүнгээс харахад боловсролын төвшин өсөх тутам шилжин ирэгчдийн эзлэх хувь өсч байсан⁹. 2010 оны тооллогын үр дүнгээс харахад бүрэн дунд (6.8%), дээд боловсролтой (5.4%) хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байна. Эдгээрийн дараа суурь (3.9%), техник мэргэжил (3.6%), тусгай дунд (3.2%), бага (2.6%) боловсролтой хүмүүс орж байна. Боловсролын бүх төвшинд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс шилжих хөдөлгөөнд орох нь илүү байна. Энэ нь 2000 онд цаашид суралцах урсгалд охид давамгайлж байснаас ялгаатай байна.

ЗУРАГ 4.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙСЭЭР, 2010 ОН



⁹ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 38


ХҮСНЭГТ 4.9 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Боловсролын төвшин	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 824 297	893 352	930 945	93 342	50 262	43 080	5.12	5.63	4.63
Дээд	392 572	162 332	230 240	21 166	9 673	11 493	5.39	5.96	4.99
Тусгай мэргэжлийн дунд	122 997	48 341	74 656	3 992	2 067	1 925	3.25	4.28	2.58
Техник болон мэргэжлийн	60 308	32 267	28 041	2 143	1 414	729	3.55	4.38	2.60
Бүрэн дунд	685 935	340 194	345 741	46 740	24 630	22 110	6.81	7.24	6.39
Суурь	366 546	206 057	160 489	14 183	9 409	4 774	3.87	4.57	2.97
Бага	195 939	104 161	91 778	5 118	3 069	2 049	2.61	2.95	2.23

Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.9 хувь байна (Зураг 5.2, Хүснэгт 5.10). Энэ нь улсын дунджаас (5.1%) өндөр байна. 2000 оны тооллогоор боловсролын төвшин өсөх тутам Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өсч байсан¹⁰. Харин 2010 оны тооллогын үр дүнгээс харахад боловсролын төвшин буурах тутам Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь ерөнхийдөө өсч байна. Өөрөөр хэлбэл боловсрол багатай хүмүүс Улаанбаатар хотод амьдрахаар ирэх нь улам бүр ихсэж байна. Гэхдээ Улаанбаатар хотын бүрэн дунд боловсролтой хүмүүсийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (7.8%) хамгийн өндөр байна. Энэ нь ерөнхий боловсролын сургууль төгссөн залуучууд Улаанбаатар хотод цаашид суралцахаар ирсэнтэй холбоотой. Үүний дараа бага (7.1%), суурь (3.9%), техник мэргэжил (4.1%), дээд (3.6%), тусгай дунд (3.3%) боловсролтой хүмүүс орж байна. Бүрэн дунд боловсролоос бусад боловсролын бүх төвшинд эрэгтэйчүүд Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэх нь эмэгтэйчүүдээс илүү байна. 2000 онд цаашид суралцах урсгалд охид давамгайлж байсан дүр төрх өөрчлөгдөж 2010 онд уг урсгалд охид, хөвгүүд бараг адилхан оролцож байна.

¹⁰ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 57


ЗУРАГ 4.2 УЛААНБААТАР ХОТЫН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙСЭЭР, 2010 ОН



ХҮСНЭГТ 4.10 УЛААНБААТАР ХОТЫН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Боловсролын төвшин	2010 онд шилжин ирэгчид								
	Бүгд			Тоо			Хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	861 468	409 680	451 788	50 913	24 990	25 923	5.9	6.1	5.7
Дээд	258 925	108 499	150 426	9 356	3 906	5 450	3.6	3.6	3.6
Тусгай мэргэжлийн дунд	61 108	24 867	36 241	1 998	927	1 071	3.3	3.7	3.0
Техник болон мэргэжлийн	20 061	11 083	8 978	826	482	344	4.1	4.3	3.8
Бүрэн дунд	389 142	193 019	196 123	30 509	15 021	15 488	7.8	7.8	7.9
Суурь	99 992	56 895	43 097	5 944	3 500	2 444	5.9	6.2	5.7
Бага	32 240	15 317	16 923	2 280	1 154	1 126	7.1	7.5	6.7

ЗУРАГ 4.3 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙСЭЭР, 2010 ОН




Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 22.9 хувь байна (Зураг 5.3, Хүснэгт 5.11). Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь дээд (34.4%), бүрэн дунд боловсролтой (30.0%) хүмүүсийн хувьд хамгийн өндөр байна. Өмнөговь аймагт 2010 онд амьдарч байгаа дээд, бүрэн дунд боловсролтой хүмүүсийн бараг гуравны нэг нь сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байна. Энэ дүр төрх нь улсын хэмжээний дүр төрхтэй адилхан байгаа нь Өмнөговь аймгийн сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөн улсын хэмжээний шилжих хөдөлгөөнд нөлөө үзүүлэхүйц өндөр төвшинд байгааг харуулж байна. Үүний дараа тусгай дунд (19.6%), суурь (18.5%), техник мэргэжил (14.4%), бага (7.5%) боловсролтой хүмүүс орж байна. Уул уурхайн салбарт тусгай болон техникийн мэргэжилтэй хүмүүс биш харин бүрэн дунд боловсролтой хүмүүс очиж ажиллаж байгаа дүр төрх харагдаж байна. Боловсролын бүх төвшинд Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийн хувьд эмэгтэйчүүдээс хэд дахин өндөр байна. Дээд боловсролтой эрэгтэй шилжин ирэгчдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс хоёр дахин өндөр байгаа нь хамгийн бага ялгаа юм.

ХҮСНЭГТ 4.11 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД
НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН,
ХҮЙСЭЭР, 2010 ОН

Боловсролын төвшин	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	42 925	25 625	17 300	9 828	8 361	1 467	22.9	32.6	8.5
Дээд	7 201	3 780	3 421	2 477	1 754	723	34.4	46.4	21.1
Тусгай мэргэжлийн дунд	2 339	1 108	1 231	458	373	85	19.6	33.7	6.9
Техник болон мэргэжлийн	1 740	949	791	250	219	31	14.4	23.1	3.9
Бүрэн дунд	12 713	8 104	4 609	3 820	3 381	439	30.0	41.7	9.5
Суурь	12 725	8 147	4 578	2 355	2 209	146	18.5	27.1	3.2
Бага	6 207	3 537	2 670	468	425	43	7.5	12.0	1.6

Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.9 хувь байгаа нь улсын төвшинтэй (5.1%) ойролцоо байна (Зураг 5.4, Хүснэгт 5.12). Сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь дээд (10.7%), бүрэн дунд боловсролтой (7.5%) хүмүүс хамгийн өндөр байна. Дорноговь аймагт 2010 онд амьдарч байгаа дээд боловсролтой хүмүүсийн аравны нэг нь сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байна. Үүний дараа техник мэргэжил (5.1%), тусгай дунд (4.2%), суурь (3.2%), бага (2.4%) боловсролтой хүмүүс орж байна. Бүрэн дунд боловсролтой хүмүүсийг эс тооцвол Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь боловсролын төвшин өсөх тутам өсч, Дорноговь аймаг руу боловсрол сайтай хүмүүс шилжин очиж байгаа дүр төрх харагдаж байна. Мөн түүнчлэн сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь техник мэргэжлийн боловсролтой эрэгтэйчүүдийн (7.5%) хувьд өндөр байгаа нь мэргэжилтэй ажилчид Дорноговь аймагт шилжин очиж байгааг харуулж байна. Боловсролын бүх төвшинд Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийн хувьд эмэгтэйчүүдээс өндөр байна. Гэхдээ хүйсийн ялгаа боловсролын төвшин багасах тутам багасч байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн хүйсийн ялгаа техник мэргэжлийн боловсролтой хүмүүсийн хувьд хамгийн их байна. Аж үйлдвэрийн том төв болохоор төлөвлөж байгаа Сайншанд хотод эрэгтэйчүүд ялангуяа, техник мэргэжлийн боловсролтой эрэгтэйчүүд олноор шилжин очиж байгаа нь аж үйлдвэрийн хөгжлийн эхлэл тавигдаж байгааг бага ч гэсэн харуулж байна.

ЗУРАГ 4.4 ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ
ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙСЭЭР, 2010 ОН



ХҮСНЭГТ 4.12 ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД
НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН,
ХҮЙСЭЭР, 2010 ОН

Боловсролын төвшин	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	38 846	19 552	19 294	2292	1310	982	5.9	6.7	5.1
Дээд	6 554	2 515	4 039	700	335	365	10.7	13.3	9.0
Тусгай мэргэжлийн дунд	2 802	1 084	1 718	118	67	51	4.2	6.2	3.0
Техник болон мэргэжлийн	1 567	852	715	80	64	16	5.1	7.5	2.2
Бүрэн дунд	12 515	6 175	6 340	936	520	416	7.5	8.4	6.6
Суурь	10 763	6 337	4 426	345	243	102	3.2	3.8	2.3
Бага	4 645	2 589	2 056	113	81	32	2.4	3.1	1.6

Монгол Улсын арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь дээд, бүрэн дунд боловсролтой хүмүүсийн дунд хамгийн өндөр байгаа нь Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөн улсын төвшинд нөлөөлж байгааг харуулж байна. Улаанбаатар хотын хувьд 2000 оны тооллогоор гарсан сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний боловсролын төвшингөөр ялгаатай байдлын дүр төрх өөрчлөгдөж, 2010 онд боловсролын төвшин буурах тутам сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өсч байгаа нь Улаанбаатар хотод боловсрол муутай хүмүүс шилжин ирэх нь улам бүр нэмэгдэж байгааг харуулж байна. Харин Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь боловсролын төвшин өсөх тутам өсч, мөн техник мэргэжлийн боловсролтой эрэгтэйчүүд шилжин очих нь их байгаа нь Сайншанд хот аж

үйлдвэрийн төв болох эхлэл зарим талаар тавигдсан болохыг харуулж байна. Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний аль ч урсгалд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс илүү оролцож байна. Гэхдээ хүйсийн ялгаа Өмнөговь аймаг руу чиглэсэн урсгалд маш өндөр, голчлон эрчүүд шилжин очиж байгаа нь уул уурхайн салбар хүйсийн ялгаатай салбар болохыг давхар нотолж байна.

4.4 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Ерөнхийдөө гэр бүлгүй залуучууд шилжих хөдөлгөөнд орох нь илүү байдаг. Монгол Улсад арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 5.0 байхад огт гэр бүл болоогүй хүнийх 7.9 хувь байгаа нь дээрх дүгнэлтийг нотолж байна (Хүснэгт 5.13). Огт гэр бүл болоогүй хүмүүсийн дараа батлуулаагүй гэр бүлтэй хүмүүс (5.9%) орж байна. Огт гэр бүл болоогүй, батлуулаагүй гэр бүлтэй залуучууд шилжих хөдөлгөөнд бусдаас илүү орж байна. Хүйсийн ялгааг авч үзэхэд огт гэр бүл болоогүй эмэгтэйчүүд, охид, эрэгтэйчүүд, хөвгүүдээс шилжих хөдөлгөөнд орох нь ялимгүй илүү байна. Энэ нь эмэгтэйчүүд гэр бүл болохоос сургуульд сурахыг илүүд үздэгийг харуулж байна.

ХҮСНЭГТ 4.13 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Гэр бүлийн байдал	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 905 969	937 271	968 698	95 289	51 423	43 866	5.0	5.5	4.5
Огт гэр бүл болоогүй	596 085	322 497	273 588	46 946	25 025	21 921	7.9	7.8	8.0
Батлуулсан гэр бүлтэй	987 575	492 568	495 007	34 448	20 204	14 244	3.5	4.1	2.9
Батлуулаагүй гэр бүлтэй	158 663	76 375	82 288	9 370	4 682	4 688	5.9	6.1	5.7
Тусгаарласан	23 660	10 221	13 439	854	429	425	3.6	4.2	3.2
Цуцалсан	35 347	14 951	20 396	1 208	573	635	3.4	3.8	3.1
Бэлбэсэн	104 639	20 659	83 980	2 463	510	1 953	2.4	2.5	2.3

Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.9 хувь байна (Хүснэгт 5.14). Энэ нь улсын дундаж төвшнийхээс (5.0%) 0.9 пунктээр илүү байна. Улаанбаатар хотын огт гэр бүл болоогүй хүмүүст сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 9.5 хувь байгаа нь улсын төвшнийхээс (7.9%) өндөр байна. Огт гэр бүл болоогүй хүмүүсийн дараа батлуулаагүй гэр бүлтэй хүмүүс (5.2%) орж байна. Ийнхүү Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнд огт гэр бүл болоогүй хүмүүс бусдаас их орж байна. Хүйсийн ялгааг авч үзэхэд огт гэр бүл болоогүй эмэгтэйчүүд (9.8%), эрэгтэйчүүдээс (9.2%) Улаанбаатар хотод шилжин ирэх нь 0.6 пунктээр илүү байна. Энэ нь огт гэр бүл болоогүй залуучууд ерөнхий боловсролын дунд сургууль төгсөгчид Улаанбаатар хотод цаашид суралцахаар ирж байгаа, үүн дотроо эмэгтэйчүүд, охид эрэгтэйчүүд, хөвгүүдийг бодвол суралцахаар ирэх нь арай илүү байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 4.14 УЛААНБААТАР ХОТЫН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД
НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ,
ХҮЙСЭЭР, 2010 ОН

Гэр бүлийн байдал	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	871 860	414 935	456 925	51 657	25 363	26 294	5.9	6.1	5.8
Огт гэр бүл болоогүй	303 772	154 868	148 904	28 716	14 183	14 533	9.5	9.2	9.8
Батлуулсан гэр бүлтэй	398 951	194 983	203 968	15 424	8 059	7 365	3.9	4.1	3.6
Батлуулаагүй гэр бүлтэй	95 177	44 941	50 236	4 934	2 389	2 545	5.2	5.3	5.1
Тусгаарласан	12 989	5 086	7 903	452	202	250	3.5	4.0	3.2
Цуцалсан	19 477	7 632	11 845	627	243	384	3.2	3.2	3.2
Бэлбэсэн	41 494	7 425	34 069	1 504	287	1 217	3.6	3.9	3.6

Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 21.9 хувь байхад огт гэр бүл болоогүй хүмүүсийнх 24.5 хувь байгаа нь арай илүү байна (Хүснэгт 5.15). Огт гэр бүл болоогүй хүмүүсийн дараа батлуулаагүй гэр бүлтэй биш харин батлуулсан гэр бүлтэй (24.0%) хүмүүс орж байгаа нь улсын төвшин, Улаанбаатар хотын байдлаас өөр байна. Өмнөговь аймагт эсвэл огт гэр бүл болоогүй залуу хүмүүс эсвэл батлуулсан гэр бүлтэй, амьдрал нь тогтсон хүмүүс шилжин очиж байна. Огт гэр бүл болоогүй болон батлуулсан гэр бүлтэй хүмүүсийн дараа цуцалсан (17.6%) болон батлуулаагүй гэр бүлтэй (14.6%) хүмүүс орж байгаа нь улсын төвшин болон Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнөөс өндөр байна. Харин тусгаарласан (8.9%) болон бэлбэсэн (2.8%) хүмүүс Өмнөговь аймаг руу шилжих нь бага байна. Хүйсийн ялгааг авч үзэхэд гэр бүлийн байдлыг үл харгалзан Өмнөговь аймаг руу чиглэсэн урсгалд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бараг 3-4 дахин давамгайлж байна. Гэхдээ огт гэрлээгүй хүмүүсийн хувьд хүйсийн ялгаа хамгийн бага байна. Огт гэр бүл болоогүй залуу эмэгтэйчүүд Өмнөговь аймаг руу шилжих нь, огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдээс бага байгаа ч гэр бүл болсон нас ахисан эмэгтэйчүүдээс илүү байна. Эндээс харахад Өмнөговь аймагт өрнөж байгаа уул уурхайн салбарын хөгжилтэй холбоотой бүтээн байгуулалтад оролцохоор зөвхөн ганц бие залуучууд төдийгүй гэр бүлтэй хүмүүс ялангуяа, гэр бүлтэй эрэгтэйчүүд олноороо очиж ажиллаж байна.

ХҮСНЭГТ 4.15 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД
НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ,
ХҮЙСЭЭР, 2010 ОН

Гэр бүлийн байдал	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	45 222	26 931	18 291	9 911	8 429	1 482	21.9	31.3	8.1
Огт гэр бүл болоогүй	12 092	7 930	4 162	2 967	2 443	524	24.5	30.8	12.6
Батлуулсан гэр бүлтэй	24 899	15 280	9 619	5 968	5 296	672	24.0	34.7	7.0
Батлуулаагүй гэр бүлтэй	4 997	2 646	2 351	729	522	207	14.6	19.7	8.8
Тусгаарласан	630	297	333	56	42	14	8.9	14.1	4.2
Цуцалсан	800	398	402	141	104	37	17.6	26.1	9.2
Бэлбэсэн	1 804	380	1 424	50	22	28	2.8	5.8	2.0

Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.8 хувь байхад огт гэр бүл болоогүй хүмүүсийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 8.3 хувь байгаа нь огт гэр бүл болоогүй хүмүүс Дорноговь аймаг руу шилжин очих нь илүү байгааг харуулж байна (Хүснэгт 5.16). Огт гэр бүл болоогүй хүмүүсийн дараа батлуулаагүй гэр бүлтэй (7.2%) хүмүүс орж байгаа нь улсын төвшний дүр төрхтэй адил байна. Харин батлуулсан гэр бүлтэй (4.7%) болон цуцалсан (4.7%) хүмүүс Дорноговь аймаг руу шилжих нь бага, тусгаарласан (3.0%) болон бэлбэсэн (1.8%) хүмүүс шилжих нь бага байна. Хүйсийн ялгааг авч үзэхэд гэр бүлийн байдлыг үл харгалзан эрэгтэйчүүд Дорноговь аймаг руу шилжин очих нь эмэгтэйчүүдээс илүү байна. Гэхдээ Дорноговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалын хүйсийн ялгаа Өмнөговь аймгийнхаас бага байна. Эдгээрээс харахад Дорноговь аймагт аж үйлдвэрийн парк баригдах бүтээн байгуулалтын ажил эхлэлийн төдий байгаа ч огт гэр бүл болоогүй болон батлуулаагүй гэр бүлтэй залуучууд бусдаас олноор очиж байгаа нь бүтээн байгуулалтын ажиллагаа зарим талаар эхэлснийг харуулж байна.

ХҮСНЭГТ 4.16 ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД
НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ,
ХҮЙСЭЭР, 2010 ОН

Гэр бүлийн байдал	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	40 811	20 703	20 108	2 353	1 357	996	5.8	6.6	5.0
Огт гэр бүл болоогүй	10 966	6 385	4 581	906	533	373	8.3	8.3	8.1
Батлуулсан гэр бүлтэй	21 822	10 997	10 825	1 020	597	423	4.7	5.4	3.9
Батлуулаагүй гэр бүлтэй	4 629	2 282	2 347	334	190	144	7.2	8.3	6.1
Тусгаарласан	535	297	238	16	10	6	3.0	3.4	2.5
Цуцалсан	856	386	470	40	18	22	4.7	4.7	4.7
Бэлбэсэн	2 003	356	1 647	37	9	28	1.8	2.5	1.7

Товч дүгнэхэд улсын хэмжээнд огт гэр бүл болоогүй болон батлуулаагүй гэр бүлтэй залуучууд сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орох нь бусдаас илүү байна. Улаанбаатар хотын хувьд огт гэр бүл болоогүй болон батлуулаагүй гэр бүлтэй хүмүүсийн дунд эмэгтэйчүүд давамгайлж байгаа нь Улаанбаатар хотод цаашид суралцах залуучууд, тэр дундаа эмэгтэйчүүд, охид илүү ирж байгааг харууллаа. Харин Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийх арай өөр эрэгтэйчүүд зонхилж байна. Гэхдээ огт гэр бүл болоогүй эмэгтэйчүүд Өмнөговь руу арай илүү шилжиж байна. Дорноговь аймагт аж үйлдвэрийн цогцолборын байгуулах гэж байгаатай холбоотойгоор огт гэр бүл болоогүй болон батлуулаагүй гэр бүлтэй залуучууд очих нь бусдаас илүү байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ,
АЖИЛГҮЙДЭЛ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААН



5.1 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, АЖИЛГҮЙДЭЛ

Хүмүүс шилжих хөдөлгөөнд орох нь тэдний эдийн засгийн идэвхтэй шууд холбоотой байдаг. Шилжин суурьших нь эдийн засгийн идэвх гаргаж байгаа нэг хэлбэр юм. 2000 онд Монгол Улсад эрэгтэйчүүд ихэвчлэн ажил хайж, харин эмэгтэйчүүд үргэлжлүүлэн суралцахаар шилжих хөдөлгөөнд орж байсан¹¹. Харин 2010 онд энэ байдал арай өөр болж, эмэгтэйчүүд цаашид суралцахаас гадна ажил хайж шилжих хөдөлгөөнд орох нь илүү болсон байна.

Арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.0 хувь байхад эдийн засгийн идэвхгүй хүнийх 5.4 хувь байгаа нь цаашид суралцах хүмүүс шилжих хөдөлгөөнд орох нь бусдаас илүү байгаатай холбоотой (Хүснэгт 6.1). Харин эдийн засгийн идэвхтэй хүн дотроо ажил хайж байгаа хүмүүсийн шилжих хөдөлгөөн хамгийн өндөр (5.9%) байна.

Ажил хайж байгаа эмэгтэйчүүдийн хувьд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид (6.0%) хамгийн өндөр байна. Харин ажил эрхэлдэг эмэгтэйчүүдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид (3.1%) эрэгтэйчүүдийнхээс (5.6%) 2.5 пунктээр доогуур байна. Ажилгүй эмэгтэйчүүд сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд оролцох нь эрэгтэйчүүдээс их байгаа ч ажил олдох нь тааруу байна. Энэ нь эмэгтэйчүүд 2000 онд цаашид суралцахаар шилжих хөдөлгөөнд орох нь илүү байсан бол 2010 онд ажил хайж шилжих хөдөлгөөнд орох нь илүү болсныг харуулж байна.

ХҮСНЭГТ 5.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн идэвх	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	1 905 969	937 271	968 698	95 289	51 423	43 866	5.0	5.5	4.5
Эдийн засгийн идэвхтэй	1 075 780	590 132	485 648	50 507	33 254	17 253	4.7	5.6	3.6
Ажил эрхэлдэг	911 664	495 101	416 563	40 821	27 722	13 099	4.5	5.6	3.1
Ажил хайж байгаа	164 116	95 031	69 085	9 686	5 532	4 154	5.9	5.8	6.0
Эдийн засгийн идэвхгүй	830 189	347 139	483 050	44 782	18 169	26 613	5.4	5.2	5.5

Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.9 хувь байхад эдийн засгийн идэвхгүй хүнийх 7.3 хувь байна (Хүснэгт 6.2). Энэ нь Улаанбаатар хотод цаашид суралцах залуучууд ихээр шилжин ирдэгтэй холбоотой. Харин эдийн засгийн идэвхтэй хүн ам дотор ажил хайж байгаа хүмүүсийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (7.0%) хамгийн өндөр байгаагаас хүмүүс Улаанбаатар хотод ажил эрхлэх боломж хайж ирж байгаа нь харагдаж байна.

¹¹ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: Улаанбаатар хот, 2002 он.

Улаанбаатар хотод ажил хайж байгаа эмэгтэйчүүдийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нь эрэгтэйчүүдийнхтэй адил өндөр (7.1%) байна. Харин ажил эрхэлдэг эмэгтэйчүүдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (3.5%) эрэгтэйчүүдийнхээс (4.9%) 1.4 пунктээр доогуур байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол ажил олох нь тааруу байна.

ХҮСНЭГТ 5.2 УЛААНБААТАР ХОТЫН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн идэвх	Бүгд		2010 онд шилжин ирэгчид						
			тоо			хувь			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	871 860	414 935	456 925	51 657	25 363	26 294	5.9	6.1	5.8
Эдийн засгийн идэвхтэй	452 255	243 208	209 047	20 932	12 690	8 242	4.6	5.2	3.9
Ажил эрхэлдэг	391 523	207 521	184 002	16 661	10 200	6 461	4.3	4.9	3.5
Ажил хайж байгаа	60 732	35 687	25 045	4 271	2 490	1 781	7.0	7.0	7.1
Эдийн засгийн идэвхгүй	419 605	171 727	247 878	30 725	12 673	18 052	7.3	7.4	7.3

Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 21.9 хувь байхад эдийн засгийн идэвхгүй хүнийх дөнгөж 5.4 хувь байна (Хүснэгт 6.3). Өмнөговь аймгийн эдийн засгийн идэвхтэй хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (27.5%) эдийн засгийн идэвхгүй хүн амынхаас даруй 5 дахин их байна. Улмаар эдийн засгийн идэвхтэй хүн дотор, ажил эрхэлдэг хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр (29.6%) байна. Үүнээс үзэхэд тус аймагт ажил хайж биш харин тодорхой ажлын байрт хүмүүс шилжин очиж байна.

Өмнөговь аймагт эмэгтэйчүүдийн ажил хайж ирэх нь эрэгтэйчүүдээс илүү байна. Өмнөговь аймагт ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн дотор сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (40.0%) хувьд хамгийн өндөр байгаа нь эмэгтэйчүүдийнхээс бараг дөрөв дахин өндөр байна. Гэтэл ажил хайж байгаа хүмүүсийн хувьд эрэгтэйчүүдийн дотор сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (13.5%) эмэгтэйчүүдийнхээс (11.3%) дөнгөж 2.2 пунктээр өндөр байна. Өөрөөр хэлбэл, Өмнөговь аймагт эрэгтэйчүүд бэлэн ажлын байрт харин эмэгтэйчүүд ажил хайж очих нь илүү байна.

ХҮСНЭГТ 5.3 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн идэвх	Бүгд		2010 онд шилжин ирэгчид						
			тоо			хувь			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	45 222	26 931	18 291	9 911	8 429	1 482	21.9	31.3	8.1
Эдийн засгийн идэвхтэй	33 794	22 061	11 733	9 294	8 157	1 137	27.5	37.0	9.7
Ажил эрхэлдэг	29 652	19 507	10 145	8 770	7 812	958	29.6	40.0	9.4
Ажил хайж байгаа	4 142	2 554	1 588	524	345	179	12.7	13.5	11.3
Эдийн засгийн идэвхгүй	11 428	4 870	6 558	617	272	345	5.4	5.6	5.3

Дорноговь аймгийн эдийн засгийн идэвхтэй хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (6.2%) эдийн засгийн идэвхгүй хүн амынхаас (5.1%) 1.1 пунктээр өндөр байна (Хүснэгт 6.4). Харин эдийн засгийн идэвхтэй хүн дотор ажил хайж байгаа хүн амын дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр (7.0%) байгаа нь тус аймагт шилжих очиж байгаа хүмүүст тэр бүр ажил олдохгүй байгаа нь харагдаж байна.

Тус аймагт ажил хайж байгаа хүн амын дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь эрэгтэйчүүд (7.3%), эмэгтэйчүүдийн (6.7%) хувьд ялгаа бага байна. Харин ажил эрхэлдэг эмэгтэйчүүдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (4.0%) эрэгтэйчүүдийнхээс (7.5%) 3.5 пунктээр доогуур байна. Өөрөөр хэлбэл, энэ аймагт сүүлчийн нэг жилд ажил хайж шилжин ирэх нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй бараг ойролцоо байхад сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эдийн засгийн идэвхгүй хүн амд эмэгтэйчүүд, эдийн засгийн идэвхтэй хүн амд эрэгтэйчүүд давамгайлж байна.

ХҮСНЭГТ 5.4 ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн идэвх	Бүгд		2010 онд шилжин ирэгчид						
			тоо			хувь			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	40 811	20 703	20 108	2 353	1 357	996	5.8	6.6	5.0
Эдийн засгийн идэвхтэй	26 087	14 751	11 336	1 608	1 107	501	6.2	7.5	4.4
Ажил эрхэлдэг	22 211	12 656	9 555	1 336	955	381	6.0	7.5	4.0
Ажил хайж байгаа	3 876	2 095	1 781	272	152	120	7.0	7.3	6.7
Эдийн засгийн идэвхгүй	14 724	5 952	8 772	745	250	495	5.1	4.2	5.6

Товч дүгнэхэд 2000 онд Монгол Улсад эрэгтэйчүүд ихэвчлэн ажил хайж, харин эмэгтэйчүүд үргэлжлүүлэн суралцахаар шилжих хөдөлгөөнд орж байсан дүр төрх 2010 онд ажиглагдаж байгаа ч эмэгтэйчүүд ажил хайж шилжих хөдөлгөөнд орох нь илүү болсон байна. Гэхдээ ажил хайж байгаа ч ажил олдох боломж шилжин суурьшиж байгаа хүмүүсийн хувьд тааруу байна. Учир нь “ажил хайж байгаа” гэж хариулсан ажилгүйчүүдийн хувьд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байна. Ажил олдох боломж сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орсон эмэгтэйчүүдийн хувьд тааруу байна. Энэ дүр төрх Улаанбаатар хот, Дорноговь аймгийн хувьд бас харагдаж байна. Харин Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид ажил хайхаас бэлэн ажлын байрт ажиллахаар ирэх нь илүү байна.

5.2 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААН

Эдийн засгийн идэвхгүй хүн ам дотор цаашид суралцах хүмүүс хамгийн их хувийг эзлэхээс гадна хамгийн их шилжих хөдөлгөөнд ордог. 2010 оны тооллогоор арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амын 36.2 хувь нь сургуульд суралцаж байгаа нь хамгийн их байна. Сургуульд сурдаг, тохирох ажил олдохгүй байгаа хүмүүсийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү байхад тэтгэвэрт байгаа хүмүүсийн дунд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү байна.

Арван тав, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.4 хувь байна (Хүснэгт 6.5). Сургуульд сурдаг хүмүүсийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр (9.1%) байна. Энэ нь сургуульд сурах нь шилжих хөдөлгөөнд орох нэг голлох шалтгаан гэдгийг баталж байна. Үүний дараа гэрийн ажилтай (4.4%), тохирох ажил олдохгүй байгаа (3.8%) хүмүүс орж байна. Эдгээр гэрийн ажилтай болон тохирох ажил олдохгүй байгаа хүмүүс шилжих хөдөлгөөнд орж байгаа нь зарим талаар амьжиргааны боломж эрэлхийлж, эдийн засгийн далд идэвх үзүүлж байгааг харуулж байна. Харин ажиллах сонирхолгүй (3.5%), тэтгэвэрт байгаа (2.4%), хөдөлмөр эрхлэх чадваргүй (2.0%) хүмүүс сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орох нь хамгийн бага байна. Эдгээрээс эдийн засгийн идэвх багасах тутам шилжих хөдөлгөөнд оролцох нь багасдаг гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Эдийн засгийн идэвхгүй хүн амын сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөнийг хүйсээр авч үзэхэд сургуульд суралцдаг эмэгтэйчүүдийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (9.5%) эрэгтэйчүүдийнхээс (8.5%) ялимгүй илүү байна. Харин бусад шалтгааны улмаас эдийн засгийн идэвхгүй байгаа хүмүүсийн хувьд сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний хүйсийн ялгаа бага байна.

ХҮСНЭГТ 5.5 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн идэвхгүй хүн ам	Бүгд		2010 онд шилжин ирэгчид						
			тоо			хувь			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	830 189	347 139	483 050	44 782	18 169	26 613	5.4	5.2	5.5
Сургуульд сурдаг	300 494	136 696	163 798	27 311	11 675	15 636	9.1	8.5	9.5
Тэтгэвэрт	191 907	65 745	126 162	4 610	1 469	3 141	2.4	2.2	2.5
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	55 888	31 256	24 632	1 128	612	516	2.0	2.0	2.1
Гэрийн ажилтай	108 403	12 122	96 281	4 749	554	4 195	4.4	4.6	4.4
Тохирох ажил олдохгүй байгаа	121 519	71 856	49 663	4 557	2 686	1 871	3.8	3.7	3.8
Ажиллах сонирхолгүй	3 283	2 321	962	115	82	33	3.5	3.5	3.4
Бусад	48 695	27 143	21 552	2 312	1 091	1 221	4.7	4.0	5.7

Улаанбаатар хотын эдийн засгийн идэвхгүй хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 7.3 хувь байна (Хүснэгт 6.6). Улаанбаатар хотод сургуульд сурдаг хүмүүсийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (11.5%) хамгийн өндөр байгаа нь улсын төвшнийхээс (9.1%) өндөр байна. Энэ нь сургуульд сурах нь Улаанбаатар хотод шилжин ирэх нэг шалтгаан болохыг харуулж байна. Үүний дараа гэрийн ажилтай (4.9%), тохирох ажил олдохгүй байгаа (4.6%) хүмүүс орж байна. Эдгээр нь улсын төвшнийхээс өндөр байна. Зарим талаар тэд амьжиргааны боломж эрэлхийлж, эдийн засгийн далд идэвх гаргаж Улаанбаатар хотод ирснийг харуулж байна. Харин ажиллах сонирхолгүй (3.9%), тэтгэвэрт байгаа (3.6%), хөдөлмөр эрхлэх чадваргүй (2.9%) хүмүүс Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэх нь хамгийн бага байна. Эдгээрээс эдийн засгийн идэвх багасах тутам Улаанбаатар хотод шилжин ирэх нь багасч байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Хүйсээр ангилан үзэхэд эмэгтэйчүүд (11.7%) Улаанбаатар хотод сургуульд суралцахаар шилжин ирэх нь эрэгтэйчүүдээс (11.2%) ялимгүй буюу 0.5 пунктээр илүү байна. 2000 онд Улаанбаатар хотод охид хөвгүүдийг бодвол суралцахаар ирэх нь илүү байсан дүр төрх¹² бага хэмжээгээр ч гэсэн хадгалагдаж байна. Харин Улаанбаатар хотод тохирох ажил олдохгүй байгаа болон бусад шалтгааны улмаас эдийн засгийн идэвхгүй байгаа хүмүүсийн сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөнд хүйсийн ялгаа бараг байхгүй байна.

ХҮСНЭГТ 5.6 УЛААНБААТАР ХОТЫН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн идэвхгүй хүн ам	Бүгд		2010 онд шилжин ирэгчид						
			тоо			хувь			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	419 605	171 727	247 878	30 725	12 673	18 052	7.3	7.4	7.3
Сургуульд сурдаг	177 974	80 417	97 557	20 440	8 990	11 450	11.5	11.2	11.7
Тэтгэвэрт	85 279	29 671	55 608	3 110	966	2 144	3.6	3.3	3.9
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	22 636	12 685	9 951	661	349	312	2.9	2.8	3.1
Гэрийн ажилтай	58 050	6 335	51 715	2 850	352	2 498	4.9	5.6	4.8
Тохирох ажил олдохгүй байгаа	47 215	27 924	19 291	2 175	1 281	894	4.6	4.6	4.6
Ажиллах сонирхолгүй	1 598	1 126	472	63	46	17	3.9	4.1	3.6
Бусад	26 853	13 569	13 284	1 426	689	737	5.3	5.1	5.5

Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 21.9 хувь байхад эдийн засгийн идэвхгүй хүнийх (7.3 хувь) бараг гурав дахин бага байна (Хүснэгт 6.7). Өмнөговь аймгийн эдийн засгийн идэвхгүй хүн дотор, “бусад”-ыг эс тооцвол, “ажиллах сонирхолгүй” (13.8%) хүмүүсийн дунд сүүлчийн нэг жилд

¹² Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 71

шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байгаа нь анхаарал татаж байна. Уул уурхайн салбарын хөгжлийг дагасан урсгалд “ажиллах сонирхолгүй” хүмүүс байна. Үүний дараа гэрийн ажилтай (8.0%), тохирох ажил олдохгүй байгаа (6.2%) хүмүүс орж байна. Эдгээрээс Өмнөговь аймагт очсон хүн болгон өөртөө тохирох ажил олж чадахгүй байгааг харуулж байна. Харин тэтгэвэрийн (1.3%), хөдөлмөр эрхлэх чадваргүй (3.0%) хүмүүс Өмнөговь аймагт шилжин ирэх нь бага байна. Гэхдээ “ажиллах сонирхолгүй” хүмүүсийн шилжих хөдөлгөөн хамгийн их байгаа учир эдийн засгийн идэвх багасах тутам Өмнөговь аймаг руу шилжих нь багасч байна гэсэн дүгнэлт хийх боломжгүй юм.

Хүйсээр ангилан үзэхэд бүр их сонирхолтой дүр зураг ажиглагдана. “Ажиллах сонирхолгүй” эмэгтэйчүүд (22.7%) Өмнөговь аймагт шилжин ирэх нь эрэгтэйчүүдээс (10.8%) хоёр дахин илүү байна. Өмнөговь аймагт уул уурхайн салбарт ажиллах гэж ирж байгаа эрчүүдийн урсгалын зэрэгцээ “гэрийн ажилтай” эмэгтэйчүүдийн урсгалаас гадна “ажиллах сонирхолгүй” эмэгтэйчүүдийн урсгал бас дагалдаж байна. Өмнөговь аймагт “тохирох ажил олдохгүй байгаа” эмэгтэйчүүдийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (6.4%) эрэгтэйчүүдийнхээс (6.0%) ялимгүй өндөр байна. Гэрийн ажилтай, ажил хийх сонирхолгүй эмэгтэйчүүдээс гадна ажил хайж байгаа эмэгтэйчүүд харьцангуй бага ч гэсэн Өмнөговь аймагт байна.

ХҮСНЭГТ 5.7 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн идэвхгүй хүн ам	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	11 428	4 870	6 558	617	272	345	5.4	5.6	5.3
Сургуульд сурдаг	2 952	1 439	1 513	172	72	100	5.8	5.0	6.6
Тэтгэвэрт	3 480	1 157	2 323	46	19	27	1.3	1.6	1.2
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	741	423	318	22	12	10	3.0	2.8	3.1
Гэрийн ажилтай	1 592	198	1 394	128	23	105	8.0	11.6	7.5
Тохирох ажил олдохгүй байгаа	1 683	1 061	622	104	64	40	6.2	6.0	6.4
Ажиллах сонирхолгүй	87	65	22	12	7	5	13.8	10.8	22.7
Бусад	893	527	366	133	75	58	14.9	14.2	15.8

Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.8 хувь байхад эдийн засгийн идэвхгүй хүнийх 5.1 хувь байна (Хүснэгт 6.8).

ХҮСНЭГТ 5.8 ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн идэвхгүй хүн ам	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	14 724	5 952	8 772	745	250	495	5.1	4.2	5.6
Сургуульд сурдаг	4 337	1 845	2 492	362	123	239	8.3	6.7	9.6
Тэтгэвэрт	3 538	1 122	2 416	45	11	34	1.3	1.0	1.4
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	1 119	683	436	24	12	12	2.1	1.8	2.8
Гэрийн ажилтай	2 069	229	1 840	135	10	125	6.5	4.4	6.8
Тохирох ажил олдохгүй байгаа	2 209	1 256	953	104	59	45	4.7	4.7	4.7
Ажиллах сонирхолгүй	120	81	39	1	1	0	0.8	1.2	0.0
Бусад	1 332	736	596	74	34	40	5.6	4.6	6.7

Дорноговь аймагт сургуульд сурдаг хүмүүсийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (8.3%) хамгийн өндөр байгаа ч гэсэн улсын төвшнийхээс (9.1%) доогуур байна. Энэ нь сургуульд сурах нь Дорноговь аймаг руу шилжих гол шалтгаан биш гэдгийг харуулж байна. Гэрийн ажилтай (6.5%), тохирох ажил олдохгүй байгаа (4.7%) хүмүүс байна. Эдгээр нь улсын төвшнийхээс ялимгүй өндөр. Ийнхүү хүмүүс амьжиргааны боломж эрэлхийлж, эдийн засгийн далд идэвх гаргаж Дорноговь аймагт ирж байна. Харин ажиллах сонирхолгүй (0.8%), тэтгэвэрт байгаа (1.3%), хөдөлмөр эрхлэх чадваргүй (2.1%) хүмүүс Дорноговь аймагт шилжин ирэх нь бага байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн идэвх багасах тутам Дорноговь аймагт шилжин ирэх нь багасч байна.

Хүйсээр авч үзэхэд эмэгтэйчүүд (9.6%) Дорноговь аймагт сургуульд суралцахаар шилжин ирэх нь эрэгтэйчүүдээс (6.7%) 2.9 пунктээр илүү байна. 2000 оны тооллогоор охид хөвгүүдийг бодвол цаашид суралцах нь илүү байсан дүр төрх Дорноговь аймгийн хувьд хадгалагдаж байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирсэн тохирох ажил олдохгүй байгаа хүмүүсийн хувьд хүйсийн ялгаа алга байна. Харин Дорноговь аймагт "бусад" шалтгааны улмаас эдийн засгийн идэвхгүй хүмүүсийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нь хүйсийн хувьд ялгаатай тухайлбал, эмэгтэйчүүд нь (6.7%) илүү шилжин ирж байна.

Сургуульд үргэлжлүүлэн сурах нь шилжих хөдөлгөөнд орох нэг шалтгаан болж байна. Ялангуяа, Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний хувьд энэ нь гол шалтгаан юм. Харин Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний хувьд сургуульд суралцах нь гол шалтгаан биш байна. Суралцах нь охидын хувьд хөвгүүдээс илүү байдаг дүр төрх хадгалагдсаар байна.

Гэрийн ажилтай болон тохирох ажил олдохгүй хүмүүс шилжих хөдөлгөөнд харьцангуй их орж байгаа нь зарим талаар амьжиргааны боломж эрэлхийлж, эдийн засгийн далд идэвх үзүүлж байгааг харуулж байна. Харин Өмнөговь аймгийн хувьд эдийн засгийн идэвхгүй "ажил хийх сонирхолгүй" гэсэн эмэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд бусдаас илүү орж байгаа нь сонирхол татна. Уул уурхайн салбар, түүнийг дагасан бүтээн байгуулалт руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалд эрэгтэйчүүд илт давамгайлж, харин тэднийг гэрийн ажилтай эмэгтэйчүүдээс гадна "ажил хийх сонирхолгүй" эмэгтэйчүүд дагаж ирж байгаа дүр зураг харагдаж байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН АЖИЛ МЭРГЭЖИЛ, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ



6.1 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН АЖИЛ МЭРГЭЖИЛ

Тодорхой ажил мэргэжилд мэргэшээгүй хүн учраас ямар ч хамаагүй олдсон ажлыг хийж явдаг тул шилжих хөдөлгөөнд орох нь их байдаг. 2000 оны тооллогоос харахад Монгол улсад үйлдвэр, худалдаа, үйлчилгээний ажилтан бусдаас илүү шилжих хөдөлгөөнд орж байсан. Харин хөдөө аж ахуй эрхлэгчид шилжих хөдөлгөөнд орох нь харьцангуй бага байсан¹³. 2010 оны тооллогоор эл дүр төрх бүрэн хэмжээгээр хадгалагдаагүй байна.

Эрхэлсэн ажилтай хүмүүс шилжих хөдөлгөөнд орох нь харьцангуй бага байдаг. Арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.0 хувь байхад ажил эрхэлдэг хүн амынх 4.5 хувь буюу ялимгүй бага байна (Хүснэгт 7.1). Харин ажил мэргэжлээр авч үзэхэд ялгаатай байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний хүмүүсийн хувьд (8.7%) хамгийн өндөр байна. Энэ нь 2000 оны тооллогоор гарсан үр дүнтэй төстэй. Үүний дараа машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч (6.9%), энгийн ажил мэргэжил (5.8%), техникч болон туслах/дэд мэргэжилтэн (5.3%), мэргэжилтэн (4.6%) орж, дунджаас дээгүүр байна. 2000 оны тооллогоос ялгаатай байгаа нь сүүлчийн үед уул уурхайн салбар өсч байгаатай холбоотой юм.

Харин хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан (2.1%), менежер (3.4%), худалдаа, үйлчилгээ (4.0%), зэвсэгт хүчин (4.2%), контор, үйлчилгээний (4.4%) ажил мэргэжил эрхэлдэг хүмүүс сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орох нь бага байна.

Хүйсээр авч үзэхэд сүүлчийн нэг жилд ажил эрхэлдэг эрэгтэйчүүд (5.6%) шилжих хөдөлгөөнд орох нь эмэгтэйчүүдээс (3.1%) 2.5 пунктээр илүү байна. Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажил эрхэлдэг эрэгтэйчүүд (10.3%) шилжих хөдөлгөөнд орох нь ийм ажил эрхэлдэг эмэгтэйчүүдээс (4.1%) гурав дахин их байна. Шилжих хөдөлгөөн өндөр байгаа ажил мэргэжлийн хувьд хүйсийн ялгаа их байна. Өөрөөр хэлбэл, шилжих хөдөлгөөн ажил мэргэжлээр болон хүйсийн ялгаатай байдлын хооронд эерэг хамаарал байна.

ХҮСНЭГТ 6.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ МЭРГЭЖИЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Ажил мэргэжил	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	911 664	495 101	416 563	40 821	27 722	13 099	4.5	5.6	3.1
Менежер	72 187	41 090	31 097	2 453	1 698	755	3.4	4.1	2.4
Мэргэжилтэн	153 919	53 224	100 695	7 097	3 394	3 703	4.6	6.4	3.7
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	40 454	15 405	25 049	2 141	1 125	1 016	5.3	7.3	4.1
Контор, үйлчилгээний ажилтан	23 725	6 657	17 068	1 038	415	623	4.4	6.2	3.7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	134 236	53 308	80 928	5 422	2 623	2 799	4.0	4.9	3.5
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	236 308	135 595	100 713	5 048	3 201	1 847	2.1	2.4	1.8
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	85 047	63 209	21 838	7 400	6 496	904	8.7	10.3	4.1
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	79 717	73 970	5 747	5 517	5 335	182	6.9	7.2	3.2
Энгийн ажил мэргэжил	68 650	36 652	31 998	3 970	2 765	1 205	5.8	7.5	3.8
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	17 421	15 991	1 430	735	670	65	4.2	4.2	4.5

¹³ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 45

Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.9 хувь байхад ажил эрхэлдэг хүн амынх 4.3 хувь буюу 1.6 пунктээр бага байна (Хүснэгт 7.2). Улаанбаатар хотын хөдөө аж ахуй, ой, загас агнуураар мэргэшсэн ажилтаны (11.0%) хувьд арван хүний нэг нь сүүлчийн нэг жилд шилжин иржээ. 2000 оны тооллогоор үйлдвэрлэл, худалдааны ажилчид Улаанбаатар хот руу шилжиж ирэх нь хамгийн их байсан¹⁴ бол 2010 онд хөдөө аж ахуйд ажиллагсад болж өөрчлөгдсөн байна. 2010 оны тооллогоор зарим шилжин ирэгчид Улаанбаатар хотод хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа дүр төрх харагдаж байна.

Энгийн ажил мэргэжил (6.8%), үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан (6.5%) дунджаас дээгүүр байна. Харин менежер (2.5%), зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй хүмүүс (2.9%), контор, үйлчилгээний ажилчид (3.2%) сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орох нь бага байна. Эдгээрээс ажил мэргэжлийн ур чадвар, боловсролын төвшин ахих тутам Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн багасч байгаа нь харагдаж байна.

Хүйсээр авч үзэхэд сүүлчийн нэг жилд ажил эрхэлдэг эрэгтэйчүүд (4.9%) шилжих хөдөлгөөнд орох нь эмэгтэйчүүдээс (3.5%) 1.4 пунктээр илүү байна. Улаанбаатар хот руу чиглэсэн хөдөө аж ахуй, ой, загас агнуураар мэргэшсэн ажилтнаас бусад бүх ажил мэргэжлийн шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд давамгайлж байна. Харин хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажил мэргэжил, үүн дотроо малчдын шилжих хөдөлгөөнд эмэгтэйчүүд давамгайлж байгаа нь сонирхол татна.

ХҮСНЭГТ 6.2 УЛААНБААТАР ХОТЫН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ МЭРГЭЖИЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Ажил мэргэжил	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	391 523	207 521	184 002	16 661	10 200	6 461	4.3	4.9	3.5
Менежер	48 533	27 319	21 214	1 237	805	432	2.5	2.9	2.0
Мэргэжилтэн	89 124	33 611	55 513	3 046	1 300	1 746	3.4	3.9	3.1
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	22 071	8 488	13 583	872	336	536	4.0	4.0	3.9
Контор, үйлчилгээний ажилтан	13 383	3 471	9 912	432	145	287	3.2	4.2	2.9
Худалдаа, үйлчилгээний ажилтан	85 154	36 283	48 871	3 502	1 671	1 831	4.1	4.6	3.7
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	4 065	2 544	1 521	447	276	171	11.0	10.8	11.2
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	52 762	38 742	14 020	3 411	2 847	564	6.5	7.3	4.0
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	40 149	37 354	2 795	1 460	1 375	85	3.6	3.7	3.0
Энгийн ажил мэргэжил	30 587	14 712	15 875	2 090	1 297	793	6.8	8.8	5.0
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	5 695	4 997	698	164	148	16	2.9	3.0	2.3

¹⁴ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 64

Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 21.9 хувь байхад ажил эрхэлдэг хүн амынх 29.6 хувь буюу 7.7 пунктээр илүү байна (Хүснэгт 7.3). Ажил эрхлэх нь Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний гол шалтгаан болж байгаа нь харагдана. Өмнөговь аймгийн үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажил эрхэлдэг хүмүүсийн (70.1%) хувьд арван хүний долоо нь сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байна. Үүний дараа машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч (48.8%), техникч болон туслах/дэд мэргэжилтэн (35.4%), мэргэжилтэн (33.2%) орж, Өмнөговь аймгийн дунджаас дээгүүр байна. Өмнөговь аймагт уул уурхайн салбар өсч байгаатай холбоотойгоор шилжих хөдөлгөөн явагдаж байна.

Харин хөдөө аж ахуй, ой, загас агнуураар мэргэшсэн ажилтан (1.8%) сүүлчийн нэг жилд Өмнөговь аймаг руу шилжих нь бусад ажил мэргэжилтэй харьцуулахад бага байна. Энэ нь уул уурхайн салбар байгаа газар хөдөө аж ахуй эрхлэх боломж таарууг харуулж байна. Уул уурхайд ажиллахгүй, харин тэдэнд худалдаа, үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 14.1-26.1 хувийн хооронд хэлбэлзэж байна. Ерөнхийдөө уул уурхайн салбарт ажилладаг ажил мэргэжил эрхэлсэн хүмүүсийн шилжих хөдөлгөөн тэдэнд үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийн шилжих хөдөлгөөнөөс 3-7 дахин их байна.

Хүйсээр ангилан үзэхэд Өмнөговь аймагт ажил эрхэлдэг эрэгтэйчүүд (40.0%) сүүлчийн нэг жилд шилжин ирэх нь эмэгтэйчүүдээс (9.4%) 30.6 пунктээр илүү байна. Өмнөговь аймагт үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажил эрхэлдэг эрэгтэйчүүдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нь (74.1%) эмэгтэйчүүдийнхээс (21.6%) гурав дахин их байна. Мөн машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагчийн ажил эрхэлдэг эрэгтэйчүүдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нь (49.4%) эмэгтэйчүүдийнхээс (19.6%) хоёр дахин их байна. Шилжих хөдөлгөөн өндөр байгаа ажил мэргэжлийн хувьд хүйсийн ялгаа их байна. Өөрөөр хэлбэл, шилжих хөдөлгөөн ажил мэргэжлээр болон хүйсийн байдлаар хоорондоо эерэг хамааралтай байна.

ХҮСНЭГТ 6.3 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ МЭРГЭЖИЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Ажил мэргэжил	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	29 652	19 507	10 145	8 770	7 812	958	29.6	40.0	9.4
Менежер	1 459	990	469	412	343	69	28.2	34.6	14.7
Мэргэжилтэн	3 218	1 503	1 715	1 067	799	268	33.2	53.2	15.6
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	1 436	769	667	508	390	118	35.4	50.7	17.7
Контор, үйлчилгээний ажилтан	710	291	419	181	112	69	25.5	38.5	16.5
Худалдаа, үйлчилгээний ажилтан	2 416	786	1 630	438	271	167	18.1	34.5	10.2
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	7 899	4 295	3 604	145	93	52	1.8	2.2	1.4
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	3 754	3 471	283	2 633	2 572	61	70.1	74.1	21.6
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	5 203	5 096	107	2 539	2 518	21	48.8	49.4	19.6
Энгийн ажил мэргэжил	2 888	1 695	1 193	753	627	126	26.1	37.0	10.6
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	669	611	58	94	87	7	14.1	14.2	12.1

Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.8 хувь байхад ажил эрхэлдэг хүн амынх 6.0 хувь буюу ялимгүй их байна (Хүснэгт 7.4). Дорноговь аймгийн үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажил эрхэлдэг хүмүүсийн 12.0 хувь нь сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид байна. Үүний дараа техникч болон туслах/дэд мэргэжилтэн (10.9%), мэргэжилтэн (7.6%), машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч (7.1%), энгийн ажил мэргэжил (6.9%), контор, үйлчилгээний ажилтан (6.6%), менежер (6.4%) орж, Дорноговь аймгийн дунджаас дээгүүр байна.

Харин хөдөө аж ахуй, ой, загас агнуураар мэргэшсэн ажилтан (2.5%), худалдаа, үйлчилгээ (4.7%), зэвсэгт хүчний (5.9%) ажил мэргэжил эрхэлдэг хүмүүс Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэх нь бага байна. Эдгээрээс шилжих хөдөлгөөн доогуур ч Дорноговь аймгийн шилжих хөдөлгөөний ажил мэргэжлээр ялгаатай байгаа дүр зураг ялангуяа, хамгийн их, хамгийн бага шилжих хөдөлгөөнд орж байгаа ажил мэргэжлийн хувьд Өмнөговь аймгийнхтай төстэй байна. Энгийнээр хэлэхэд Дорноговь аймагт аж үйлдвэрийн салбарт ажиллах хүмүүс ирж байна.

ХҮСНЭГТ 6.4 ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ МЭРГЭЖИЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Ажил мэргэжил	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	22 211	12 656	9 555	1 336	955	381	6.0	7.5	4.0
Менежер	1 205	641	564	77	61	16	6.4	9.5	2.8
Мэргэжилтэн	2 607	753	1 854	197	105	92	7.6	13.9	5.0
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	1 002	486	516	109	75	34	10.9	15.4	6.6
Контор, үйлчилгээний ажилтан	755	197	558	50	18	32	6.6	9.1	5.7
Худалдаа, үйлчилгээний ажилтан	2 377	628	1 749	112	40	72	4.7	6.4	4.1
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	5 917	3 432	2 485	146	99	47	2.5	2.9	1.9
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	1 372	1 062	310	164	135	29	12.0	12.7	9.4
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	3 816	3 256	560	271	243	28	7.1	7.5	5.0
Энгийн ажил мэргэжил	2 364	1 519	845	163	137	26	6.9	9.0	3.1
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	796	682	114	47	42	5	5.9	6.2	4.4

Хүйсээр авч үзэхэд ажил эрхэлдэг эрэгтэйчүүд (7.5%) Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэх нь эмэгтэйчүүдээс (4.0%) 3.5 пунктээр илүү байна. Дорноговь аймагт эрэгтэй мэргэжилтэнд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (13.9%) эмэгтэйчүүдийнхээс (5.0%) 9.0 пунктээр илүү байгаа нь хүйсийн хувьд ялгаатай байна. Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажил мэргэжлийг эс тооцвол, шилжих хөдөлгөөн өндөр байгаа ажил мэргэжлийн хувьд хүйсийн ялгаа их байна.

Эцэст нь дүгнэхэд сүүлчийн нэг жилд үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний хүмүүс хамгийн их шилжих хөдөлгөөнд орсон байна. Энэ нь 2000 оны тооллогоор гарсан үр дүнтэй төстэй байна. Үүний дараа машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, энгийн ажил мэргэжил, техникч болон туслах/дэд мэргэжилтэн, мэргэжилтэн орж байна. Энэ нь 2000 оны үр дүнгээс ялгаатай, уул уурхайн салбар өсч байгаатай холбоотой байна. Улаанбаатар хотод 2000 оны тооллогоор шилжин ирэгчид үйлдвэрлэл, худалдаанд ажиллах нь их байсан бол 2010 оныхоор хөдөө аж ахуйд ажиллагчид болж өөрчлөгдсөн байна. Өмнөговь аймагт 2010 онд үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил эрхэлдэг хүмүүсийн хувьд арван хүний долоо нь сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байна.

Шилжих хөдөлгөөн өндөр байгаа ажил мэргэжил болон хүйсийн ялгаа их, шилжих хөдөлгөөн ажил мэргэжлээр болон хүйсийн ялгаатай байдлын хооронд эерэг хамааралтай байна.

6.2 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР

Шилжих хөдөлгөөний эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ялгаатай байдлыг судлах нь улс орны эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага цаашилбал, эдийн засгийн загварыг харахад чухал байдаг. Луисийн (Lewis 1954) онолоор эдийн засагт бүтцийн өөрчлөлт бий болоход шинээр хөгжиж байгаа эдийн засгийн салбар руу шилжих хөдөлгөөн чиглэдэг. Харин Харрис болон Тодарогийн (Harris and Todaro 1970) онолоор хөгжиж байгаа улс оронд хөдөө аж ахуйн салбарыг дэмждэг, аж үйлдвэрийн салбарыг дэмждэггүй, цалинг аль болох доод хэмжээнд барих бодлого явуулдаг учраас эдийн засгийн бүтцэд өөрчлөлт гардаггүй тул шилжих хөдөлгөөн тодорхой салбарыг чиглэдэггүй, албан бус салбарт ажиллаж хүлээлт бий болдог гэж үздэг. Эдийн засгийн ийм системд хот хөдөөгүй ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлт байдаг тул шилжих хөдөлгөөн нь эрсдэл дагуулдаг. Монгол Улсын хувьд 2000 оны тооллогоос үзэхэд Төвийн бүс рүү чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал нь хөдөө аж ахуйн салбарын хэсэг нүүдэл байсан, харин Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал нь худалдаа, үйлчилгээний салбар руу чиглэсэн байсан¹⁵. Монгол Улс дахь шилжих хөдөлгөөн нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн үр дагавар биш, хөдөө аж ахуйд зуд, ган зэрэг байгалийн гамшиг тохиолдсон эрсдэлтэй байдлын улмаас үүссэн шилжих хөдөлгөөний урсгал байсан гэж үзэж болно.

Арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.0 хувь байхад ажил эрхэлдэг хүн амынх 4.5 хувь буюу ялимгүй бага байна. 2010 оны тооллогоор барилга (13.5%), уул уурхайн (11.1%) салбарт ажилладаг хүмүүсийн хувьд сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөн хамгийн их байна (Хүснэгт 7.5). Энэ нь 2000 оны тооллогоос ялгаатай байна. 2000 оны тооллогоор сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь төрийн удирдлага, боловсруулах үйлдвэр, зочид буудал, зоогийн газар гэсэн салбарт ажилладаг хүмүүсийн хувьд өндөр байсан юм.

¹⁵ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 46, 66

ХҮСНЭГТ 6.5 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ
ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
САЛБАР, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	911 664	495 101	416 563	40 821	27 722	13 099	4.5	5.6	3.1
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	241 017	139 428	101 589	5 257	3 374	1 883	2.2	2.4	1.9
Уул уурхай, олборлолт	48 897	39 223	9 674	5 406	4 780	626	11.1	12.2	6.5
Боловсруулах үйлдвэрлэл	63 391	33 586	29 805	3 364	2 197	1 167	5.3	6.5	3.9
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	14 257	10 770	3 487	491	416	75	3.4	3.9	2.2
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	6 451	3 794	2 657	201	163	38	3.1	4.3	1.4
Барилга	58 517	46 704	11 813	7 726	7 055	671	13.2	15.1	5.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	117 040	51 077	65 963	4 112	2 128	1 984	3.5	4.2	3.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	52 681	42 059	10 622	2 853	2 565	288	5.4	6.1	2.7
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	28 446	6 315	22 131	1 521	332	1 189	5.3	5.3	5.4
Мэдээлэл, холбоо	13 646	7 206	6 440	406	225	181	3.0	3.1	2.8
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	15 841	6 083	9 758	578	255	323	3.6	4.2	3.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7 689	3 390	4 299	369	169	200	4.8	5.0	4.7
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	10 498	5 142	5 356	320	159	161	3.0	3.1	3.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	12 276	8 779	3 497	907	698	209	7.4	8.0	6.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	74 581	49 269	25 312	2 456	1 712	744	3.3	3.5	2.9
Боловсрол	79 552	21 318	58 234	2 552	673	1 879	3.2	3.2	3.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	35 710	6 981	28 729	1 086	246	840	3.0	3.5	2.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	8 463	4 628	3 835	277	155	122	3.3	3.3	3.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	19 285	8 092	11 193	750	359	391	3.9	4.4	3.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	683	182	501	71	10	61	10.4	5.5	12.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2 743	1 075	1 668	118	51	67	4.3	4.7	4.0

2010 онд уул уурхайн салбар, түүнийг дагасан бүтээн байгуулалт руу чиглэсэн шилжих хөдөлгөөний шинэ урсгал бий болсон байна. Үүний дараа хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйлдвэрлэл (10.4%), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа (7.4%), тээвэр, агуулахын (5.4%) болон зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ (5.3%), боловсруулах үйлдвэрлэл (5.4%), үл хөдлөх хөрөнгийн салбар (5.4%) орж, дунджаас дээгүүр байна.

Харин хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (2.2%), мэдээлэл, холбоо (3.0%), хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн (3.0%), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн (3.0%), усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх (3.1%) үйл ажиллагаа, боловсрол (3.2%), урлаг, үзвэр, тоглоом наадам (3.3%), төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал (3.3%), бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ (3.5%), санхүүгийн, даатгалын (3.6%) болон үйлчилгээний бусад үйл ажиллагаа (3.9%), олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа (4.3%) орж, эдгээр салбар руу чиглэсэн шилжих хөдөлгөөн дунджаас доогуур байна.

Хүйсээр авч үзэхэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид хамгийн их нь барилгын салбарт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс гурав дахин, уул уурхайн салбарт хоёр дахин илүү байна. Харин сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид ихтэй ч гэсэн хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйлдвэрлэлд эмэгтэйчүүд давамгайлж эрэгтэйчүүдээс хоёр дахин илүү байна. Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн, боловсрол, урлаг, үзвэр, тоглоом, наадмын үйл ажиллагаанд ажиллаж байгаа сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид хүйсийн ялгаа бараг алга байна. Үлдсэн бүх салбарт ажиллаж буй сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давамгайлж байна.

Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.9 хувь байхад ажил эрхэлдэг хүн амынх 4.3 хувь буюу 1.6 пунктээр бага байна (Хүснэгт 7.6). 2010 оны тооллогоор Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйлдвэрлэл (11.0%), хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт (9.1%) ажилладаг хүмүүс их байна. Энэ нь 2000 оны тооллогоор гарсан үр дүнгээс ялгаатай байна. 2000 оны тооллогоор Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид боловсруулах үйлдвэр, зочид буудал, зоогийн газрын салбарт ажиллах нь их байсан¹⁶. 2000 онд Улаанбаатар хотод шилжин ирэгчдийг хамгийн их шингээдэг салбар нь боловсруулах үйлдвэр, зочид буудал, зоогийн газар байсан бол 2010 онд хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбар болж өөрчлөгдсөн байна. Энэ нь Улаанбаатар хотын баячуудын давхаргад үзүүлэх үйлчилгээ улам бүр өргөжиж Улаанбаатар хотын захын хороололд хүмүүс шилжин ирээд мал маллаж эсвэл газар тариалан эрхэлж амьдрах болсныг харуулж байна.

Үүний дараа барилга (7.5%), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа (5.8%), боловсруулах үйлдвэрлэл (5.7%), зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ (5.5%), уул уурхай (5.1%), үл хөдлөх хөрөнгийн ажиллагаа (5.1%) орж, Улаанбаатрын дунджаас дээгүүр байна.

Харин цахилгаан, хий, уур, агааржуулалт (1.8%), төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал (2.2%), мэдээлэл, холбоо (2.6%), тээвэр ба агуулахын (2.6%), хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн (2.7%), усан хангамж;

¹⁶ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 66

бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа (2.8%), урлаг, үзвэр, тоглоом наадам (2.9%), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн (2.9%), санхүүгийн, даатгалын (3.2%), үйлчилгээний бусад үйл ажиллагаа (3.6%) болон боловсрол (3.6%), бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ (3.7%), олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа (3.9%) орж, Улаанбаатар хотын эдгээр салбарт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид ажиллах нь Улаанбаатар хотын дунджаас доогуур байна.

Хүйсээр авч үзэхэд Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс (1.4 пунктээр) давамгайлж байна. Барилга (3.7 пункт), боловсруулах үйлдвэрлэл (3.2 пункт), усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх (2.8 пункт), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх (2.8 пункт), санхүүгийн, даатгалын (1.2 пункт), тээвэр ба агуулахын (1.2 пункт), үйлчилгээний бусад үйл ажиллагаа (1.1 пункт), бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ (1.1 пункт), уул уурхай, олборлолтын (0.9 пункт) салбарт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс давамгайлж байгаа нь бусад салбарынхаас илүү байна. Мөн мэдээлэл, холбоо (0.4 пункт), хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн (0.4 пункт), төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал (0.5 пункт) цахилгаан, хий, уур, агааржуулалтын (0.7 пункт) салбарт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс бага ч гэсэн давамгайлж байна.

Түүнчлэн урлаг, үзвэр, тоглоом наадам, боловсрол, үл хөдлөх хөрөнгийн, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн салбарт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувьд хүйсийн ялгаа бараг алга байна.

Харин Улаанбаатар хотын сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байгаа, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйлдвэрлэл (7.7 пункт), хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын (0.4 пункт) салбарт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс давамгайлж байна. Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний (1.0 пункт) салбарт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс давамгайлж байна.

ХҮСНЭГТ 6.6 УЛААНБААТАР ХОТЫН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ
ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	391 523	207 521	184 002	16 661	10 200	6 461	4.3	4.9	3.5
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5 374	3 468	1 906	490	311	179	9.1	9.0	9.4
Уул уурхай, олборлолт	19 323	15 851	3 472	990	839	151	5.1	5.3	4.3
Боловсруулах үйлдвэрлэл	41 881	21 670	20 211	2 380	1 564	816	5.7	7.2	4.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	7 335	5 426	1 909	129	106	23	1.8	2.0	1.2
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3 537	2 041	1 496	98	81	17	2.8	4.0	1.1
Барилга	40 147	31 486	8 661	2 995	2 600	395	7.5	8.3	4.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	77 811	36 040	41 771	2 895	1 552	1 343	3.7	4.3	3.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	30 340	23 386	6 954	803	684	119	2.6	2.9	1.7
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	19 482	4 750	14 732	1 072	225	847	5.5	4.7	5.7
Мэдээлэл, холбоо	10 613	5 656	4 957	278	159	119	2.6	2.8	2.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	9 487	3 778	5 709	307	150	157	3.2	4.0	2.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7 079	3 146	3 933	359	164	195	5.1	5.2	5.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	6 316	3 182	3 134	184	98	86	2.9	3.1	2.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	8 516	6 295	2 221	494	410	84	5.8	6.5	3.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	32 063	19 873	12 190	718	480	238	2.2	2.4	2.0
Боловсрол	33 950	9 016	24 934	1 234	328	906	3.6	3.6	3.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	17 184	3 122	14 062	470	96	374	2.7	3.1	2.7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	5 440	3 141	2 299	157	90	67	2.9	2.9	2.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	13 168	5 284	7 884	472	224	248	3.6	4.2	3.1
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	556	149	407	61	8	53	11.0	5.4	13.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1 921	761	1 160	75	31	44	3.9	4.1	3.8

Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 21.9 хувь байхад ажил эрхэлдэг хүн ам 29.6 хувь байна (Хүснэгт 7.7). 2010 оны тооллогоор Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь барилга (80.7%), тээвэр ба агуулахын (49.9%), уул уурхай, олборлолт (45.7%), цахилгаан, хий, уур, агааржуулалт (39.0%), усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх (32.2%), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх (30.0%) салбарт ажилладаг хүмүүсийн хувьд хамгийн өндөр, дунджаас дээгүүр байна. 2010 оны тооллогоор цоо шинээр гарч ирсэн Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал дотор хамгийн том урсгал нь уул уурхайн салбар руу биш барилгын салбар руу чиглэсэн байна.

Үүний дараагаар зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ (17.6%), боловсруулах үйлдвэрлэл (17.4%), санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа (15.3%), мэдээлэл, холбоо (10.3%), бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ (10.1%), хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн (10.1%) салбар орж байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид уул уурхай, барилгын салбараас гадна хүмүүсийн бөөгнөрөл дагаж худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж байна.

Харин хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (1.9%), урлаг, үзвэр, тоглоом наадам (3.4%), боловсрол (5.5%), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн (8.2%), төрийн удирдлага ба батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал (9.0%), үйлчилгээний бусад (8.7%) албарт ажиллаж байгаа хүмүүсийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь Өмнөговь аймгийн дунджаас доогуур байна. Цаашилбал, үл хөдлөх хөрөнгийн, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйлдвэрлэл, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн гэсэн гурван салбарт Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид ажиллаагүй байна.

Хүйсээр авч үзэхэд Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс (30.6 пункт) давамгайлж байна. Барилга (38.7 пункт), усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны (33.6 пункт) салбарт ажиллаж байгаа шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс давамгайлж байна. Өмнөговь аймагт шилжин ирэгчдийг шингээж, ажиллуулж буй салбарт эрэгтэйчүүд давамгайлж байна.

Тээвэр ба агуулахын (23.9 пункт), уул уурхай, олборлолт (22.3 пункт), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх (19.4 пункт), цахилгаан, хий, уур, агааржуулалт (14.9 пункт), зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ (14.8 пункт), үйлчилгээний бусад (14.3 пункт), боловсруулах үйлдвэрлэл (11.9 пункт), хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн (10.6 пункт) салбарт ажиллаж байгаа сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс, дунджаас бага ч гэсэн давамгайлж, хүйсийн ялгаа 10.6-23.9 пунктын хооронд хэлбэлзэж байна.

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ (8.7 пункт), мэдээлэл, холбоо (6.0 пункт), санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа (4.5 пункт), төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын (2.3 пункт) салбарт ажиллаж байгаа сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд, эрэгтэйчүүд бага зэрэг давамгайлж, хүйсийн ялгаа 2.3-8.7 пунктын хооронд хэлбэлзэж байна.

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (0.8 пункт), урлаг, үзвэр, тоглоом наадам (0.8 пункт), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн (0.6 пункт) салбарт ажиллаж байгаа сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд хүйсийн ялгаа байхгүй байна. Өөрөөр хэлбэл, Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал бага байгаа салбарт хүйсийн ялгаа ч бага байна. Өмнөговь аймаг руу чиглэсэн урсгалд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давамгайлах нь их, боловсролоос (0.1 пункт) бусад бүх салбарт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давамгайлж байна.

ХҮСНЭГТ 6.7 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ
ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	29 652	19 507	10 145	8 770	7 812	958	29.6	40.0	9.4
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	8 027	4 363	3 664	151	98	53	1.9	2.2	1.4
Уул уурхай, олборлолт	5 216	4 299	917	2 382	2 132	250	45.7	49.6	27.3
Боловсруулах үйлдвэрлэл	660	377	283	115	85	30	17.4	22.5	10.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	562	468	94	219	194	25	39.0	41.5	26.6
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	118	78	40	38	34	4	32.2	43.6	10.0
Барилга	4 495	4 201	294	3 629	3 498	131	80.7	83.3	44.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 632	652	980	165	100	65	10.1	15.3	6.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2 618	2 437	181	1 306	1 256	50	49.9	51.5	27.6
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	615	130	485	108	38	70	17.6	29.2	14.4
Мэдээлэл, холбоо	146	76	70	15	10	5	10.3	13.2	7.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	314	104	210	48	19	29	15.3	18.3	13.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	10	5	5	-	-	-	-	-	-
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	158	70	88	13	6	7	8.2	8.6	8.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	817	418	399	245	165	80	30.0	39.5	20.1
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2 086	1 349	737	187	132	55	9.0	9.8	7.5
Боловсрол	1 298	274	1 024	72	15	57	5.5	5.5	5.6
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	576	95	481	58	18	40	10.1	18.9	8.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	119	53	66	4	2	2	3.4	3.8	3.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	173	54	119	15	10	5	8.7	18.5	4.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	3	1	2	-	-	-	-	-	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	9	3	6	-	-	-	-	-	-

Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.8 хувь байхад ажил эрхэлдэг хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 6.0 хувь буюу ялимгүй их байна. 2010 оны тооллогоор Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь барилга (21.2%), уул уурхай, олборлолт (16.8%), олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн (10.7%), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх (9.2%), боловсруулах үйлдвэрлэл (7.9%), тээвэр ба агуулахын (6.6%) салбарт өндөр дунджаас дээгүүр байна (Хүснэгт 7.8). Эдгээрээс Дорноговь аймагт аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалт эхлэхээс гадна уул уурхайн салбарт бас өрнөж, хүмүүсийг татаж байгаа нь харагдаж байна.

Эдгээрийн дараа санхүүгийн болон даатгалын (5.6%), зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ (5.3%), төрийн удирдлага ба батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал (5.3%), цахилгаан, хий, уур, агааржуулалт (4.3%), үйлчилгээний бусад үйл ажиллагаа (4.2%), урлаг, үзвэр, тоглоом наадам (4.2%) орж дунджаас доогуур ч гэсэн сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийг татсан салбарт орж байна. Дорноговь аймгийн цахилгаан, хий, уур, агааржуулалтын дэд бүтцийн салбарт хүмүүст шилжин ирж ажилласан нь бүтээн байгуулалт эхэлж байгааг харуулж байна.

Мэдээлэл, холбоо (1.8%), усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх (1.9%), хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа (2.4%), хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (2.5%), бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ (3.1%), боловсрол (3.8%), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн (3.9%) салбарт ажиллагчдын дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн бага байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дотроос үл хөдлөх хөрөнгийн, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл үйлдвэрлэлд нэг ч хүн ажиллаагүй байна.

Хүйсээр авч үзэхэд Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс (3.6 пункт) бага зэрэг давамгайлж байна. Барилга (8.3 пункт), уул уурхай, олборлолт (6.0 пункт), зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний (3.6 пункт) салбар руу чиглэсэн шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс давамгайлж, дунджаас дээгүүр байна. Дорноговь аймагт шилжин ирэгчдийг ихээр шингээж, ажиллуулж байгаа салбарт эрэгтэйчүүд давамгайлж байна.

Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн (0.9 пункт), хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (0.9 пункт), мэдээлэл, холбоо (1.5 пункт), урлаг, үзвэр, тоглоом наадам (1.5 пункт), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх (1.8 пункт), бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ (2.0 пункт), тээвэр ба агуулахын (2.9 пункт), боловсруулах үйлдвэрлэлийн (3.5 пункт) салбарт ажиллаж байгаа сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давамгайлж, хүйсийн ялгаа 0.9-3.5 пунктын хооронд хэлбэлзэж байна.

Мэргэжлийн шинжлэх ухааны болон техникийн үйл ажиллагаа (0.2 пункт), төрийн удирдлага ба батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал (0.6 пункт) руу чиглэсэн шилжих хөдөлгөөнд, эрэгтэйчүүд бага зэрэг давамгайлж, хүйсийн ялгаа 0.2-0.6 пунктын хооронд хэлбэлзэж байна.

ХҮСНЭГТ 6.8 ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ
ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	22 211	12 656	9 555	1 336	955	381	6.0	7.5	4.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5 919	3 435	2 484	146	98	48	2.5	2.9	1.9
Уул уурхай, олборлолт	1 563	1 253	310	262	225	37	16.8	18.0	11.9
Боловсруулах үйлдвэрлэл	403	195	208	32	19	13	7.9	9.7	6.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	302	236	66	13	10	3	4.3	4.2	4.5
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	161	80	81	3	3	-	1.9	3.8	-
Барилга	1 023	793	230	217	183	34	21.2	23.1	14.8
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 470	453	1 017	45	20	25	3.1	4.4	2.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4 547	3 414	1 133	301	251	50	6.6	7.4	4.4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	509	70	439	28	6	22	5.5	8.6	5.0
Мэдээлэл, холбоо	168	77	91	3	2	1	1.8	2.6	1.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	411	108	303	23	6	17	5.6	5.6	5.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	9	4	5	-	-	-	-	-	-
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	181	75	106	7	3	4	3.9	4.0	3.8
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	173	100	73	16	10	6	9.2	10.0	8.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2 742	1 711	1 031	146	95	51	5.3	5.6	4.9
Боловсрол	1 545	344	1 201	59	11	48	3.8	3.2	4.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	667	128	539	16	4	12	2.4	3.1	2.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	120	61	59	5	3	2	4.2	4.9	3.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	264	106	158	11	4	7	4.2	3.8	4.4
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	6	4	2	-	-	-	-	-	-
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	28	9	19	3	2	1	10.7	22.2	5.3

Боловсрол (0.8 пункт), үйлчилгээний бусад салбар (0.7 пункт), цахилгаан, хий, уур, агааржуулалт (0.3 пункт), санхүүгийн болон даатгалын (0.1 пункт) салбар руу чиглэсэн шилжих хөдөлгөөнд эмэгтэйчүүд давамгайлж байна. Дорноговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал бага байгаа салбарт эмэгтэйчүүд давамгайлж, их байгаа салбарт эрэгтэйчүүд давамгайлсан дүр зураг харагдаж байна.

2010 оны тооллогоор сүүлчийн нэг жилд барилга, уул уурхайн салбарт ажилладаг хүмүүс ихээр шилжих хөдөлгөөнд орсон байна. Энэ нь 2000 оны тооллогоос ялгаатай байна. 2000 оны тооллогоор сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөн төрийн удирдлага, боловсруулах үйлдвэр, зочид буудал, зоогийн газарт ажилладаг хүмүүсийн хувьд хамгийн их байсан. 2010 онд уул уурхайн салбар, түүнийг дагасан ажил руу шилжих хөдөлгөөний шинэ урсгал бий болгосон байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийг уул уурхайн салбар биш, барилгын салбар хамгийн их шингээж байна. Дорноговь аймагт аж үйлдвэрийн паркийн ажил эхлэхээс гадна уул уурхайн салбарт үйл ажиллагаа өрнөж, хүмүүсийг татаж буй нь харагдаж байна.

Харин Улаанбаатар хотын хувьд 2000 онд шилжин ирэгчдийг хамгийн их шингээдэг байсан салбар нь боловсруулах үйлдвэр, зочид буудал, зоогийн газар байсан бол 2010 онд хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбар болж өөрчлөгдсөн байна. Энэ нь Улаанбаатар хотын баячуудын давхаргад үзүүлэх үйлчилгээ улам бүр өргөжсөн. Улаанбаатар хотын захын хороололд хүмүүс шилжин ирээд мал маллаж эсвэл газар тариалан эрхэлж амьдрах болсныг илтгэнэ.

Хүйсээр авч үзэхэд шилжих хөдөлгөөн их байгаа барилгын салбарт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс гурав дахин, уул уурхайн салбарт хоёр дахин илүү, шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд давамгайлж байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байгаа, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс давамгайлж байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давамгайлах нь их байж, боловсролоос бусад бүх салбарт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давамгайлж байна. Дорноговь аймагт шилжин ирэгчдийг ихээр шингээж, ажиллуулж байгаа салбарт эрэгтэйчүүд бас давамгайлж байна.

6.3 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хөдөө аж ахуйн салбарт хөлстэй болон хөлсгүй ажилладаг, хувиараа болон албан бусаар ажил эрхэлдэг, байнгын ажилгүй хүмүүс шилжих хөдөлгөөнд орох нь их байдаг.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.0 хувь байхад ажил эрхэлдэг хүн амынх 4.5 хувь буюу ялимгүй бага байна. 2010 оны тооллогоор сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь цалин хөлстэй ажиллагчийн (6.1%) хувьд хамгийн өндөр байна (Хүснэгт 7.9). Энэ нь 2000 оны тооллогын үр дүнгээс ялгаатай байна. 2000 оны тооллогоор ажил эрхлэлтийн байдлын “бусад” гэсэн бүлэгт багтаж байгаа хүмүүсийн хувьд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид хамгийн өндөр, үүний дараа гэрээгээр ажиллагсад орж байсан¹⁷. Ийнхүү 2000 онд “цалин хөлстэй ажиллагч” шилжих хөдөлгөөнд их оролцож байгаагүй бол 2010 онд их ордог болж өөрчлөгдсөн байна. Үүнээс 2000 онд шилжигчид албан бус салбарт ажиллах нь их байсан бол 2010 онд албан секторт ажиллах нь илүү болсныг харуулж байна. Үүний дараа ажил олгогч (2.9%), нөхөрлөл, хоршооллын

¹⁷ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 49

гишүүн (2.7%), хувиараа хөдөлмөр эрхлэгч (2.4%) орж, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогчийн (2.3%) хувьд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь бага байна.

Хүйсээр авч үзвэл сүүлчийн нэг жилд шилжин ирсэн ажил эрхэлдэг хүмүүсийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2.5 пунктээр давамгайлж байна. Цалин хөлстэй ажиллагч (4.1 пункт), өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч (2.7 пункт) эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс давамгайлж дунджаас дээгүүр байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн ажил олгогчийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс (1.6 пункт) давамгайлж байна.

Харин хувиараа хөдөлмөр эрхлэгч (0.3 пункт), нөхөрлөл, хоршооллын гишүүдийн (0.0 пункт) шилжих хөдөлгөөний хувьд хүйсийн ялгаа бараг байхгүй байна. Ажил эрхлэлтийн байдлын бусад (4.3) гэсэн бүлэгт багтсан хүмүүсийн шилжих хөдөлгөөний хувьд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс давамгайлж, ажил эрхлэлтийн байдлаар ангилах боломжгүй эмэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд ихээр орж байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байгаа ажил эрхлэлтийн байдлын хувьд хүйсийн ялгаа бас өндөр байгаа дүр зураг харагдаж байна.

ХҮСНЭГТ 6.9 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Ажил эрхлэлтийн байдал	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	911 664	495 101	416 563	40 821	27 722	13 099	4.5	5.6	3.1
Цалин хөлстэй ажиллагч	512 628	265 255	247 373	31 024	21 320	9 704	6.1	8.0	3.9
Ажил олгогч	23 005	15 414	7 591	657	522	135	2.9	3.4	1.8
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	252 715	186 487	66 228	6 130	4 649	1 481	2.4	2.5	2.2
Нөхөрлөл, хоршооллын гишүүн	1 854	1 069	785	50	29	21	2.7	2.7	2.7
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	117 764	24 292	93 472	2 760	1 096	1 664	2.3	4.5	1.8
Бусад	3 698	2 584	1 114	200	106	94	5.4	4.1	8.4

Улаанбаатар хотын арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.9 хувь байхад ажил эрхэлдэг хүн амд эзлэх хувь 4.3 хувь буюу 1.6 пунктээр бага байна. 2010 оны тооллогоор Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь ажил эрхлэлтийн байдлын “бусад” гэсэн бүлэгт багтсан хүмүүсийн (6.7%) хувьд хамгийн өндөр, “цалин хөлстэй ажиллагч” (4.7%), нөхөрлөл, хоршооллын гишүүн (4.2%) дунджаас дээгүүр байна (Хүснэгт 7.10). “Бусад”, “цалин хөлстэй ажиллагч”-ийн шилжих хөдөлгөөн өндөр байгаа нь 2000 оны тооллогын үр дүнтэй адилхан байна. 2000 оны тооллогоор Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь ажил эрхлэлтийн “бусад” гэсэн бүлгийн хувьд хамгийн өндөр байсан¹⁸. 2010 онд 2000 онтой адилхан Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид, ажил эрхлэлтийн хувьд ангилахад түвөгтэй, “бусад” гэсэн бүлэг буюу албан бус салбарт ажиллах хандлага хэвээр

¹⁸ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 69

байна. “Бусад” гэсэн бүлгийн дараа “цалин хөлстэй ажиллагч” Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэх нь их байна. Энэ нь 2000, 2010 онд ялгаагүй Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид албан болон албан бус салбарт аль алинд ажилладаг байна.

Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч (3.9%), хувиараа хөдөлмөр эрхлэгч (3.2%), ажил олгогчийн (2.6%) хувьд Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь дунджаас доогуур байна. Ажил олгогчийн хувьд хамгийн бага байгаа нь Улаанбаатар хотод шилжин ирсэн хүмүүс удаагүй байхад бизнес эрхлээд, ажлын байр бий болгож, ажил олгогчоор ажиллах боломж муу байдгийг харуулж байна.

Хүйсээр авч үзвэл Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн ажил эрхэлдэг хүмүүсийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.4 пунктээр давамгайлж байна. Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч (2.1 пункт), цалин хөлстэй ажиллагч (1.7 пункт) эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс давамгайлж дунджаас дээгүүр байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эрэгтэйчүүд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй ажиллан байгаа дүр төрх нь бусад улс орныхоос ялгаатай байна. Ихэнх улс оронд Монгол улсад ч ялгаагүй эмэгтэйчүүд өрхөд цалин хөлсгүй ажил эрхлэх нь нийтлэг байдаг. Гэтэл Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь цалин хөлсгүй ажил эрхэлдэг эрэгтэйчүүдийн хувьд илүү байгаа нь Улаанбаатар хотод шилжин ирсэн эрэгтэйчүүдэд ажлын байр олдохгүй байгааг харуулж байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн ажил олгогч (1.4 пункт), хувиараа хөдөлмөр эрхлэгчийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс (1.1 пункт) давамгайлж байна.

Нөхөрлөл, хоршооллын гишүүдийн (0.8 пункт) шилжих хөдөлгөөний хувьд хүйсийн ялгаа бага байна. Ажил эрхлэлтийн байдлын бусад (4.3) гэсэн бүлэгт багтсан хүмүүсийн шилжих хөдөлгөөний хувьд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс давамгайлж, ажил эрхлэлтийн байдлаар ангилал боломжгүй ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд ихээр орж байна. Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний коэффициент өндөр байгаа ажил эрхлэлтийн байдлын хувьд хүйсийн ялгаа мөн өндөр байгаа дүр зураг Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний хувьд харагдаж байна.

ХҮСНЭГТ 6.10 УЛААНБААТАР ХОТЫН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Ажил эрхлэлтийн байдал	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	391 523	207 521	184 002	16 661	10 200	6 461	4.3	4.9	3.5
Цалин хөлстэй ажиллагч	283 777	143 169	140 608	13 259	7 914	5 345	4.7	5.5	3.8
Ажил олгогч	16 137	10 620	5 517	417	324	93	2.6	3.1	1.7
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	84 880	51 214	33 666	2 674	1 829	845	3.2	3.6	2.5
Нөхөрлөл, хоршооллын гишүүн	552	306	246	25	15	10	4.5	4.9	4.1
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	4 623	1 219	3 404	182	67	115	3.9	5.5	3.4
Бусад	1 554	993	561	104	51	53	6.7	5.1	9.4

Өмнөговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 21.9 хувь байхад ажил эрхэлдэг хүн амд 29.6 хувь буюу 7.7 пунктээр их байна. 2010 оны тооллогоор Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь “цалин хөлстэй ажиллагч”-ийн (42.9%) хувьд хамгийн өндөр дунджаас дээгүүр байна (Хүснэгт 7.11). Энэ нь Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид албан бус секторт биш, бэлэн, баталгаатай ажлын байрт ажилд орж байгааг харуулна. Үүний дараа ажил олгогч (14.9%), ажил эрхлэлтийн байдлын “бусад” гэсэн бүлэгт багтсан хүмүүс (10.9%), нөхөрлөл, хоршооллын гишүүн (10.5%), хувиараа хөдөлмөр эрхлэгч (6.0%) дунджаас доогуур байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй (2.5%) ажиллах нь бага байна. Эдгээрээс Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид албан бус секторт ажиллах боломж харьцангуй бага нь харагдаж байна.

Хүйсээр авч үзвэл Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирсэн ажил эрхэлдэг хүмүүсийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 30.6 пунктээр их байна. Ажил эрхлэлтийн байдлаас цалин хөлстэй ажиллагч (38.9 пункт) эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс давамгайлж дунджаас дээгүүр байна. Энэ нь Өмнөговь аймагт бий болж байгаа бэлэн баталгаатай ажлын байрт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү ажиллаж байгааг харуулна. Шилжин ирсэн эрэгтэйчүүд ажил олгогчоор ажиллах нь эмэгтэйчүүдээс 11.7 пунктээр илүү байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч (2.0 пункт), хувиараа хөдөлмөр эрхлэгчийн (2.0 пункт) хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давамгайлж байна.

Нөхөрлөл, хоршооллын гишүүн (3.4 пункт), ажил эрхлэлтийн байдлын “бусад” (4.3) гэсэн бүлэгт багтсан хүмүүсийн шилжих хөдөлгөөний хувьд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс давамгайлж ажил эрхлэлтийн байдлаар ангилах боломжгүй ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүд Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэх нь их байна. Өөрөөр хэлбэл, сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байгаа ажил эрхлэлтийн байдлын хувьд хүйсийн ялгаа өндөр байгаа дүр зураг Өмнөговь аймагт шилжин ирэгчдийн хувьд харагдаж байна.

ХҮСНЭГТ 6.11 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Ажил эрхлэлтийн байдал	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	29 652	19 507	10 145	8 770	7 812	958	29.6	40.0	9.4
Цалин хөлстэй ажиллагч	19 231	13 745	5 486	8 246	7 418	828	42.9	54.0	15.1
Ажил олгогч	355	250	105	53	46	7	14.9	18.4	6.7
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	6 158	4 734	1 424	367	304	63	6.0	6.4	4.4
Нөхөрлөл, хоршооллын гишүүн	19	11	8	2	1	1	10.5	9.1	12.5
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	3 843	730	3 113	97	39	58	2.5	5.3	1.9
Бусад	46	37	9	5	4	1	10.9	10.8	11.1

Дорноговь аймгийн арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид 5.8 хувь байхад ажил эрхэлдэг хүн ам 6.0 хувь буюу ялимгүй их байна. 2010 оны тооллогоор Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь “цалин хөлстэй ажиллагч”-ийн (7.5%) хувьд өндөр, үүний дараа ажил эрхлэлтийн байдлын “бусад” (7.1%) гэсэн бүлэг орж дунджаас дээгүүр байна (Хүснэгт 7.12). Энэ нь Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид албан бус секторт биш, бэлэн, баталгаатай ажлын байрт ажилд илүү орж байгааг харуулж байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч (4.4%), ажил олгогч (4.2%), өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч (3.2%), нөхөрлөл, хоршооллын гишүүн (2.0%) дунджаас доогуур байна.

Хүйсээр авч үзвэл Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирсэн ажил эрхэлдэг хүмүүсийн дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 3.6 пунктээр их байна. Ажил эрхлэлтийн байдлаас цалин хөлстэй ажиллагч (4.5 пункт), өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч (4.5 пункт) эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс давамгайлж дунджаас дээгүүр байна. Энэ нь Дорноговь аймагт бэлэн, баталгаатай ажлын байр бий болж эхэлсэн, тэнд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол илүү ажилд орж байгааг харуулж байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эрэгтэйчүүд хувиараа хөдөлмөр эрхлэх нь эмэгтэйчүүдээс 1.9 пунктээр илүү, шилжин ирэгчид ажил олгогчоор ажиллах нь хүйсийн хувьд ялгаагүй байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирээд нөхөрлөл, хоршооллын гишүүнээр ажиллаж байгаа хүмүүс дандаа эрэгтэйчүүд байхад ажил эрхлэлтийн байдлын “бусад” (4.3) гэсэн бүлэгт дандаа эмэгтэйчүүд байна. Эндээс Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эмэгтэйчүүд ажил эрхлэлтийн байдлаар ангилах боломжгүй, албан бус салбарт ажиллаж байгаа нь харагдана. Сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байгаа ажил эрхлэлтийн байдлын хувьд хүйсийн ялгаа өндөр байгаа дүр зураг Дорноговь аймаг руу руу чиглэсэн шилжих хөдөлгөөний хувьд бага ч гэсэн харагдаж байна.

ХҮСНЭГТ 6.12 ДОРНОГОВЬ АЙМГИЙН АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Ажил эрхлэлтийн байдал	Бүгд			2010 онд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	22 211	12 656	9 555	1 336	955	381	6.0	7.5	4.0
Цалин хөлстэй ажиллагч	12 770	7 016	5 754	955	668	287	7.5	9.5	5.0
Ажил олгогч	306	210	96	13	9	4	4.2	4.3	4.2
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	6 114	4 636	1 478	268	225	43	4.4	4.9	2.9
Нөхөрлөл, хоршооллын гишүүн	50	25	25	1	-	1	2.0	-	4.0
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч	2 901	725	2 176	94	48	46	3.2	6.6	2.1
Бусад	70	44	26	5	5	-	7.1	11.4	-

2000 онд “цалин хөлстэй ажиллагч” шилжих хөдөлгөөнд хамгийн их оролцож байгаагүй бол 2010 онд хамгийн их ордог болж өөрчлөгдсөн байна. Энэ нь 2000 онд шилжигчид албан бус салбарт ажиллах нь их байсан бол харин 2010 онд албан секторт ажиллах болсныг харуулж байна. 2010 онд 2000 оныхтой адилхан Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид ажил эрхлэлтийн хувьд ангилахад түвөгтэй, “бусад” гэсэн бүлэг буюу албан бус салбарт ажилладаг дүр төрх хэвээрээ байна. “Бусад” гэсэн бүлгийн дараа “цалин хөлстэй ажиллагч”-аар Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид ажиллах нь их байна. Харин Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь “цалин хөлстэй ажиллагч”-ийн хувьд өндөр байна. Энэ нь Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид албан бус секторт биш, бэлэн, баталгаатай ажлын байрт ажилд орж байгааг харуулна. Ийм дүр зураг Дорноговь аймгийн хувьд бага хэмжээгээр ажиглагдаж байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байгаа ажил эрхлэлтийн байдлын хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давамгайлах төдийгүй хүйсийн ялгаа өндөр байгаа дүр зураг байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ,
ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ЦАХИЛГААН, ХАЛААЛТ, УСАН ХАНГАМЖ



7.1 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ

Шилжигчдийн орон сууцны байдал шилжих хөдөлгөөн ихсэх тутам мууддаг. Дэлхийн том хотод байдаг ядуучуудын хорооллыг (slum) шилжин ирэгчид үүсгэсэн. Монгол Улсад ч гэсэн сүүлчийн үед шилжих хөдөлгөөн эрс нэмэгдсний улмаас Улаанбаатар хотын гэр хороолол улам бүр тэлсээр байна. Шилжигчдийн орон сууцыг өрхийн тэргүүлэгчийн орон сууцны байдлаар сонгож судалдаг. Энэ судалгаанд өрхийн тэргүүлэгч нь сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрхийн орон сууцны байдлыг судална. Энд өрхийн бусад гишүүн нь өрхийн тэргүүлэгчээс өмнө шилжин ирсэн тохиолдлыг ялгах боломжгүй сул талтай байдаг.

Монгол Улсад гэр, байшин гэсэн орон сууцны үндсэн хоёр төрөл байна. 2010 оны тооллогоор нийт өрхийн 45.2 хувь гэрт, 53.6 хувь байшинд, 1.1 хувь зориулалтын бус болон бусад сууцад амьдарч байна. Нэг жилд шилжин ирсэн өрхийн эзлэх хувь нь (3.0%) арван тав, түүнээс дээш насны хүн амд шилжин ирэгчдийн эзлэх хувиас (5.0%) доогуур байна. Энэ нь гэр бүлийн шилжих хөдөлгөөн харьцангуй бага, суралцахаар явах хувь хүний шилжих хөдөлгөөн харьцангуй их байгааг харуулж байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрхийн эзлэх хувь зориулалтын бус сууцад амьдарч байгаа өрхийн (7.7%) хувьд өндөр, дараа нь бусад (4.2%) сууцад, гэрт (3.2%) амьдарч байгаа өрх дунджаас дээгүүр байна (Хүснэгт 8.1). Өөрөөр хэлбэл, нэг жилд шилжин ирэгчид зориулалтын бус сууцад амьдрах нь их, тэдний хувьд орон сууцны асуудал хүндрэлтэй нь харагдаж байна.

Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрхийн эзлэх хувь байшинд (2.7%) амьдарч байгаа өрхийн хувьд хамгийн бага байна. Шилжин ирэгчид шилжин ирсэн жилдээ багтаж байшин худалдаж авах нь бага аж.

Өрхийн тэргүүлэгчийн хүйсээр үзэхэд эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хувьд нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (3.2%) эрэгтэй өрхийн тэргүүлэгчийнхээс (3.0%) ялимгүй өндөр хүйсийн ялгаа бага байна. Нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь зориулалтын бус сууцад амьдарч байгаа эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд (7.9%) өндөр байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь орон сууцны төрөл, хүйсээр ялгаа багатай ч шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байгаа сууцны төрөлд амьдарч байгаа өрх эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байх нь илүү байна.

ХҮСНЭГТ 7.1 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Сууцны төрөл	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	713 780	560 224	153 556	21 524	16 578	4 946	3.0	3.0	3.2
Гэр	322 836	258 461	64 375	10 427	8 501	1 926	3.2	3.3	3.0
Байшин	382 808	296 267	86 541	10 471	7 642	2 829	2.7	2.6	3.3
Зориулалтын бус сууц	8 064	5 445	2 619	623	432	191	7.7	7.9	7.3
Бусад	72	51	21	3	3	-	4.2	5.9	-

2010 оны тооллогоор Улаанбаатар хотын өрхийн 29.0 хувь гэрт, 69.7 хувь байшинд, 1.4 хувь зориулалтын бус сууцад, харин 21 өрх “бусад” сууцад амьдарч байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрхийн эзлэх хувь 4.1 хувь байна (Хүснэгт 8.2). Улаанбаатар хотод нэг жилд шилжин ирсэн өрхийн эзлэх хувь зориулалтын бус сууцад амьдарч байгаа өрхийн (7.7%) хувьд хамгийн өндөр төдийгүй бусдаас тасарсан байна. Энэ нь Улаанбаатар хотод шилжин ирэгчид олноороо орон сууцны подвал хөлслөн суух

болсонтой холбоотой. Улаанбаатар хотын бараг бүх байрны орон сууцны подвалыг хөлсөлдөг болжээ.

Үүний дараа гэрт (6.2%), бусад (4.8%) сууцад амьдарч байгаа өрх орж дунджаас дээгүүр байна. Улаанбаатар хотод шилжин ирсэн хүмүүсийн хувьд орон сууцны асуудал хүндрэлтэй байна.

Улаанбаатар хотын өрхөд нэг жилд шилжин ирсэн өрхийн эзлэх хувь байшинд (3.1%) амьдарч байгаа өрхийн хувьд хамгийн бага байна. Улаанбаатар хотод шилжин ирэгчид эхлээд байшин орон сууц шилжин ирсэн жилдээ багтаж худалдаж авах нь бага байна.

Улаанбаатар хотын өрхийн тэргүүлэгчийг хүйсээр авч үзэхэд эмэгтэй өрхийн тэргүүлэгчдийн дунд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (4.3%) эрэгтэй өрхийн тэргүүлэгчийнхээс (4.0%) ялимгүй өндөр хүйсийн ялгаа бага байна. Улаанбаатар хотод нэг жилд шилжин ирсэн өрхийн эзлэх хувь зориулалтын бус сууцад амьдарч байгаа эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд (10.7%) өндөр байна. “Бусад” гэсэн төрлийн орон сууцад амьдарч байгаа 21 өрхийн тэргүүлэгч бүгд эмэгтэй хүмүүс байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрхийн эзлэх хувь өндөр байгаа сууцны төрөл эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байх нь илүү байна.

ХҮСНЭГТ 7.2 УЛААНБААТАР ХОТОД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Сууцны төрөл	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	302 242	225 554	76 688	12 292	9 025	3 267	4.1	4.0	4.3
Гэр	87 537	66 161	21 376	5 440	4 263	1 177	6.2	6.4	5.5
Байшин	210 596	156 748	53 848	6 433	4 481	1 952	3.1	2.9	3.6
Зориулалтын бус сууц	4 088	2 628	1 460	418	280	138	10.2	10.7	9.5
Бусад	21	17	4	1	1	-	4.8	5.9	0.0

2010 оны тооллогоор Өмнөговь аймгийн нийт өрхийн 80.1 хувь гэрт, 19.1 хувь нь байшинд, 0.8 хувь зориулалтын бус сууцад, таван өрх “бусад” сууцад амьдарч байна. Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 4.3 хувь байна (Хүснэгт 8.3). Өмнөговь аймгийн нийт өрхийн 4.3 хувь сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байна. Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нь арван тав, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувиас (21.9%) тав дахин бага байна. Үүнээс Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалд гэр бүлийн урсгал биш, хувь хүний урсгал зонхилж байгааг харуулж байна. Өмнөговь аймагт ажиллахаар ирсэн хүмүүс өрхөөрөө амьдрахгүй, зочид буудал, ажилчдын байр зэрэг газарт амьдарч байгаатай холбоотой.

Өмнөговь аймгийн нэг жилд шилжин ирсэн өрхийн эзлэх хувь зориулалтын бус сууцад амьдарч байгаа өрхийн (17.4%) хувьд өндөр байна. Мөн “бусад” гэсэн төрлийн орон сууцад амьдарч байгаа таван өрх нь Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байна. Эдгээрээс Өмнөговь аймагт уул уурхайн салбарын ажилд оролцохоор хүмүүс бэлэн ажлын байрт очиж, ажилтай болж байгаа ч тэдний орон сууцны байдал таарууг байгааг харуулж байна.

Үүний дараа байшинд (6.7%) амьдарч байгаа дунджаас дээгүүр байна. Харин Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь гэрт (3.6%) амьдарч байгаа өрхийн хувьд бага байна. Эдгээрээс Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал нь тэнд байнга очиж суурьших биш, бэлэн байгаа ажлын байрт очиж ажиллах түр зуурын сууцад амьдрах, ажлын байр байхгүй болсон тохиолдолд буцаж шилжих хандлага бий болсныг харуулж байна.

Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзэхэд эрэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (4.6%) эмэгтэй өрхийн тэргүүлэгчийнхээс (3.4%) 1.2 пунктээр өндөр, хүйсийн ялгаа бага байна. Харин Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь зориулалтын бус сууцад амьдарч байгаа эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд (20.0%) өндөр байна. Мөн “бусад” гэсэн төрлийн орон сууцад амьдарч байгаа таван өрхийн тэргүүлэгч эрэгтэй хүмүүс байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирээд байшинд амьдарч байгаа өрхийн тэргүүлэгч эмэгтэй байна. Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр (байшингаас бусад) сууцны төрөлд амьдарч байгаа өрх эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна.

ХҮСНЭГТ 7.3 ӨМНӨГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Сууцны төрөл	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	14 939	11 598	3 341	645	531	114	4.3	4.6	3.4
Гэр	11 973	9 200	2 773	432	362	70	3.6	3.9	2.5
Байшин	2 846	2 318	528	192	153	39	6.7	6.6	7.4
Зориулалтын бус сууц	115	75	40	20	15	5	17.4	20.0	12.5
Бусад	5	5	-	1	1	-	20.0	20.0	-

2010 оны тооллогоор Дорноговь аймгийн нийт өрхийн 45.4 хувь гэрт, 53.2 хувь байшинд, 1.3 хувь нь зориулалтын бус сууцад, хоёр өрх “бусад” сууцад амьдарч байна. Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 3.7 хувь байна (Хүснэгт 8.4). Дорноговь аймгийн өрхийн 3.7 хувь сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байна. Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нь арван тав, түүнээс дээш насны хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувиас (6.0%) 2.3 пунктээр бага байна. Эдгээрээс Дорноговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалд гэр бүлийн урсгалаас хувь хүний урсгал ялимгүй давамгайлж байгааг харуулж байна.

Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь зориулалтын бус сууцад амьдарч байгаа өрхийн (8.1%) хувьд өндөр байна. Эндээс Дорноговь аймагт өрнөх ажилд очиж буй хүмүүст орон сууцны асуудал хүндрэлтэй нь харагдаж байна. Байшинд (4.1%) амьдарч байгаа өрх дунджаас дээгүүр байна. Харин Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь гэрт (3.0%) амьдарч байгаа өрхийн хувьд бага байна.

Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзэхэд эрэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (3.8%) эмэгтэй өрхийн тэргүүлэгчийнхээс (3.4%) 0.4 пунктээр өндөр, хүйсийн ялгаа ч бага байна. Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь зориулалтын

бус сууцад амьдарч байгаа эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд (9.4%) өндөр байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирээд гэрт амьдарч байгаа өрхийн тэргүүлэгч эрэгтэй байх нь илүү байхад байшинд амьдарч байгаа өрхийн тэргүүлэгч эмэгтэй байх нь илүү байна.

ХҮСНЭГТ 7.4 ДОРНОГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Сууцны төрөл	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	16 543	13 058	3 485	611	493	118	3.7	3.8	3.4
Гэр	7 514	5 909	1 605	228	191	37	3.0	3.2	2.3
Байшин	8 804	6 977	1 827	365	286	79	4.1	4.1	4.3
Зориулалтын бус сууц	223	171	52	18	16	2	8.1	9.4	3.8
Бусад	2	1	1	-	-	-	-	-	-

Сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орсон өрх зориулалтын бус сууцад амьдрах нь их, шилжин ирэгчдийн хувьд орон сууцны асуудал хүндрэлтэй байна. Улаанбаатар хот, Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид зориулалтын бус сууцад амьдрах нь хамгийн өндөр байна. Өмнөговь аймагт уул уурхайн салбарт ажиллахаар хүмүүс бэлэн ажлын байранд очиж, ажилтай болж байгаа ч тэдний орон сууц тааруу байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь орон сууцны төрөл, хүйсээр ялгаа багатай ч сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байгаа сууцны төрөлд амьдарч байгаа өрх эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байх нь илүү байна.

7.2 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР

Шилжин ирэгчид ялангуяа, эхний хэдэн жилдээ бусдын өмчлөлийн байрт түрээс төлж амьдрах нь илүү байдаг. Монгол Улсын хувьд нийт өрхийн бараг тал хувь нь гэрт амьдарч байгаа учраас гэр нь ихэнх тохиолдолд өөрийн өмч байдаг.

2010 оны тооллогоор нийт өрхийн 86.7 хувь өөрийн эзэмшлийн сууцад, 6.3 хувь бусдын сууцад түрээсээр суудаг, 6.1 хувь бусдын сууцад түрээсгүй суудаг, харин 0.9 хувь нь өмчлөлийн “бусад” (байгууллагын өмч орж болно) хэлбэрийн сууцад амьдарч байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (3.0%) арван тав, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувиас (5.0%) доогуур байна (Хүснэгт 8.5). Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өрхийн тэргүүн нь бусдын сууцад түрээсээр суудаг өрхийн (10.0%) хувьд хамгийн өндөр, үүний дараа өмчлөлийн “бусад” хэлбэрийн сууцад (7.1%), бусдын сууцад түрээсгүй суудаг өрх (6.7%) дунджаас дээгүүр байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид бусдын байрт түрээс төлж амьдарч байгаа нь орон сууцны асуудал хүндрэлтэйгээс гадна харьцангуй өндөр өртөгтэй байгааг харуулж байна.

Харин өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өөрийн эзэмшлийн сууцад (2.2%) амьдарч байгаа өрхийн хувьд хамгийн бага байна. Шилжин ирэгчид шилжин ирсэн жилдээ багтаж байшин худалдаж авах нь бага байна.

Өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзэхэд эмэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (3.2%) эрэгтэй өрхийн тэргүүлэгчийнхээс (3.0%) ялимгүй өндөр, хүйсийн ялгаа бага байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин

ирэгчдийн эзлэх хувь бусдын сууцад түрээсээр суудаг эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд (10.0%) өндөр байна. Эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх бусдын сууцад түрээсгүй суух нь их байхад эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх бусдын сууцад түрээстэй суух нь ялимгүй их байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь сууцны өмчлөлийн хэлбэр, хүйсээр ялгаа бага байна.

ХҮСНЭГТ 7.5 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эзэмшлийн хэлбэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	713 780	560 224	153 556	21 524	16 578	4 946	3.0	3.0	3.2
Өөрийн эзэмшлийн	619 034	493 609	125 425	13 702	11 036	2 666	2.2	2.2	2.1
Бусдын сууцад түрээстэй суудаг	44 951	31 153	13 798	4 477	3 097	1 380	10.0	9.9	10.0
Бусдын сууцад түрээсгүй суудаг	43 544	30 912	12 632	2 900	2 113	787	6.7	6.8	6.2
Бусад	6 251	4 550	1 701	445	332	113	7.1	7.3	6.6

2010 оны тооллогоор Улаанбаатар хотын өрхийн 81.7 хувь өөрийн эзэмшлийн, 10.3 хувь бусдын сууцад түрээсээр, 7.0 хувь бусдын сууцад түрээсгүй, 0.9 хувь нь өмчлөлийн “бусад” хэлбэрийн сууцад амьдарч байна. Улаанбаатар хотын өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 4.1 хувь байна (Хүснэгт 8.6). Улаанбаатар хотын өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь бусдын сууцад түрээсээр суудаг өрхийн (10.1%) хувьд хамгийн өндөр байна.

Үүний дараа эзэмшлийн “бусад” хэлбэрийн сууц (8.0%), бусдын байрт түрээсгүй (7.1%) амьдарч байгаа өрх дунджаас дээгүүр байна. Улаанбаатар хотод шилжин ирсэн хүмүүс өөрийн гэсэн сууцгүй, бусдын сууцад амьдарч байна.

Улаанбаатар хотын өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өөрийн эзэмшлийн сууцад (3.0%) амьдарч байгаа өрхийн хувьд бага байна.

Улаанбаатар хотын өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзэхэд эмэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (4.3%) эрэгтэй өрхийн тэргүүлэгчийнхээс (4.0%) ялимгүй өндөр, хүйсийн ялгаа бага байна. Улаанбаатар хотын бусдын сууцад түрээсээр (0.3 пункт) болон түрээсгүй (0.3 пункт) суудаг өрх эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байх нь илүү байна. Харин “бусад” гэсэн төрлийн орон сууц, өөрийн эзэмшлийн сууцад амьдарч байгаа өрхийн тэргүүлэгч эрэгтэй байх нь илүү байна.

ХҮСНЭГТ 7.6 УЛААНБААТАР ХОТОД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эзэмшлийн хэлбэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	302 242	225 554	76 688	12 292	9 025	3 267	4.1	4.0	4.3
Өөрийн эзэмшлийн	247 029	187 443	59 586	7 407	5 700	1 707	3.0	3.0	2.9
Бусдын сууцанд түрээстэй суудаг	31 193	21 156	10 037	3 159	2 119	1 040	10.1	10.0	10.4
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	21 221	15 010	6 211	1 501	1 047	454	7.1	7.0	7.3
Бусад	2 799	1 945	854	225	159	66	8.0	8.2	7.7

2010 оны тооллогоор Өмнөговь аймгийн нийт өрхийн 91.6 хувь өөрийн эзэмшлийн, 3.6 хувь бусдын сууцад түрээсээр, 4.4 хувь бусдын сууцад түрээсгүй, 0.4 хувь өмчлөлийн “бусад” хэлбэрийн сууцад амьдарч байна.

Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 4.3 хувь байна (Хүснэгт 8.7). Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өрхийн тэргүүн нь “бусад” өмчлөлийн хэлбэрийн сууцад суудаг өрхийн (18.0%) хувьд хамгийн өндөр байна. Үүний дараа бусдын сууцад түрээсээр суудаг (17.1%), бусдын сууцад түрээсгүй (15.2%) амьдарч байгаа өрх дунджаас дээгүүр байна. Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өөрийн эзэмшлийн сууцад амьдарч байгаа өрхийн хувьд (3.2%) хамгийн бага байна. Эндээс Өмнөговь аймагт шилжин ирсэн хүмүүс өөрийн сууцгүй бусдын сууцад амьдардаг нь харагдаж байна.

Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзэхэд эмэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (2.3%) эрэгтэй өрхийн тэргүүлэгчийнхээс (3.5%) 1.2 пунктээр доогуур хүйсийн ялгаа бага байна. Өмнөговь аймгийн бусдын сууцад түрээсгүй суудаг өрхийн хувьд хүйсийн ялгаа 4.2 пункт байна.

ХҮСНЭГТ 7.7 ӨМНӨГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эзэмшлийн хэлбэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	14 939	11 598	3 341	645	531	114	4.3	4.6	3.4
Өөрийн эзэмшлийн	13 679	10 647	3 032	441	371	70	3.2	3.5	2.3
Бусдын сууцанд түрээстэй суудаг	545	413	132	93	71	22	17.1	17.2	16.7
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	654	489	165	100	80	20	15.3	16.4	12.1
Бусад	61	49	12	11	9	2	18.0	18.4	16.7

2010 оны тооллогоор Дорноговь аймгийн өрхийн 78.8 хувь өөрийн эзэмшлийн, 9.0 хувь бусдын сууцад түрээсээр, 10.1 хувь бусдын сууцад түрээсгүй, 2.2 хувь өмчлөлийн “бусад” хэлбэрийн сууцад амьдарч байна.

Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь 2.3 байна (Хүснэгт 8.8). Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь бусдын сууцад түрээсээр суудаг (10.6%) өрхийн хувьд хамгийн өндөр байна. Бусдын сууцад түрээсгүй суудаг (7.9%), эзэмшлийн “бусад” төрлийн сууцад (6.5%) амьдарч байгаа өрх орж дунджаас дээгүүр байна. Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (2.3%) өөрийн эзэмшлийн сууцад амьдарч байгаа өрхийн хувьд хамгийн бага байна. Эндээс Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид өөрийн гэсэн сууцгүй, бусдын сууцад амьдардаг нь харагдаж байна.

Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзэхэд эмэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (1.9%) эрэгтэй өрхийн тэргүүлэгчийнхээс (2.4%) 0.5 пунктээр илүү, хүйсийн ялгаа бага байна. Дорноговь аймгийн эзэмшлийн “бусад” төрлийн сууцад амьдардаг өрхийн хувьд хүйсийн ялгаа их, 4.4 пункт байна. Харин бусдын сууцад түрээсээр суух нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хувьд (0.6 пунктээр) арай илүү байна.

ХҮСНЭГТ 7.8 ДОРНОГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эзэмшлийн хэлбэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	16 543	13 058	3 485	611	493	118	3.7	3.8	3.4
Өөрийн эзэмшлийн	13 028	10 422	2 606	298	249	49	2.3	2.4	1.9
Бусдын сууцад түрээстэй суудаг	1 483	1 129	354	157	118	39	10.6	10.5	11.0
Бусдын сууцад түрээсгүй суудаг	1 663	1 207	456	132	104	28	7.9	8.6	6.1
Бусад	369	300	69	24	22	2	6.5	7.3	2.9

Эцэст нь сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орсон өрх бусдын байрт, тэр дундаа түрээс төлж амьдрах нь их, шилжигчдийн хувьд орон сууцны асуудал хүндрэлтэйгээс гадна харьцангуй өндөр өртөгтэй байгааг харуулсан. Улаанбаатар хотод шилжин ирэгчид байшин орон сууц худалдаж аваад шилжин ирэх эсвэл шилжин ирсэн жилдээ багтаж байшин худалдаж авах нь бага байна. Өмнөговь аймагт шилжин ирсэн хүмүүс өөрийн гэсэн сууцгүй, бусдын сууцад амьдарч байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь сууцны өмчлөлийн хэлбэр, хүйсээр ялгаа бага байна.

7.3 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР

Цахилгааны эх үүсвэр найдвартай, байнгын үнэ хямд байх нь шилжин ирэгчдийг татдаг нэг хүчин зүйл. 2000 оны тооллогоор Улаанбаатар хотод шилжин ирэх нэг шалтгаан нь цахилгаан эрчим хүчний асуудал байсан¹⁹.

2010 оны тооллогоор нийт өрхийн 76.8 хувь төвлөрсөн системд холбогдсон, 15.4 хувь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглаж байгаа нь цахилгаан эрчим хүчний үндсэн эх үүсвэр болж байна. Үүнээс гадна багахан хэсэг нь дизель станц (0.2%), бага оврын цахилгаан үүсгүүр (0.02%) ашиглаж байна. Харин нийт өрхийн 3.3 хувь нь цахилгаан эх үүсвэргүй байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нь цахилгаан эх үүсвэрээр ялгаа бага байна. Төвлөрсөн системд (3.3%) холбогдсон өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байхад сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжтэй (1.5%) өрхийн хувьд бага байна (Хүснэгт 8.9). Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь цахилгаан эх үүсвэргүй өрхийн хувьд дунджаас дээгүүр байна. Өөрөөр хэлбэл, цахилгаан эх үүсвэр шилжих хөдөлгөөнд орох хүчин зүйл хэвээрээ байгаа ч шилжин ирэгчид ирсэн газартаа цахилгаан гэрэлгүй байна.

Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувийн ялгаатай байдал эмэгтэй тэргүүлэгчийн хувьд илүү болж байна. Эмэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь төвлөрсөн системд холбогдсон өрхийн хувьд (3.5%) эрэгтэй өрхийн тэргүүлэгчийнхээс (3.3%) илүү байна. Эрэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашигласан өрхийн хувьд (1.5%) эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс (1.1%) бага байна. Эрэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь цахилгааны эх үүсвэргүй өрхийн хувьд (3.6%) эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийнхөөс (1.9%) хоёр дахин илүү байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн цахилгааны эх үүсвэр эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийнхөөс илүү байхад эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх цахилгааны эх үүсвэргүй байх нь илүү байна.

ХҮСНЭГТ 7.9 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Цахилгааны эх үүсвэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
				ТОО			ХУВЬ		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	713 780	560 224	153 556	21 524	16 578	4 946	3.0	3.0	3.2
Төвлөрсөн систем	548 517	418 416	130 101	18 316	13 740	4 576	3.3	3.3	3.5
Дизель станц	18 905	15 059	3 846	476	388	88	2.5	2.6	2.3
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	110 200	97 696	12 504	1 603	1 464	139	1.5	1.5	1.1
Бага оврын цахилгаан үүсгүүр	12 548	10 954	1 594	370	331	39	2.9	3.0	2.4
Цахилгааны эх үүсвэргүй	23 610	18 099	5 511	759	655	104	3.2	3.6	1.9

¹⁹ Монгол Улсын Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа, Улаанбаатар хот, 2002 он, хуудас 74

2010 оны тооллогоор Улаанбаатар хотын нийт өрхийн 98.3 хувь төвлөрсөн системд холбогдсон нь цахилгаан эрчим хүчний үндсэн эх үүсвэр болж байна. Төвлөрсөн системээс гадна 0.2 хувь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, 0.3 хувь бага оврын цахилгаан үүсгүүр ашиглаж байна. Харин Улаанбаатар хотын нийт өрхийн 1.1 хувь цахилгааны эх үүсвэргүй байгаа нь анхаарал татаж байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь цахилгааны эх үүсвэрээр ялгаатай байна. Цахилгааны эх үүсвэргүй (7.5%) өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байгаа нь төвлөрсөн системд холбогдсон (4.1%) өрхийнхөөс 3.4 пунктээр илүү байна (Хүснэгт 8.10). Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж (6.9%), бага оврын цахилгаан үүсгүүртэй (7.3%) өрхийн хувьд дунджаас дээгүүр байна. Улаанбаатар хот бараг бүхэлдээ төвлөрсөн системд холбогдсон ч сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх цахилгаан, гэрэлгүй байх нь их байна. Энэ нь шилжин ирэгчид хотын захын хорооллыг улам бүр тэлж байгааг харуулж байна.

Улаанбаатар хотын өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувьд хүйсийн ялгаа бага байна. Эмэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь төвлөрсөн системд холбогдсон өрхийн хувьд (4.2%) эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс (3.9%) ялимгүй илүү байна. Эмэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь бага оврын цахилгаан үүсгүүр ашигласан өрхийн хувьд (6.0%) эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс (7.7%) ялимгүй бага байна. Улаанбаатар хотын эрэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь цахилгааны эх үүсвэргүй өрхийн хувьд (8.0%) эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийнхөөс (5.7%) 2.3 пунктээр их байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн цахилгааны эх үүсвэр эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийнхөөс илүү байхад эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх цахилгааны эх үүсвэргүй байна.

ХҮСНЭГТ 7.10 УЛААНБААТАР ХОТОД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Цахилгааны эх үүсвэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	302 242	225 554	76 688	12 292	9 025	3 267	4.1	4.0	4.3
Төвлөрсөн систем	297 198	221 608	75 590	11 921	8 719	3 202	4.0	3.9	4.2
Дизель станц	-	-	-	-	-	-	-	-	-
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	726	595	131	50	41	9	6.9	6.9	6.9
Бага оврын цахилгаан үүсгүүр	1 011	810	201	74	62	12	7.3	7.7	6.0
Цахилгааны эх үүсвэргүй	3 307	2 541	766	247	203	44	7.5	8.0	5.7

2010 оны тооллогоор Өмнөговь аймгийн нийт өрхийн 50.6 хувь төвлөрсөн системд холбогдсон, 14.7 хувь дизель станц, 25.8 хувь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, 3.8 хувь бага оврын цахилгаан үүсгүүр ашиглаж байна. Өмнөговь аймгийн өрхийн 5.6 хувь цахилгааны эх үүсвэргүй байна. Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь дизель станцтай (8.8%), бага оврын цахилгаан үүсгүүртэй

(8.2%) өрхийн хувьд өндөр байгаа нь хамгийн бага сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжтэй (1.6%) өрхийнхөөс (7.2 пункт, 6.6 пунктээр) илүү байна (Хүснэгт 8.11). Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь цахилгааны эх үүсвэргүй (5.7%) өрхийн хувьд дунджаас дээгүүр байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид төвлөрсөн системд холбогдоогүй байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид цахилгаан, гэрэлгүй байх нь дунджаас илүү байна. Эдгээрээс Өмнөговь аймагт шилжин ирэгчдийн амьжиргааны нөхцөл хурдан сайжирч чадахгүй байгааг харуулна.

Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувьд хүйсийн ялгаа, дизель станц, цахилгааны эх үүсвэргүй өрхөөс бусад цахилгааны эх үүсвэртэй өрхийн хувьд бага байна. Дизель станцтай өрхийн хувьд эрэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (9.6%) эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс (6.1%) 3.5 пунктээр илүү байна. Цахилгааны эх үүсвэргүй өрхийн хувьд эрэгтэй тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (6.9%) эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс (2.3%) 4.6 пунктээр илүү байна.

ХҮСНЭГТ 7.11 ӨМНӨГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Цахилгааны эх үүсвэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	14 939	11 598	3 341	645	531	114	4.3	4.6	3.4
Төвлөрсөн систем	7 565	5 642	1 923	304	237	67	4.0	4.2	3.5
Дизель станц	2 114	1 607	507	186	155	31	8.8	9.6	6.1
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	3 860	3 247	613	61	56	5	1.6	1.7	0.8
Бага оврын цахилгаан үүсгүүр	563	479	84	46	40	6	8.2	8.4	7.1
Цахилгааны эх үүсвэргүй	837	623	214	48	43	5	5.7	6.9	2.3

2010 оны тооллогоор Дорноговь аймгийн нийт өрхийн 76.2 хувь төвлөрсөн системд холбогдсон, 2.0 хувь дизель станц, 13.8 хувь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, 2.6 хувь бага оврын цахилгаан үүсгүүр ашиглаж байна (Хүснэгт 8.12). Дорноговь аймгийн өрхийн 5.5 хувь цахилгааны эх үүсвэргүй байна. Дорноговь аймгийн дизель станцтай (5.2%), бага оврын цахилгаан үүсгүүртэй (5.0%) өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байгаа нь хамгийн бага сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжтэй (2.0%) өрхийнхөөс (3.2 пункт, 3.0 пунктээр) илүү байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь төвлөрсөн системд холбогдсон (3.9%) өрхийн хувьд дунджаас дээгүүр байна. Дорноговь аймгийн дийлэнх өрх төвлөрсөн системд холбогдсон ч Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх өөр эх үүсвэрээс, тухайлвал, дизель станц, бага оврын цахилгаан үүсгүүрээс гэрэл, цахилгаантай байх нь их байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид цахилгаан, гэрэлгүй байх нь бага байна. Эдгээрээс Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид цахилгаан, гэрлийн хувьд Дорноговь аймгийн уугуул хүмүүсээс ялгаагүй хангагдаж байна.

Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувийн хүйсийн ялгаа, дизель станц, бага оврын цахилгаан үүсгүүртэй өрхөөс бусад цахилгааны эх үүсвэртэй өрхийн хувьд бага байна. Дизель станцтай өрхийн хувьд эрэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (5.2%) эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс (3.8%) 1.4 пунктээр илүү байна. Харин бага оврын цахилгаан үүсгүүртэй өрхийн хувьд эрэгтэй өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (4.9%) эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс (5.3%) 0.4 пунктээр доогуур байна.

ХҮСНЭГТ 7.12 ДОРНОГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Цахилгааны эх үүсвэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	16 543	13 058	3 485	611	493	118	3.7	3.8	3.4
Төвлөрсөн систем	12 600	9 784	2 816	495	396	99	3.9	4.0	3.5
Дизель станц	327	247	80	17	14	3	5.2	5.7	3.8
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	2 283	1 967	316	46	40	6	2.0	2.0	1.9
Бага оврын цахилгаан үүсгүүр	424	367	57	21	18	3	5.0	4.9	5.3
Цахилгааны эх үүсвэргүй	909	693	216	32	25	7	3.5	3.6	3.2

Эцэст нь гэрэл, цахилгаантай болох нь шилжигчдийг татах хүчин зүйлс боловч шилжин ирэгчид шилжин ирсэн жилдээ цахилгааны эх үүсвэртэй болохгүй байна. Улаанбаатар хот бүрэн хэмжээгээр төвлөрсөн системтэй боловч өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь цахилгааны эх үүсвэргүй өрхийн хувьд хамгийн өндөр байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид цахилгаан, гэрэлгүй байх нь дунджаас илүү, шилжин ирэгчдийн хувьд амьжиргааны нөхцөл хурдан сайжирч чадахгүй байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид цахилгаан, гэрлийн хувьд Дорноговь аймгийн уугуул хүмүүсээс ялгаагүй хангагдаж байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн цахилгааны эх үүсвэр эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийнхөөс илүү найдвартай байхад эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх цахилгаан эх үүсвэргүй байх нь их байна.

7.4 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ДУЛААНЫ ХАНГАМЖ

Монгол Улс шиг цаг агаартай улс орны хувьд дулааны хангамж сайтай, халаах үнэ хямд байх нь шилжигчдийг татдаг нэг хүчин зүйл. 2010 оны тооллогоор нийт өрхийн 72.6 хувь ердийн галлагаатай, 24.1 хувь төвлөрсөн халаалттай, 2.9 хувь нам даралтын зуухтай, 0.4 хувь цахилгаан халаагууртай байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь халаалтын төрлөөр ялгаа бага 2.7-5.4 хувийн хооронд хэлбэлзэж байна. Цахилгаан халаагууртай (5.4%) өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байхад ердийн галлагаатай (2.7%) өрхийн хувьд хамгийн бага байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нам даралтын зуух (4.9%), төвлөрсөн халаалттай өрхийн хувьд дунджаас дээгүүр байна.

Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь бага байх тутам хүйсийн ялгаа бага байна. Ердийн галлагаатай өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хүйсийн хувьд бараг ялгаагүй, эмэгтэй өрхийн тэргүүлэгчийнх 2.6 хувь, эрэгтэй өрхийн тэргүүлэгчийнх 2.7 хувь байна. Харин өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байсан цахилгаан халаагууртай өрхийн хувьд эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувьд (5.0%) эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс (7.1%) 2.1 пунктээр бага байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн дулааны хангамж нь ердийн галлагаатай байх нь илүү байна.

ХҮСНЭГТ 7.13 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Халаалтын эх үүсвэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	713 780	560 224	153 556	21 524	16 578	4 946	3.0	3.0	3.2
Төвлөрсөн	171 925	126 332	45 593	6 338	4 422	1 916	3.7	3.5	4.2
Нам даралтын зуух	20 756	17 073	3 683	1 021	716	305	4.9	4.2	8.3
Цахилгаан халаагуур	3 126	2 505	621	169	125	44	5.4	5.0	7.1
Ердийн галлагаа	517 973	414 314	103 659	13 996	11 315	2 681	2.7	2.7	2.6

2010 оны тооллогоор Улаанбаатар хотын өрхийн 55.3 хувь ердийн галлагаатай, 39.3 хувь төвлөрсөн халаалттай, 4.7 нь нам даралтын зуухтай, 0.7 хувь цахилгаан халаагууртай байна.

Улаанбаатар хотын өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь халаалтын төрлөөр ялгаатай, 3.6-6.0 хувийн хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт 8.14). Цахилгаан халаагууртай (6.0%) өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байхад төвлөрсөн халаалттай (3.6%) өрхийн хувьд хамгийн бага байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь ердийн галлагаатай (4.3%), нам даралтын зуухтай (5.7%) өрхийн хувьд дунджаас дээгүүр байна. Улаанбаатар хотод шилжин ирсэн өрх төвлөрсөн халаалттай байх нь бага, харин нам даралтын зуух, цахилгаан халаагууртай байх нь их байна.

Улаанбаатар хотын өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь бага байх тутам хүйсийн ялгаа бага байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувийн хүйсийн ялгаа ердийн галлагаатай өрхийн хувьд хамгийн бага, эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 4.3 хувь, эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 4.0 хувь байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувийн хүйсийн ялгаа төвлөрсөн халаалттай өрхийн хувьд бага, эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 3.3 хувь, эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 4.2 хувь байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байсан цахилгаан халаагууртай өрхийн хувьд эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийнх (5.4%) эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс (8.1%) 2.7 пунктээр бага байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх ердийн галлагаатай байх нь илүү байхад бусад төрлийн хувьд эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байх нь илүү байна.

ХҮСНЭГТ 7.14 УЛААНБААТАР ХОТОД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Халаалтын эх үүсвэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	302 242	225 554	76 688	12 292	9 025	3 267	4.1	4.0	4.3
Төвлөрсөн	118 836	85 347	33 489	4 251	2 845	1 406	3.6	3.3	4.2
Нам даралтын зуух	14 186	11 339	2 847	802	559	243	5.7	4.9	8.5
Цахилгаан халаагуур	2 055	1 621	434	123	88	35	6.0	5.4	8.1
Ердийн галлагаа	167 165	127 247	39 918	7 116	5 533	1 583	4.3	4.3	4.0

2010 оны тооллогоор Өмнөговь аймгийн өрхийн 90.8 хувь ердийн галлагаатай, 6.6 хувь төвлөрсөн халаалттай, 2.5 хувь нам даралтын зуухтай, 0.1 хувь цахилгаан халаагууртай байна.

Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь халаалтын төрлөөр ялгаатай, 4.0-11.8 хувийн хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт 8.15). Цахилгаан халаагууртай (11.8%) өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байхад ердийн галлагаатай (4.0%) өрхийн хувьд хамгийн бага байна. Харин өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нам даралтын зуухтай (5.6%), төвлөрсөн халаалттай (8.1%) өрхийн хувьд дунджаас дээгүүр байна.

Өмнөговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь цахилгаан халаагуураас бусад халаалтын төрөлд хүйсийн ялгаа бага байна. Ердийн галлагаатай өрхийн хувьд хүйсийн ялгаа хамгийн бага, эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 4.3 хувь, эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 2.9 хувь байна. Төвлөрсөн халаалттай өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувийн хүйсийн ялгаа бага, эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 7.8 хувь, эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 9.3 хувь байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байсан цахилгаан халаагууртай өрхийн хувьд хамгийн өндөр (15.4%) төдийгүй, эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх бүгдээрээ цахилгаан халаагууртай байна.

ХҮСНЭГТ 7.15 ӨМНӨГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Халаалтын эх үүсвэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	14 939	11 598	3 341	645	531	114	4.3	4.6	3.4
Төвлөрсөн	986	770	216	80	60	20	8.1	7.8	9.3
Нам даралтын зуух	372	325	47	21	17	4	5.6	5.2	8.5
Цахилгаан халаагуур	17	13	4	2	2	-	11.8	15.4	-
Ердийн галлагаа	13 564	10 490	3 074	542	452	90	4.0	4.3	2.9

2010 оны тооллогоор Дорноговь аймгийн өрхийн 71.5 хувь ердийн галлагаатай, 24.3 хувь төвлөрсөн халаалттай, 3.8 хувь нам даралтын зуухтай, 0.4 хувь цахилгаан халаагууртай байна.

Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь халаалтын төрлөөр их ялгаатай, 3.1-11.6 хувийн хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт 8.16). Цахилгаан халаагууртай (11.6%) өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байхад ердийн галлагаатай (3.1%) өрхийн хувьд хамгийн бага байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь, нам даралтын зуухтай (4.3%), төвлөрсөн халаалттай (5.1%) өрхийн хувьд дунджаас дээгүүр байна.

Дорноговь аймгийн өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь цахилгаан халаагуураас бусад халаалтын төрөлд хүйсийн ялгаа бага байна. Төвлөрсөн халаалттай өрхийн хувьд хүйсийн ялгаа хамгийн бага эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 5.0 хувь, эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 5.2 хувь байна. Дорноговь аймгийн ердийн галлагаатай өрхийн хувьд хүйсийн ялгаа бага эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 3.3 хувь, эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 2.6 хувь байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байсан цахилгаан халаагууртай өрхийн хувьд хүйсийн ялгаа хамгийн их (4.8 пункт), эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 12.5 хувь, эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 7.7 хувь байна.

ХҮСНЭГТ 7.16 ДОРНОГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Халаалтын эх үүсвэр	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	16 543	13 058	3 485	611	493	118	3.7	3.8	3.4
Төвлөрсөн	4 018	3 096	922	204	156	48	5.1	5.0	5.2
Нам даралтын зуух	634	529	105	27	22	5	4.3	4.2	4.8
Цахилгаан халаагуур	69	56	13	8	7	1	11.6	12.5	7.7
Ердийн галлагаа	11 822	9 377	2 445	372	308	64	3.1	3.3	2.6

Сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орсон өрх ердийн галлагаатай байх нь бага байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх төвлөрсөн халаалттай байх нь хамгийн бага, нам даралтын зуух, цахилгаан халаагууртай нь их байна. Өмнөговь, Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх ердийн галлагаатай нь бага цахилгаан халаагууртай нь их байна.

Сүүлчийн нэг жилд шилжих хөдөлгөөнд орсон эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх ердийн галлагаатай нь илүү байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх ердийн галлагаатай нь илүү, бусад төрлийн хувьд эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй нь илүү байна. Харин Өмнөговь, Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх цахилгаан халаагууртай нь илүү байна.

7.5 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН УСНЫ ХАНГАМЖ

Усны хангамж нь тухтай, эрүүл амьдралын баталгаа болно. 2010 оны тооллогоор байшинд амьдардаг өрхийн 56.8 хувь зөөврийн, 38.5 хувь төвлөрсөн халуун, хүйтэн усны хангамжтай, 4.4 хувь төвлөрсөн хүйтэн усны хангамжтай, 0.4 хувь бие даасан системтэй байна.

Байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь усныхангамжийн төрлөөр ялгаа бага, 2.0-4.2 хувийн хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт 8.18). Биеэ даасан халуун, хүйтэн усны хангамжтай (4.2%) байшинд суудаг өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байхад зөөврийн устай (2.0%) байшинд суудаг өрхийн хувьд бага байна. Харин байшинд суудаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нь төвлөрсөн халуун, хүйтэн усны хангамжтай байшинд суудаг өрх (3.4%), биеэ даасан хүйтэн устай байшинд суудаг өрхийн (3.3%) хувьд дунджаас дээгүүр байна.

Байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь бага байх тутам хүйсийн ялгаа бага байна. Зөөврийн устай байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувьд хүйсийн ялгаа бараг байхгүй, эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 2.2 хувь, эрэгтэй өрхийн тэргүүлэгчийн хувьд 1.9 хувь байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байсан биеэ даасан халуун, хүйтэн устай өрхийн хувьд эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь (3.3%) эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс (9.1%) 5.8 пунктээр бага байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байшинд амьдардаг өрхийн усны хангамж биеэ даасан системтэй нь их байна. Үүний дотор эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байшинд амьдардаг өрхийн усан хангамж нь халуун, хүйтэн устай биеэ даасан системтэй байхад эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байшинд амьдардаг өрх зөвхөн хүйтэн устай биеэ даасан системтэй нь илүү байна.

ХҮСНЭГТ 7.17 НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, УСАН ХАНГАМЖ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Усан хангамж	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	378 152	293 011	85 141	9 956	7 295	2 661	2.6	2.5	3.1
Төвлөрсөн усан хангамж	161 965	119 553	42 412	5 641	3 946	1 695	3.5	3.3	4.0
Халуун, хүйтэн устай	145 433	107 031	38 402	4 957	3 417	1 540	3.4	3.2	4.0
Зөвхөн хүйтэн устай	16 532	12 522	4 010	684	529	155	4.1	4.2	3.9
Бие даасан систем	1 501	1 277	224	56	40	16	3.7	3.1	7.1
Халуун, хүйтэн устай	771	661	110	32	22	10	4.2	3.3	9.1
Зөвхөн хүйтэн устай	730	616	114	24	18	6	3.3	2.9	5.3
Зөөврийн	214 686	172 181	42 505	4 259	3 309	950	2.0	1.9	2.2

Тайлбар: * - Нийтийн зориулалттай бусад байр ороогүй болно.

2010 оны тооллогоор Улаанбаатар хотын байшинд амьдардаг өрхийн 45.2 хувь зөөврийн, 52.6 хувь төвлөрсөн халуун, хүйтэн усны хангамжтай, 1.8 хувь төвлөрсөн зөвхөн хүйтэн усны хангамжтай, 0.5 хувь бие даасан системтэй байна.

Улаанбаатар хотын байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь усны хангамжийн төрлөөр ялгаа бага, 1.9-3.8 хувийн хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт 8.19). Зөвхөн хүйтэн устай (биеэ даасан систем (3.8%), төвлөрсөн (3.6%)) байшинд суудаг өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байхад биеэ даасан халуун, хүйтэн устай (1.9%), зөөврийн устай (2.4%) байшинд суудаг өрхийн хувьд бага байна. Улаанбаатар хотын байшинд суудаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь төвлөрсөн халуун, хүйтэн усны хангамжтай байшинд суудаг өрхийн (3.3%) хувьд дунджаас дээгүүр байна.

Улаанбаатар хотын байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувийн хүйсийн ялгаа (0.7 пункт) бага боловч усны хангамжийн төрлөөр хүйсийн ялгаа их, эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хувьд илүү байна. Биеэ даасан халуун, хүйтэн устай (6.2 пункт), зөөврийн устай (5.0 пункт), биеэ даасан хүйтэн устай (7.2 пункт) байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хүйсийн хувьд нэлээд ялгаатай, эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн хувьд өндөр байна. Улаанбаатар хотын байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь төвлөрсөн халуун, хүйтэн, хүйтэн устай өрхийн хувьд хүйсийн ялгаа бага байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн, төвлөрсөн усны хангамжтай байшинд амьдардаг өрхийн хувьд хүйсийн ялгаа бага, бусад усны хангамжийн төрөлд эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх илүү байна.

ХҮСНЭГТ 7.18 УЛААНБААТАР ХОТОД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, УСАН ХАНГАМЖ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Усан хангамж	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	207 650	154 740	52 910	6 039	4 212	1 827	2.9	2.7	3.5
Төвлөрсөн усан хангамж	112 936	81 460	31 476	3 774	2 524	1 250	3.3	3.1	4.0
Халуун, хүйтэн устай	109 250	78 928	30 322	3 642	2 428	1 214	3.3	3.1	4.0
Зөвхөн хүйтэн устай	3 686	2 532	1 154	132	96	36	3.6	3.8	3.1
Бие даасан систем	855	709	146	22	14	8	2.6	2.0	5.5
Халуун, хүйтэн устай	537	452	85	10	4	6	1.9	0.9	7.1
Зөвхөн хүйтэн устай	318	257	61	12	10	2	3.8	3.9	3.3
Зөөврийн	93 859	72 571	21 288	2 243	1 674	569	2.4	2.3	2.7

Тайлбар: * - Нийтийн зориулалттай бусад байр ороогүй болно.

2010 оны тооллогоор Өмнөговь аймгийн байшинд амьдардаг өрхийн 64.6 хувь зөөврийн, 3.5 хувь төвлөрсөн халуун, хүйтэн усан хангамжтай, 30.1 хувь төвлөрсөн зөвхөн хүйтэн усан хангамжтай, 1.8 хувь бие даасан системтэй байна.

Өмнөговь аймгийн байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь усны хангамжийн төрлөөр ялгаа их, 6.3-20.8 хувийн хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт 8.20). Өмнөговь аймагт биеэ даасан халуун, хүйтэн устай (20.8%) байшинд суудаг өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байхад төвлөрсөн зөвхөн хүйтэн устай (6.3%), зөөврийн устай (6.6%) байшинд суудаг өрхийн хувьд бага байна. Өмнөговь аймгийн байшинд суудаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нь төвлөрсөн халуун, хүйтэн усны хангамжтай байшинд суудаг өрхийн (7.1%) хувьд дунджаас дээгүүр байна.

Өмнөговь аймгийн байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувьд дүнгээр авч үзэхэд хүйсийн ялгаа (0.9 пункт) бага байгаа боловч усны хангамжийн төрлөөр хүйсийн ялгаа их байна. Өмнөговь аймгийн байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь төвлөрсөн халуун, хүйтэн устай (25.3 пункт) байшинд амьдардаг өрхийн хувьд хүйсийн ялгаа их, ийм хангамжтай байшинд амьдарч байгаа өрх эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна. Биеэ даасан халуун, хүйтэн устай байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хүйсийн хувьд ялгаатай (22.7 пункт) байгаагаас гадна шилжин ирээд ийм хангамжтай байшинд амьдарч байгаа өрх эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна.

ХҮСНЭГТ 7.19 ӨМНӨГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, УСАН ХАНГАМЖ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Усан хангамж	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	2802	2287	515	186	148	38	6.6	6.5	7.4
Төвлөрсөн усан хангамж	943	759	184	60	47	13	6.4	6.2	7.1
Халуун, хүйтэн устай	99	81	18	7	2	5	7.1	2.5	27.8
Зөвхөн хүйтэн устай	844	678	166	53	45	8	6.3	6.6	4.8
Бие даасан систем	50	46	4	7	7	-	14.0	15.2	-
Халуун, хүйтэн устай	24	22	2	5	5	-	20.8	22.7	-
Зөвхөн хүйтэн устай	26	24	2	2	2	-	7.7	8.3	-
Зөөврийн	1809	1482	327	119	94	25	6.6	6.3	7.6

Тайлбар: * - Нийтийн зориулалттай бусад байр ороогүй болно.

2010 оны тооллогоор Дорноговь аймгийн байшинд амьдардаг өрхийн 56.2 хувь зөөврийн, 13.7 хувь төвлөрсөн халуун, хүйтэн усан хангамжтай, 30.0 хувь төвлөрсөн хүйтэн усан хангамжтай, 0.2 хувь бие даасан системтэй байна.

Дорноговь аймгийн байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь усан хангамжийн төрлөөр ялгаа их, 3.2-16.7 хувийн хооронд хэлбэлзэж байна (Хүснэгт 8.21). Дорноговь аймагт биеэ даасан халуун, хүйтэн устай (16.7%) байшинд суудаг өрхийн хувьд өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байхад зөөврийн устай (3.2%) байшинд суудаг өрхийн хувьд бага байна. Дорноговь аймгийн байшинд суудаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь нь төвлөрсөн зөвхөн хүйтэн устай (4.8%), төвлөрсөн халуун, хүйтэн усны хангамжтай (5.7%) байшинд суудаг өрхийн хувьд дунджаас дээгүүр байна.

Дорноговь аймгийн байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь дүнгээр нь үзэхэд хүйсийн ялгаа байхгүй боловч, усны хангамжийн төрлөөр хүйсийн ялгаа байна. Биеэ даасан халуун, хүйтэн устай (20.0 пункт) байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хүйсийн хувьд их ялгаатай, шилжиж ирээд ийм хангамжтай байшинд амьдарч байгаа өрх эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна.

ХҮСНЭГТ 7.20 ДОРНОГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРСЭН БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, УСАН ХАНГАМЖ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, 2010 ОН

Усан хангамж	Өрх - бүгд			2010 онд шилжин ирсэн өрх					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	8 599	6 821	1 778	344	273	71	4.0	4.0	4.0
Төвлөрсөн усан хангамж	3 758	2 897	861	190	147	43	5.1	5.1	5.0
Халуун, хүйтэн устай	1 179	934	245	67	51	16	5.7	5.5	6.5
Зөвхөн хүйтэн устай	2 579	1 963	616	123	96	27	4.8	4.9	4.4
Бие даасан систем	12	8	4	1	1	-	8.3	12.5	-
Халуун, хүйтэн устай	6	5	1	1	1	-	16.7	20.0	-
Зөвхөн хүйтэн устай	6	3	3	-	-	-	-	-	-
Зөөврийн	4 829	3 916	913	153	125	28	3.2	3.2	3.1

Тайлбар: * - Нийтийн зориулалттай бусад байр ороогүй болно.

Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгч зөөврийн устай байшинд амьдрах нь бага, биеэ даасан халуун, хүйтэн устай байшинд амьдрах нь их байна. Ялангуяа, Өмнөговь, Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид биеэ даасан халуун, хүйтэн устай байшинд амьдрах нь их байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид хүйтэн устай байшинд амьдрах нь их, биеэ даасан халуун, хүйтэн устай байшинд амьдрах нь бага байна. Байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь бага байх тутам хүйсийн ялгаа бага байна.

ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ



ДҮГНЭЛТ

Шилжих хөдөлгөөнийг судлах нь эдийн засгийн бүтэц, эдийн засгийн хөгжилтэй уялддаг учраас их чухал байдаг. Гэхдээ шилжих хөдөлгөөний төвшин өндөр байгааг ажлын байр нэмэгдсэн газарт хүмүүс очиж, ажилтай болж, амьжиргаа нь сайжирч байгаа сайн үйл явц гэж шууд дүгнэж болохгүй.

Монгол Улсын шилжих хөдөлгөөн их нэмэгджээ. Үүнийг зах зээл хөдөлмөрийг хуваарилдаг онолтой тохирч байна гэж үзэх нь бий. Гэтэл татах хүчин зүйлсээс гадна түлхэх хүчин зүйлсийн улмаас хүмүүс шилжих хөдөлгөөнд орж байна.

2000 оны тооллогоор Монгол Улсад үндсэн хоёр урсгал гарсан. Үүнд:

1. Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал
2. Төвийн бүс рүү чиглэсэн урсгал

Эдгээр хоёр урсгалыг харахад зах зээлд ойртож, татагдсан мэт боловч өөрсдийн уугуул нутагт татах хүч суларч, ган зуд болж түлхэх хүч нэмэгдсний улмаас хүмүүс шилжих хөдөлгөөнд орсон дүр зураг ажиглагдсан. 2000 оны тооллогоор гарсан шилжих хөдөлгөөний урсгал эдийн засгийн салбар шинээр бий болсон эсвэл эдийн засгийн хөгжилтэй уялдсан биш, малгүй болсон малчид, ажилгүй хүмүүс амьжиргаа хайж шилжих хөдөлгөөнд орсон нь их байсан.

2010 оны тооллогоор шилжих хөдөлгөөний дээрх дүр зураг бараг хэвээр хадгалагдсан байна.

ТӨРСНӨӨС ХОЙШИХ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

- Улаанбаатар хот руу Монгол улсын өнцөг булан бүрээс чиглэсэн урсгалын дүр зураг 2000-2010 оны тооллогын хооронд хэвээр үлдсэн хэдүй ч урсгалын хэмжээ бараг хоёр дахин нэмэгджээ.
- 2000 онд Улаанбаатар хотод амьдарч байгаа гурван хүний нэг нь шилжин ирэгчид байсан бол 2010 онд хоёр хүний нэг нь шилжин ирэгчид болсон байна.
- Төв болон Хангайн бүсээс Улаанбаатар хот руу хүмүүс шилжин ирэхээс гадна, Төв болон Хангайн бүсэд Баруун болон Зүүн бүсээс хүмүүс ирж байгаа тул Төв болон Хангайн бүс нь зөвхөн “илгээх” биш, “хүлээж авах” газар болж, Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний “дамжих цэг” болж байна.
- Орхон, Дархан-Уул, Говь-Сүмбэр, Сэлэнгэ, Төв аймагт шилжин ирэгчид нэмэгдсээр байна.
- Шилжин ирэгчдийг татдаг уламжлалт аймгуудаас гадна 2010 онд Дорноговь, Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал шинээр үүсчээ.
- Дорноговь, Өмнөговь аймаг руу чиглэсэн урсгалд эрэгтэйчүүд давамгайлж байхад бусад аймаг, Улаанбаатар хот руу чиглэсэн урсгалд эмэгтэйчүүд давамгайлж байгаа нь уг хоёр аймагт өрнөж байгаа уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотой юм.

ТАВАН ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

- Улаанбаатар хот руу чиглэсэн урсгал Сүүлчийн таван жилд бараг хоёр дахин нэмэгдсэн байна.
- Төв болон Хангайн бүс нутаг шилжих хөдөлгөөний дамжих цэг болж байгаа ерөнхий дүр зураг сүүлчийн таван жилийн шилжих хөдөлгөөнд ажиглагдаж байна.
- Сүүлчийн таван жилд гадагшаа шилжих хөдөлгөөний хамгийн бага бүс нутаг нь Хангайн бүс нутаг хэвээр байна.
- Аймгийн нийт хүн амд сүүлчийн таван жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь Өмнөговь, Говьсүмбэрт хамгийн өндөр байна.

- Өмнөговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний эрчимтэй шинэ урсгал сүүлчийн таван жилд бүр их нэмэгджээ.

НЭГ ЖИЛИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

- Сүүлчийн нэг жилийн шилжих хөдөлгөөний дүр төрх сүүлчийн таван жилийнхтэй төстэй, гэхдээ гол шинж чанарууд нь “Баруун бүс нутаг - Улаанбаатар хот – Төвийн бүс нутаг” гэсэн урсгал тод харагдаж байна. Энэ нь зарим шилжигчид ялангуяа хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байсан хүмүүсийн (малчид) хувьд Улаанбаатар хот нь Төвийн бүс нутагт суурьших “дамжих цэг” болж байгааг харуулж байна.
- Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн тоо 10462 хүн байгаа нь Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирсэн хүнээс зургаа дахин цөөн байгаа ч энэ аймаг руу чиглэсэн шинэ урсгалд эрэгтэйчүүд илүү олон орж байна.
- Эцэст нь 2010 онд шилжих хөдөлгөөний дүр зураг урсгал нь 2000 оныхтой ижил боловч шилжих хөдөлгөөн ерөнхийдөө эрчимжсэн байна.

ХҮН АМЫН СУУРЬШИЛ, ХОТЖИЛТ

Улаанбаатар хот, Төв болон Хангайн бүс нутаг, Өмнөговь болон Дорноговь аймаг руу чиглэсэн шилжих хөдөлгөөний үр дүнд суурьшилт, хотжилт, хөгжилд нааштай үр дүн хараахан гараагүй байна. Учир нь:

- Шилжин явагчид ихтэй газар хотжилт нэмэгдэж, шилжин ирэгчид ихтэй газар хотжилт буурсан байна. Малгүй болсон малчдын зарим нь аймгийн төв рүү шилжиж уугуул аймагтаа хотжилтыг нэмэгдүүлж байна.
- Төв болон Сэлэнгэ аймагт бусад бүсээс шилжин ирж, Төвийн бүсийн хотжилтыг бууруулж байна.
- Монгол улсын хүн амын шилжих хөдөлгөөн нь сүүлийн 20-иод жилийн эдийн засгийн хөгжил, өөрчлөлттэй холбоотой төлөвлөгөөтэй, зорилготой шилжих хөдөлгөөн биш юм.
- Улаанбаатар хотын хүн амын нийт хүн амд эзлэх хувь өссөөр байгаа нь нийслэлийг бусад аймаг, хотоос хэд дахин олон хүн амтай, улсын хэмжээний “хэмжээлшгүй том хот” болсоор байгааг харуулж байна.

НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ДҮР ЗУРАГ

Монгол Улсын хүн амд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувиас харахад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү шилжих хөдөлгөөнд орж байна. Насны бүтцээр авч үзэхэд 15-19 насны охид, хөвгүүд шилжих хөдөлгөөнд орох нь илүү байна. Боловсролын төвшингээр авч үзэхэд дээд, бүрэн дунд боловсролтой хүмүүс шилжих хөдөлгөөнд орох нь өндөр байна. Гэр бүлийн байдлаар авч үзэхэд огт гэр бүл болоогүй болон батлуулаагүй гэр бүлтэй залуучууд шилжих хөдөлгөөнд орох нь гэр бүлтэй болон гэр бүлтэй байсан хүмүүсээс илүү байна.

2000 оны тооллогоор Монгол Улсад эрэгтэйчүүд ихэвчлэн ажил хайж шилждэг байсан бол эмэгтэйчүүд үргэлжлүүлэн суралцахаар шилжих хөдөлгөөнд оролцдог дүр зураг гарсан. Энэ дүр зураг 2010 оны тооллогын үр дүнгээс харагдаж байгаа ч эмэгтэйчүүд ажил хайж шилжих хөдөлгөөнд орох нь илүү болжээ. Шилжих хөдөлгөөнд орох нь өөрөө эдийн засгийн идэвх гаргаж байгаа нэг хэлбэр юм. Гэхдээ ажил хайж байгаа ч ажил олдох боломж шилжин ирэгчдийн хувьд тааруу нь харагдаж байна. Учир нь “ажил хайж байгаа” гэж хэлсэн ажилгүйчүүдийн хувьд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байна. Энэ боломж эмэгтэйчүүдийн хувьд бүр тааруу байна.

Сургуульд сурах нь шилжих хөдөлгөөнд орох нэг шалтгаан болж байна. Цаашид суралцах нь охидын хувьд хөвгүүдээс илүү байдаг дүр зураг хадгалагдсаар байна. Суралцахаас бусад шалтгааныг харахад эдийн засгийн идэвх багасах тутам шилжих хөдөлгөөнд оролцох нь багасдаг дүр зураг харагдаж байна. Гэрийн ажилтай болон тохирох ажил олдохгүй байгаа хүмүүс шилжих хөдөлгөөнд харьцангуй орж байгаа нь зарим талаар амьжиргааны боломж эрэлхийлж, эдийн засгийн далд идэвх үзүүлж байгааг харуулж байна.

Сүүлчийн нэг жилд үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээ эрхэлдэг хүмүүс их шилжих хөдөлгөөнд орсон байна. Энэ нь 2000 оны тооллогоор гарсан дүнтэй төстэй байна. Үүний дараа машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, энгийн ажил мэргэжил, техникч болон туслах/дэд мэргэжилтэн, мэргэжилтэн орж байна. 2000 оны дүр төрхөөс ялгаатай. Сүүлчийн үед уул уурхайн салбар өсч байгаатай холбоотой. Шилжих хөдөлгөөний төвшин өндөр байгаа ажил мэргэжлийн хувьд хүйсийн ялгаа их байна. Шилжих хөдөлгөөний төвшин ажил мэргэжлээр ялгаатай байдал хүйсийн ялгаатай байдал хоёрын хооронд эерэг хамааралтай байна.

2010 оны тооллогоор сүүлчийн нэг жилд барилга, уул уурхайн салбарт ажилладаг хүмүүс их шилжих хөдөлгөөнд орсон байна. Энэ нь 2000 оны тооллогоос ялгаатай байна. 2000 оны тооллогоор сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь төрийн удирдлага, боловсруулах үйлдвэр, зочид буудал, зоогийн газарт салбарт ажилладаг хүмүүсийн хувьд өндөр байсан. Уул уурхайн салбар, түүнийг дагасан бүтээн байгуулалт нь шилжих хөдөлгөөний цоо шинэ мөртлөө өндөр төвшний урсгал бий болгосон байна. Шилжин ирэгчдийг хамгийн ихээр шингээж байгаа барилгын салбарт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс гурав дахин, уул уурхайн салбарт хоёр дахин илүү болж шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд давамгайлж илтгэж байна.

2000 онд "цалин хөлстэй ажиллагч" шилжих хөдөлгөөнд ихээр оролцож байгаагүй бол 2010 онд ихээр ордог болж өөрчлөгдсөн байна. Энэ нь 2000 онд шилжин ирэгчид албан бус салбарт ажиллах нь их байсан бол 2010 онд албан секторт ажиллах нь илүү болсныг харуулж байна.

Шилжин ирэгчдийн орон сууцны байдал хүндрэлтэй байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь зориулалтын бус сууцад амьдарч байгаа өрхийн хувьд их байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь орон сууцны төрөл, хүйсээр ялгаа бага байна. Гэхдээ сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өндөр байгаа сууцны төрөлд амьдарч байгаа өрх эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй нь илүү байна.

Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх бусдын байрт, тэр дундаа түрээс төлж амьдрах нь их байна. Эндээс шилжин ирэгчдийн хувьд орон сууцны асуудал хүндрэлтэйгээс гадна өндөр өртөгтэй нь харагдаж байна. Өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь сууцыг өмчлөх хэлбэр хүйсээр ялгаа бага байна.

Гэрэл, цахилгаантай болох нь шилжин ирэгчдийг татах хүчин зүйлс мөн боловч бүх айл, өрх шилжин ирсэн жилдээ цахилгааны эх үүсвэртэй болохгүй байна. Эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн цахилгааны эх үүсвэр эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийнхөөс илүү найдвартай байхад эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх цахилгааны эх үүсвэргүй нь илүү байна.

Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх ердийн галлагаатай нь бага байна. Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн халаалтын төрөл нь ердийн галлагаатай байх нь илүү байна.

Сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх зөөврийн устай байшинд амьдрах нь бага, биеэ даасан халуун, хүйтэн устай байшинд амьдрах нь их байна. Байшинд амьдардаг өрхийн тэргүүлэгчдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь бага байх тутам хүйсийн ялгаа бага байна.

УЛААНБААТАР ХОТОД НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ДҮР ЗУРАГ

Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн дунд 15-19 насны эмэгтэйчүүд давамгайлж, бусад насанд эрэгтэйчүүд давамгайлж байна. 2000 оны тооллогоор малаа алдсан малчид Улаанбаатар хотод шилжин ирж байсан дүр зураг 2010 оны тооллогоос бас харагдаж байна.

2010 онд боловсролын төвшин буурах тутам сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь өсч байгаа нь Улаанбаатар хотод боловсрол муутай хүмүүс шилжиж ирэх нь улам бүр нэмэгдэж байгааг харуулж байна.

Улаанбаатар хотод огт гэр бүл болоогүй болон гэр бүлээ батлуулаагүй хүмүүс шилжин ирэх нь илүү байж, тэдний дунд эмэгтэйчүүд давамгайлж байна. Улаанбаатар хотод цаашид суралцах залуучууд, тэр дундаа эмэгтэйчүүд, охид илүү ирж байна.

2000 оны тооллогоор Улаанбаатар хотод эрэгтэйчүүд ихэвчлэн ажил хайж ирж, эмэгтэйчүүд үргэлжлүүлэн суралцахаар ирж байсан. Энэ дүр зураг 2010 оны тооллогын үр дүнгээс харагдаж байна. Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн хувьд ажил олдох нь тааруу байна. Учир нь “ажил хайж байгаа” гэж хэлсэн ажилгүйчүүдэд сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байна.

Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд гэрийн ажилтай болон тохирох ажил олдохгүй байгаа хүмүүс шилжин ирэх нь хүмүүс шилжих хөдөлгөөнд орохдоо зарим талаар амьжиргааны боломж эрэлхийлж, эдийн засгийн далд идэвх үзүүлж байгааг харуулж байна.

2000 оны тооллогоор Улаанбаатар хотод үйлдвэрлэл, худалдааны ажилд шилжин ирэх нь хамгийн их байсан бол 2010 оныхоор хөдөө аж ахуйд ажиллагсад болж өөрчлөгдсөн байна.

2000 онд Улаанбаатар хотод шилжин ирэгчдийг их шингээдэг салбар нь боловсруулах үйлдвэр, зочид буудал, зоогийн газар байсан бол 2010 онд хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбар болж өөрчлөгдсөн байна. Энэ нь Улаанбаатар хотын баячуудын давхаргад үзүүлэх үйлчилгээ улам бүр өргөжиж Улаанбаатар хотын захын хороололд хүмүүс шилжин ирээд мал маллаж эсвэл газар тариалан эрхэлж амьдрах болсныг харуулж байна. Улаанбаатар хотод сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь хамгийн өндөр байгаа, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур гэсэн хоёр салбарт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс давамгайлж байна.

2010 онд 2000 онтой адилхан Улаанбаатар хотод шилжин ирэгчид, ажил эрхлэлтийн хувьд ангилахад түвөгтэй, “бусад” гэсэн бүлэг буюу албан бус салбарт ажиллах хандлага хэвээр байна. Улаанбаатар хотод шилжин ирэгчид “бусад” гэсэн бүлгийн дараа “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллах нь их байна.

Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн орон сууцны байдал тааруу байна. Тэд зориулалтын бус сууцад амьдрах төдийгүй бусдаас тасарсан байна. Улаанбаатар хотод шилжин ирэгчид эхлээд байшин орон сууц худалдаж аваад шилжин ирэх эсвэл шилжин ирсэн жилдээ багтаж байшин худалдаж авах нь бага байна. Улаанбаатар хотод шилжин ирсэн өрх төвлөрсөн халаалтай нь хамгийн бага, нам даралтын зуух, цахилгаан халаагууртай нь хамгийн их байна. Улаанбаатар хот нь эрчим хүчний төвлөрсөн системтэй боловч сүүлчийн нэг жилд шилжин ирсэн өрх цахилгааны эх үүсвэргүй байх нь хамгийн өндөр байна. Улаанбаатар хотод шилжин ирэгчид хүйтэн устай байшинд амьдрах нь их, биеэ даасан халуун, хүйтэн устай байшинд амьдрах нь бага байна.

ӨМНӨГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ДҮР ЗУРАГ

Өмнөговь аймагт 40-44 насны эрэгтэйчүүд (39.2%) сүүлчийн нэг жилд шилжин ирэх нь их байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирсэн бүх насанд эрчүүд давамгайлж байна. Харин 20-29 насны эмэгтэйчүүд бусад насны эмэгтэйчүүдтэй харьцуулахад шилжин очих нь илүү байна.

Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь дээд, бүрэн дунд боловсролтой хүмүүсийн хувьд хамгийн өндөр байна. Энэ аймагт ихэвчлэн эрчүүд шилжин очиж байгаа нь уул уурхайн салбар хүйсийн ялгаатай салбар болохыг харуулж байна.

Өмнөговь аймагт огт гэр бүл болоогүй эмэгтэйчүүд сүүлчийн нэг жилд шилжин ирэх нь гэр бүлтэй болон гэр бүлтэй байсан эмэгтэйчүүдийг бодвол их байна. Өмнөговь аймагт огт гэр бүл болоогүй залуучууд шилжин очихоос гадна баталгаатай гэр бүлтэй хүмүүс бас адилхан оролцож байна. Өмнөговь аймагт өрнөж байгаа уул уурхайн салбарын хөгжилд бүх насны гэр бүлтэй болон гэр бүлгүй эрчүүд болон огт гэр бүл болоогүй залуу эмэгтэйчүүд илүү оролцож байна.

Энэ аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид ажил хайхаас илүүтэй бэлэн ажлын байрт ажиллахаар ирж байна. Гэхдээ Өмнөговь аймагт хамгийн эдийн засгийн идэвхгүй “ажил хийх сонирхолгүй” эмэгтэйчүүд шилжин ирэх нь сонирхол татаж байна. Уул уурхайн салбарт ажиллах эрэгтэйчүүдийн урсгалыг гэрийн ажилтай эмэгтэйчүүдээс гадна “ажил хийх сонирхолгүй” эмэгтэйчүүдийн урсгал дагаж ирж байна.

Өмнөговь аймагт 2010 онд ажиллаж байгаа үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээ эрхэлдэг хүмүүсийн арван хүний долоо нь сүүлчийн нэг жилд шилжин ирсэн байна.

Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид уул уурхайн салбар, түүнийг дагалдсан бүтээн байгуулалтад ажиллаж байна. Учир нь шилжин ирэгчдийг хамгийн их шингээж байгаа салбар нь уул уурхай биш, барилгын салбар байна. Өмнөговь аймагт боловсролоос бусад бүх салбарт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давамгайлж байна.

Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь “цалин хөлстэй ажиллагч”-ийн хувьд өндөр байна. Энэ нь Өмнөговь аймагт шилжин ирэгчид албан бус секторт биш, бэлэн, баталгаатай ажлын байрт ажилд орж байгааг харуулж байна.

Өмнөговь аймагт хэдүйгээр ажил байр бэлэн байгаа ч орон сууцны асуудал хүндрэлтэй байна. Өмнөговь аймагт шилжин ирэгчид зориулалтын бус сууцад амьдрах нь бусдаас их байна. Өмнөговь аймагт шилжин ирсэн хүмүүс өөрийн сууцгүй, бусдын сууцад амьдарч байна. Өмнөговь аймагт шилжин ирсэн өрхийн ердийн галлагаатай нь бага, цахилгаан халаагууртай нь их байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид цахилгаан, гэрэлгүй байх нь дунджаас илүү байна. Өмнөговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид биеэ даасан халуун, хүйтэн устай байшинд амьдрах нь хамгийн их байна.

ДОРНОГОВЬ АЙМАГТ НЭГ ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ДҮР ЗУРАГ

Дорноговь аймгийн хувьд бүтээн байгуулалт эхлэлийн төдий байгаа нь тодорхой байна. Дорноговь аймагт 20-24 насны эрэгтэйчүүд шилжин ирэх нь хамгийн их байна. Шинэ бүтээн байгуулалтын төв багтаж байгаа Дорноговь аймаг руу боловсролгүй хүмүүс шилжин суурьших нь улсын төвшнөөс арай өндөр байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь боловсролын төвшин өсөх тутам өсч байна. Техник мэргэжлийн боловсролтой эрэгтэйчүүд шилжин ирэх нь их байна. Дорноговь аймагт бий болох аж үйлдвэрийн паркын бүтээн байгуулалт эхлэл төдий байгаа ч огт гэр бүл болоогүй болон гэр бүлээ батлуулаагүй залуучууд бусдаас илүү очиж байгаа нь Дорноговь аймаг хүмүүсийг татдаг газар болсныг харуулж байна. Дорноговь аймаг руу хүмүүс ажил хайж очиж байгаа ч ажил олдохгүй нь харагдаж байна. Дорноговь аймагт уул уурхайн салбарт үйл ажиллагаа өрнөж, хүмүүсийг татаж байгаа нь харагдаж байна. Дорноговь аймагт шилжин ирэгчдийг хамгийн ихээр шингээж, ажиллуулж байгаа салбарт эрэгтэйчүүд хамгийн их давамгайлж байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчдийн эзлэх хувь “цалин хөлстэй ажиллагч”-ийн хувьд хамгийн өндөр байна. Энэ нь Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид баталгаатай ажилд орж байгааг харуулж байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид цахилгаан, гэрлийн хувьд Дорноговь аймгийн уугуул хүмүүсээс ялгаагүй хангагдаж байна. Дорноговь аймагт сүүлчийн нэг жилд шилжин ирэгчид биеэ даасан халуун, хүйтэн устай байшинд амьдрах нь их байна.

ЗӨВЛӨМЖ

Орчин үеийн Монгол Улсын мал аж ахуйн салбарын эрсдэлтэй байдлыг бууруулах талаар арга хэмжээ авч, ирээдүйн хөгжлийн загварыг тодорхойлох, ингэхдээ эдийн засгийн түлхүү хөгжүүлэх салбарыг зөв сонгох шаардлагатай байна. Хамгийн гол нь баялагт суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ шинэ технологид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай байна.

Хөдөө орон нутгийн хөгжлийн талаарх бодлогыг тэдгээрийн онцлогт тулгуурлан нүүдлийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлтэй уялдуулан хөгжүүлэх шаардлагатай.

Төв болон Хангайн бүсийн аймгийн бэлчээр ашиглалт, газар тариалангийн хөгжлийг малын тооны өсөлттэй зохицсон бодлого боловсруулах зүйтэй юм.

Дээр дурдасланчлан улсын хөгжлийн зүй зохистой тэргүүлэх салбарыг хөгжүүлэхийн зэрэгцээгээр нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг зөв хослуулан хөгжүүлж, урсгалаараа эмх замбараагүй шилжих хөдөлгөөний эрчмийг ойрын хугацаанд сааруулах нь зүйтэй байна.

НОМ ЗҮЙ

Bhagat, R. B (2005) "Conceptual issues in measurement of internal migration in India" paper presented in XXVth IUSSP International Conference held in Tours, France, 18-23 July 2005

Жефферсон/ Jefferson, M. (1939) 'The Law of the Primate City', Geographical Review 29(2): 226-232.

Равенстэйн/ Ravenstein, E. G. (1885) 'The Laws of Migration', Journal of the statistical society, XLVIII(2): 167-227.

Ли/ Lee, S. (1966) 'A Theory of Migration', Demography 61: 47-57.

Луис/ Lewis, A. (1954) 'Economic Development with Unlimited Supplies of Labour', Manchester School 22: 139-191.

Харис болон Тодаро/ Harris, J. R. and M. P. Todaro (1970) 'Migration, Unemployment and Development: a Two Sector Analysis', The American Economic Review 60: 126-142.

Хопт болон Кэйн/ Haupt, A and Kane T, T (2004) "Population handbook", Population reference bureau, Washington, DC http://www.prb.org/pdf/PopHandbook_Eng.pdf

Statistics of Newzealand – internal migration of New Zealand

UN Manual - basic concepts on internal migration

UN Manual - internal migration

UN Manual – measurement of rural-urban migration

USA Census bureau (2003) "Migration data and reports"

ЗГ (2008) Монгол Улсын хуулийн эмхтгэл I боть, Улаанбаатар хот

ҮСГ (2002) Дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого дээр суурилсан судалгаа

ҮСХ (2011) Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын үндсэн үр дүн

<http://iussp2005.princeton.edu/download.aspx?submissionId=50276>

<http://www.census.gov/population/www/cen2000/migration/index.html>


http://www.stats.govt.nz/browse_for_stats/population/Migration/internal-migration

<http://www.un.org/esa/population/techcoop/IntMig/manual6/chapter3.pdf>

<http://www.un.org/esa/population/techcoop/IntMig/manual6/intro.pdf>

http://www.un.org/esa/population/techcoop/IntMig/manual6/pref_toc.pdf

ХАВСРАЛТ



ХҮСНЭГТ 1.1 СУУРИН ХҮН АМД СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид						
				тоо			хувь			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	2 355 363	1 165 579	1 189 784	3 17 668	160 537	157 131	13.5	13.8	13.2	
5-9	212 529	108 244	104 285	14 573	7 384	7 189	6.9	6.8	6.9	
10-14	236 865	120 064	116 801	17 430	8 794	8 636	7.4	7.3	7.4	
15-19	257 645	130 560	127 085	50 339	22 944	27 395	19.5	17.6	21.6	
20-24	292 183	147 472	144 711	80 840	38 696	42 144	27.7	26.2	29.1	
25-29	247 983	124 490	123 493	46 783	23 876	22 907	18.9	19.2	18.5	
30-34	222 522	111 976	110 546	28 988	16 089	12 899	13.0	14.4	11.7	
35-39	202 383	100 819	101 564	21 735	12 515	9 220	10.7	12.4	9.1	
40-44	179 267	88 273	90 994	17 327	9 938	7 389	9.7	11.3	8.1	
45-49	158 756	77 475	81 281	13 745	7 757	5 988	8.7	10.0	7.4	
50-54	122 082	58 009	64 073	9 478	5 084	4 394	7.8	8.8	6.9	
55-59	71 989	33 384	38 605	5 616	2 752	2 864	7.8	8.2	7.4	
60-64	49 453	22 106	27 347	3 671	1 733	1 938	7.4	7.8	7.1	
65-69	38 232	17 262	20 970	2 734	1 254	1 480	7.2	7.3	7.1	
70-74	29 332	13 081	16 251	2 073	900	1 173	7.1	6.9	7.2	
75-79	18 617	7 252	11 365	1 259	470	789	6.8	6.5	6.9	
80-84	9 166	3 258	5 908	623	218	405	6.8	6.7	6.9	
85+	6 359	1 854	4 505	454	133	321	7.1	7.2	7.1	

ХҮСНЭГТ 1.2 УЛААНБААТАР ХОТЫН СУУРИН ХҮН АМД СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид						
				тоо			хувь			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	1 032 911	496 765	536 146	185 624	89 836	95 788	18.0	18.1	17.9	
5-9	78 298	39 990	38 308	7 433	3 784	3 649	9.5	9.5	9.5	
10-14	82 753	41 840	40 913	9 687	4 876	4 811	11.7	11.7	11.8	
15-19	121 019	58 632	62 387	38 003	17 035	20 968	31.4	29.1	33.6	
20-24	159 643	77 209	82 434	52 580	24 776	27 804	32.9	32.1	33.7	
25-29	116 322	56 452	59 870	20 031	10 223	9 808	17.2	18.1	16.4	
30-34	97 609	47 714	49 895	14 508	7 702	6 806	14.9	16.1	13.6	
35-39	86 563	42 319	44 244	11 000	5 991	5 009	12.7	14.2	11.3	
40-44	74 127	35 413	38 714	9 042	4 603	4 439	12.2	13.0	11.5	
45-49	67 613	31 885	35 728	7 563	3 856	3 707	11.2	12.1	10.4	
50-54	52 379	23 907	28 472	5 442	2 617	2 825	10.4	10.9	9.9	
55-59	31 323	13 927	17 396	3 422	1 491	1 931	10.9	10.7	11.1	
60-64	22 676	9 829	12 847	2 342	1 022	1 320	10.3	10.4	10.3	
65-69	16 605	7 292	9 313	1 776	808	968	10.7	11.1	10.4	
70-74	12 043	5 289	6 754	1 293	542	751	10.7	10.2	11.1	
75-79	7 462	2 829	4 633	781	272	509	10.5	9.6	11.0	
80-84	3 855	1 392	2 463	403	136	267	10.5	9.8	10.8	
85+	2 621	846	1 775	318	102	216	12.1	12.1	12.2	

ХҮСНЭГТ 1.3 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУУРИН ХҮН АМД СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Насны бүлэг	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	55 050	31 945	23 105	14 122	11 083	3 039	25.7	34.7	13.2
5-9	4 592	2 346	2 246	261	117	144	5.7	5.0	6.4
10-14	5 236	2 668	2 568	198	117	81	3.8	4.4	3.2
15-19	4 387	2 456	1 931	422	310	112	9.6	12.6	5.8
20-24	6 610	4 146	2 464	2 676	1 939	737	40.5	46.8	29.9
25-29	6 988	4 218	2 770	3 087	2 176	911	44.2	51.6	32.9
30-34	5 931	3 722	2 209	2 055	1 705	350	34.6	45.8	15.8
35-39	5 412	3 415	1 997	1 832	1 571	261	33.9	46.0	13.1
40-44	4 853	3 044	1 809	1 600	1 436	164	33.0	47.2	9.1
45-49	3 982	2 400	1 582	1 138	993	145	28.6	41.4	9.2
50-54	2 501	1 446	1 055	526	460	66	21.0	31.8	6.3
55-59	1 331	674	657	187	156	31	14.0	23.1	4.7
60-64	856	442	414	82	68	14	9.6	15.4	3.4
65-69	709	329	380	30	21	9	4.2	6.4	2.4
70-74	715	290	425	17	8	9	2.4	2.8	2.1
75-79	511	214	297	7	3	4	1.4	1.4	1.3
80-84	244	87	157	3	2	1	1.2	2.3	0.6
85+	192	48	144	1	1	-	0.5	2.1	-

ХҮСНЭГТ 2.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БОЛОВСРОЛГҮЙ ХҮН АМД СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Бичиг үсгийн мэдлэг	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
УЛСЫН ДҮН									
БҮГД	81 672	43 919	37 753	5 864	3 585	2 279	7.2	8.2	6.0
Бичиг үсэг мэддэг	48 451	26 811	21 640	3 531	2 218	1 313	7.3	8.3	6.1
Бичиг үсэг мэддэггүй	33 221	17 108	16 113	2 333	1 367	966	7.0	8.0	6.0
УЛААНБААТАР									
БҮГД	10 392	5 255	5 137	2 251	1 199	1 052	21.7	22.8	20.5
Бичиг үсэг мэддэг	5 495	2 762	2 733	1 282	696	586	23.3	25.2	21.4
Бичиг үсэг мэддэггүй	4 897	2 493	2 404	969	503	466	19.8	20.2	19.4
ӨМНӨГОВЬ									
БҮГД	2 297	1 306	991	134	110	24	5.8	8.4	2.4
Бичиг үсэг мэддэг	1 553	897	656	103	90	13	6.6	10.0	2.0
Бичиг үсэг мэддэггүй	744	409	335	31	20	11	4.2	4.9	3.3

ХҮСНЭГТ 2.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТӨВШИН, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Боловсролын төвшин	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
УЛСЫН ДҮН									
БҮГД	1 824 297	893 352	930 945	279 801	140 774	139 027	15.3	15.8	14.9
Дээд	392 572	162 332	230 240	71 360	30 567	40 793	18.2	18.8	17.7
Тусгай мэргэжлийн дунд	122 997	48 341	74 656	13 027	6 155	6 872	10.6	12.7	9.2
Техник болон мэргэжлийн	60 308	32 267	28 041	5 927	3 549	2 378	9.8	11.0	8.5
Бүрэн дунд	685 935	340 194	345 741	136 651	67 985	68 666	19.9	20.0	19.9
Суурь	366 546	206 057	160 489	37 704	23 630	14 074	10.3	11.5	8.8
Бага	195 939	104 161	91 778	15 132	8 888	6 244	7.7	8.5	6.8
УЛААНБААТАР									
БҮГД	861 468	409 680	451 788	166 253	79 977	86 276	19.3	19.5	19.1
Дээд	258 925	108 499	150 426	34 332	14 449	19 883	13.3	13.3	13.2
Тусгай мэргэжлийн дунд	61 108	24 867	36 241	7 298	3 261	4 037	11.9	13.1	11.1
Техник болон мэргэжлийн	20 061	11 083	8 978	2 880	1 623	1 257	14.4	14.6	14.0
Бүрэн дунд	389 142	193 019	196 123	97 506	46 908	50 598	25.1	24.3	25.8
Суурь	99 992	56 895	43 097	17 665	10 363	7 302	17.7	18.2	16.9
Бага	32 240	15 317	16 923	6 572	3 373	3 199	20.4	22.0	18.9
ӨМНӨГОВЬ									
БҮГД	42 925	25 625	17 300	13 529	10 739	2 790	31.5	41.9	16.1
Дээд	7 201	3 780	3 421	4 185	2 591	1 594	58.1	68.5	46.6
Тусгай мэргэжлийн дунд	2 339	1 108	1 231	653	498	155	27.9	44.9	12.6
Техник болон мэргэжлийн	1 740	949	791	323	276	47	18.6	29.1	5.9
Бүрэн дунд	12 713	8 104	4 609	4 787	4 138	649	37.7	51.1	14.1
Суурь	12 725	8 147	4 578	2 932	2 676	256	23.0	32.8	5.6
Бага	6 207	3 537	2 670	649	560	89	10.5	15.8	3.3

ХҮСНЭГТ 3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР

Гэр бүлийн байдал	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
УЛСЫН ДҮН									
БҮГД	1 905 969	937 271	968 698	285 665	144 359	141 306	15.0	15.4	14.6
Огт гэр бүл болоогүй	596 085	322 497	273 588	124 400	63 260	61 140	20.9	19.6	22.3
Батлуулсан гэр бүлтэй	987 575	492 568	495 007	118 381	61 910	56 471	12.0	12.6	11.4
Батлуулаагүй гэр бүлтэй	158 663	76 375	82 288	28 031	14 226	13 805	17.7	18.6	16.8
Тусгаарласан	23 660	10 221	13 439	3 101	1 452	1 649	13.1	14.2	12.3
Цуцалсан	35 347	14 951	20 396	3 998	1 883	2 115	11.3	12.6	10.4
Бэлбэсэн	104 639	20 659	83 980	7 754	1 628	6 126	7.4	7.9	7.3
УЛААНБААТАР									
БҮГД	871 860	414 935	456 925	168 504	81 176	87 328	19.3	19.6	19.1
Огт гэр бүл болоогүй	303 772	154 868	148 904	86 843	42 174	44 669	28.6	27.2	30.0
Батлуулсан гэр бүлтэй	398 951	194 983	203 968	56 624	28 472	28 152	14.2	14.6	13.8
Батлуулаагүй гэр бүлтэй	95 177	44 941	50 236	16 330	8 013	8 317	17.2	17.8	16.6
Тусгаарласан	12 989	5 086	7 903	1 672	686	986	12.9	13.5	12.5
Цуцалсан	19 477	7 632	11 845	2 248	918	1 330	11.5	12.0	11.2
Бэлбэсэн	41 494	7 425	34 069	4 787	913	3 874	11.5	12.3	11.4
ӨМНӨГОВЬ									
БҮГД	45 222	26 931	18 291	13 663	10 849	2 814	30.2	40.3	15.4
Огт гэр бүл болоогүй	12 092	7 930	4 162	3 619	2 931	688	29.9	37.0	16.5
Батлуулсан гэр бүлтэй	24 899	15 280	9 619	8 471	6 877	1 594	34.0	45.0	16.6
Батлуулаагүй гэр бүлтэй	4 997	2 646	2 351	1 191	806	385	23.8	30.5	16.4
Тусгаарласан	630	297	333	105	68	37	16.7	22.9	11.1
Цуцалсан	800	398	402	202	138	64	25.3	34.7	15.9
Бэлбэсэн	1 804	380	1 424	75	29	46	4.2	7.6	3.2

ХҮСНЭГТ 4.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМД СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн идэвх	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид						
				тоо			хувь			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
УЛСЫН ДҮН										
БҮГД	1 905 969	937 271	968 698	285 665	144 359	141 306	15.0	15.4	14.6	
Эдийн засгийн идэвхтэй	1 075 780	590 132	485 648	149 696	88 800	60 896	13.9	15.0	12.5	
Ажил эрхэлдэг	911 664	495 101	416 563	126 849	76 204	50 645	13.9	15.4	12.2	
Ажил хайж байгаа	164 116	95 031	69 085	22 847	12 596	10 251	13.9	13.3	14.8	
Эдийн засгийн идэвхгүй	830 189	347 139	483 050	135 969	55 559	80 410	16.4	16.0	16.6	
УЛААНБААТАР										
БҮГД	871 860	414 935	456 925	168 504	81 176	87 328	19.3	19.6	19.1	
Эдийн засгийн идэвхтэй	452 255	243 208	209 047	71 523	41 417	30 106	15.8	17.0	14.4	
Ажил эрхэлдэг	391 523	207 521	184 002	60 074	34 853	25 221	15.3	16.8	13.7	
Ажил хайж байгаа	60 732	35 687	25 045	11 449	6 564	4 885	18.9	18.4	19.5	
Эдийн засгийн идэвхгүй	419 605	171 727	247 878	96 981	39 759	57 222	23.1	23.2	23.1	
ӨМНӨГОВЬ										
БҮГД	45 222	26 931	18 291	13 663	10 849	2 814	30.2	40.3	15.4	
Эдийн засгийн идэвхтэй	33 794	22 061	11 733	12 598	10 405	2 193	37.3	47.2	18.7	
Ажил эрхэлдэг	29 652	19 507	10 145	11 804	9 907	1 897	39.8	50.8	18.7	
Ажил хайж байгаа	4 142	2 554	1 588	794	498	296	19.2	19.5	18.6	
Эдийн засгийн идэвхгүй	11 428	4 870	6 558	1 065	444	621	9.3	9.1	9.5	

**ХҮСНЭГТ 4.2 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХГҮЙ
ХҮН АМД СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ,
АЖИЛ ЭРХЛЭЭГҮЙ ШАЛТГААН, ХҮЙСЭЭР, 2010 ОН**

Эдийн засгийн идэвхгүй хүн ам	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
УЛСЫН ДҮН									
БҮГД	830 189	347 139	483 050	135 969	55 559	80 410	16.4	16.0	16.6
Сургуульд сурдаг	300 494	136 696	163 798	79 237	33 358	45 879	26.4	24.4	28.0
Тэтгэвэрт	191 907	65 745	126 162	14 194	4 744	9 450	7.4	7.2	7.5
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	55 888	31 256	24 632	3 927	2 142	1 785	7.0	6.9	7.2
Гэрийн ажилтай	108 403	12 122	96 281	15539	1 557	13 982	14.3	12.8	14.5
Тохирох ажил олдохгүй байгаа	121 519	71 856	49 663	13544	7 758	5 786	11.1	10.8	11.7
Ажиллах сонирхолгүй	3 283	2 321	962	343	230	113	10.4	9.9	11.7
Бусад	48 695	27 143	21 552	9185	5 770	3 415	18.9	21.3	15.8
УЛААНБААТАР									
БҮГД	419 605	171 727	247 878	96 981	39 759	57 222	23.1	23.2	23.1
Сургуульд сурдаг	177 974	80 417	97 557	63 285	27 336	35 949	35.6	34.0	36.8
Тэтгэвэрт	85 279	29 671	55 608	9 524	3 070	6 454	11.2	10.3	11.6
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	22 636	12 685	9 951	2 387	1 275	1 112	10.5	10.1	11.2
Гэрийн ажилтай	58 050	6 335	51 715	9 533	1 041	8 492	16.4	16.4	16.4
Тохирох ажил олдохгүй байгаа	47 215	27 924	19 291	7 113	4 132	2 981	15.1	14.8	15.5
Ажиллах сонирхолгүй	1 598	1 126	472	203	136	67	12.7	12.1	14.2
Бусад	26 853	13 569	13 284	4 936	2 769	2 167	18.4	20.4	16.3
ӨМНӨГОВЬ									
БҮГД	11 428	4 870	6 558	1 065	444	621	9.3	9.1	9.5
Сургуульд сурдаг	2 952	1 439	1 513	182	92	90	6.2	6.4	5.9
Тэтгэвэрт	3 480	1 157	2 323	94	38	56	2.7	3.3	2.4
Хөдөлмөр эрхлэх чадваргүй	741	423	318	50	31	19	6.7	7.3	6.0
Гэрийн ажилтай	1 592	198	1 394	304	35	269	19.1	17.7	19.3
Тохирох ажил олдохгүй байгаа	1 683	1 061	622	190	107	83	11.3	10.1	13.3
Ажиллах сонирхолгүй	87	65	22	16	10	6	18.4	15.4	27.3
Бусад	893	527	366	229	131	98	25.6	24.9	26.8

ХҮСНЭГТ 4.3 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД
СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ,
АЖИЛ МЭРГЭЖИЛ, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Ажил мэргэжил	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид						
				Тоо			Хувь			
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
УЛСЫН ДҮН										
БҮГД	911 664	495 101	416 563	126 849	76 204	50 645	13.9	15.4	12.2	
Менежер	72 187	41 090	31 097	9 520	5 858	3 662	13.2	14.3	11.8	
Мэргэжилтэн	153 919	53 224	100 695	25 579	10 397	15 182	16.6	19.5	15.1	
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	40 454	15 405	25 049	6 899	3 079	3 820	17.1	20.0	15.3	
Контор, үйлчилгээний ажилтан	23 725	6 657	17 068	3 927	1 325	2 602	16.6	19.9	15.2	
Худалдаа, үйлчилгээний ажилтан	134 236	53 308	80 928	19 326	8 844	10 482	14.4	16.6	13.0	
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	236 308	135 595	100 713	15 913	9 259	6 654	6.7	6.8	6.6	
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	85 047	63 209	21 838	16 892	13 822	3 070	19.9	21.9	14.1	
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	79 717	73 970	5 747	13 356	12 648	708	16.8	17.1	12.3	
Энгийн ажил мэргэжил	68 650	36 652	31 998	11 184	6 984	4 200	16.3	19.1	13.1	
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	17 421	15 991	1 430	4 253	3 988	265	24.4	24.9	18.5	
УЛААНБААТАР										
БҮГД	391 523	207 521	184 002	60 074	34 853	25 221	15.3	16.8	13.7	
Менежер	48 533	27 319	21 214	5 230	3 168	2 062	10.8	11.6	9.7	
Мэргэжилтэн	89 124	33 611	55 513	11 636	4 852	6 784	13.1	14.4	12.2	
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	22 071	8 488	13 583	3 284	1 186	2 098	14.9	14.0	15.4	
Контор, үйлчилгээний ажилтан	13 383	3 471	9 912	1 811	582	1 229	13.5	16.8	12.4	
Худалдаа, үйлчилгээний ажилтан	85 154	36 283	48 871	13 274	6 214	7 060	15.6	17.1	14.4	
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	4 065	2 544	1 521	1 173	727	446	28.9	28.6	29.3	
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	52 762	38 742	14 020	10 217	8 066	2 151	19.4	20.8	15.3	
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	40 149	37 354	2 795	5 477	5 099	378	13.6	13.7	13.5	
Энгийн ажил мэргэжил	30 587	14 712	15 875	6 711	3 785	2 926	21.9	25.7	18.4	
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	5 695	4 997	698	1 261	1 174	87	22.1	23.5	12.5	
ӨМНӨГОВЬ										
БҮГД	29 652	19 507	10 145	11 804	9 907	1 897	39.8	50.8	18.7	
Менежер	1 459	990	469	645	506	139	44.2	51.1	29.6	
Мэргэжилтэн	3 218	1 503	1 715	1 705	1 101	604	53.0	73.3	35.2	
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	1 436	769	667	737	522	215	51.3	67.9	32.2	
Контор, үйлчилгээний ажилтан	710	291	419	303	156	147	42.7	53.6	35.1	
Худалдаа, үйлчилгээний ажилтан	2 416	786	1 630	666	352	314	27.6	44.8	19.3	
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	7 899	4 295	3 604	340	199	141	4.3	4.6	3.9	
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	3 754	3 471	283	2 871	2 791	80	76.5	80.4	28.3	
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	5 203	5 096	107	3 348	3 318	30	64.3	65.1	28.0	
Энгийн ажил мэргэжил	2 888	1 695	1 193	951	743	208	32.9	43.8	17.4	
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	669	611	58	238	219	19	35.6	35.8	32.8	

ХҮСНЭГТ 4.4.1 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД
СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
УЛСЫН ДҮН									
БҮГД	911 664	495 101	416 563	126 849	76 204	50 645	13.9	15.4	12.2
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	241 017	139 428	101 589	16 642	9 819	6 823	6.9	7.0	6.7
Уул уурхай, олборлолт	48 897	39 223	9 674	11 585	9 952	1 633	23.7	25.4	16.9
Боловсруулах үйлдвэрлэл	63 391	33 586	29 805	10 599	6 306	4 293	16.7	18.8	14.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	14 257	10 770	3 487	1 516	1 179	337	10.6	10.9	9.7
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	6 451	3 794	2 657	659	473	186	10.2	12.5	7.0
Барилга	58 517	46 704	11 813	14 611	12 774	1 837	25.0	27.4	15.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоцикийн засвар үйлчилгээ	117 040	51 077	65 963	15 661	7 597	8 064	13.4	14.9	12.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	52 681	42 059	10 622	7 786	6 619	1 167	14.8	15.7	11.0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	28 446	6 315	22 131	5 269	1 147	4 122	18.5	18.2	18.6
Мэдээлэл, холбоо	13 646	7 206	6 440	1 698	951	747	12.4	13.2	11.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	15 841	6 083	9 758	2 831	1 109	1 722	17.9	18.2	17.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7 689	3 390	4 299	1 271	567	704	16.5	16.7	16.4
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	10 498	5 142	5 356	1 359	680	679	12.9	13.2	12.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	12 276	8 779	3 497	2 496	1 930	566	20.3	22.0	16.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	74 581	49 269	25 312	12 885	9 123	3 762	17.3	18.5	14.9
Боловсрол	79 552	21 318	58 234	11 175	2 965	8 210	14.0	13.9	14.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	35 710	6 981	28 729	4 256	918	3 338	11.9	13.1	11.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	8 463	4 628	3 835	1 068	582	486	12.6	12.6	12.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	19 285	8 092	11 193	2 795	1 271	1 524	14.5	15.7	13.6
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	683	182	501	176	40	136	25.8	22.0	27.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2 743	1 075	1 668	511	202	309	18.6	18.8	18.5

ХҮСНЭГТ 4.4.2 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД
СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
УЛААНБААТАР									
БҮГД	391 523	207 521	184 002	60 074	34 853	25 221	15.3	16.8	13.7
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5 374	3 468	1 906	1 398	887	511	26.0	25.6	26.8
Уул уурхай, олборлолт	19 323	15 851	3 472	3 213	2 724	489	16.6	17.2	14.1
Боловсруулах үйлдвэрлэл	41 881	21 670	20 211	7 641	4 479	3 162	18.2	20.7	15.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	7 335	5 426	1 909	638	505	133	8.7	9.3	7.0
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3 537	2 041	1 496	399	295	104	11.3	14.5	7.0
Барилга	40 147	31 486	8 661	8 540	7 193	1 347	21.3	22.8	15.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	77 811	36 040	41 771	11 290	5 763	5 527	14.5	16.0	13.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	30 340	23 386	6 954	3 227	2 664	563	10.6	11.4	8.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	19 482	4 750	14 732	3 963	848	3 115	20.3	17.9	21.1
Мэдээлэл, холбоо	10 613	5 656	4 957	1 219	712	507	11.5	12.6	10.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	9 487	3 778	5 709	1 264	556	708	13.3	14.7	12.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	7 079	3 146	3 933	1 221	545	676	17.2	17.3	17.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	6 316	3 182	3 134	761	392	369	12.0	12.3	11.8
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	8 516	6 295	2 221	1 635	1 334	301	19.2	21.2	13.6
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	32 063	19 873	12 190	4 103	2 921	1 182	12.8	14.7	9.7
Боловсрол	33 950	9 016	24 934	4 651	1 303	3 348	13.7	14.5	13.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	17 184	3 122	14 062	1 994	398	1 596	11.6	12.7	11.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	5 440	3 141	2 299	621	361	260	11.4	11.5	11.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	13 168	5 284	7 884	1 841	814	1 027	14.0	15.4	13.0
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	556	149	407	157	34	123	28.2	22.8	30.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1 921	761	1 160	298	125	173	15.5	16.4	14.9

ХҮСНЭГТ 4.4.3 АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮН АМД
СҮҮЛЧИЙН 5 ЖИЛД ШИЛЖИН ИРЭГЧДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙСЭЭР, 2010 ОН

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд			Сүүлчийн таван жилд шилжин ирэгчид					
				тоо			хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
ӨМНӨГОВЬ									
БҮГД	29 652	19 507	10 145	11 804	9 907	1 897	39.8	50.8	18.7
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	8 027	4 363	3 664	346	202	144	4.3	4.6	3.9
Уул уурхай, олборлолт	5 216	4 299	917	3 210	2 818	392	61.5	65.6	42.7
Боловсруулах үйлдвэрлэл	660	377	283	210	163	47	31.8	43.2	16.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	562	468	94	252	219	33	44.8	46.8	35.1
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	118	78	40	43	40	3	36.4	51.3	7.5
Барилга	4 495	4 201	294	3 866	3 710	156	86.0	88.3	53.1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1 632	652	980	300	160	140	18.4	24.5	14.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2 618	2 437	181	1 787	1 704	83	68.3	69.9	45.9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	615	130	485	165	48	117	26.8	36.9	24.1
Мэдээлэл, холбоо	146	76	70	39	21	18	26.7	27.6	25.7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	314	104	210	117	34	83	37.3	32.7	39.5
